



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ




“ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙ

Гарын авлага

*Энэхүү гарын авлагыг Хууль зүйн яатнаас хэрэгжүүлж буй
Дэлхийн банкны “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах”
төслийн хүрээнд боловсруулав.*



Улаанбаатар хот
2013 он

DDC
340.11
X-758

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙ
Гарын авлага

Гарын авлага боловсруулсан баг:

Зөвлөх: Д. Зүмбэрэлхам (Ph.D)

Боловсруулсан: Л.Мөнхсайхан (Ph.D)
Ж.Наранцацрал (MA)
М.Батсуурь (MA)

Хэвлэлийн хуудас: 11.4

Цаасны хэмжээ: B5

Хэвлэсэн тоо: 1200

Хэвлэсэн газар: “BCI” Хэвлэлийн компани

ISBN 978-99962-56-63-9



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ, ОЮУТАН НАРТ



Монгол Улсын Засгийн газрын Хууль зүйн салбараа шинэчлэх санаачлагыг анхлан дэмжсэн хандивлагчдын тоонд Дэлхийн банк зүй ёсоор ордог билээ. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2002-2008 онуудад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн хүрээнд эрх зүйн шинэтгэлийн чухал хэсэг болох Эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, чанарыг олон улсын түвшинд нийцүүлж, сайжруулах ажлын эхлэл тавигдсан юм. Тухайлбал, “Эрх зүйн дээд боловсролын Монгол Улсын стандарт”-ын анхны хувилбар, түүний дагуу 31 хичээлийн жишиг хөтөлбөр, эдгээрээс 14 хичээлийн оюутанд зориулсан гарын авлага зэргийг боловсруулж, сургалтын арга барилыг шинэчлэхэд чиглэсэн ажлууд хийгдсэн. Эдгээр хөтөлбөр, гарын авлагыг 2007-2008 онд эрх зүйч бэлтгэдэг бүх их, дээд сургуулиудын оюутнуудын хүртээл болгосон.

2009 оноос Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж эхэлсэн “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд дээрх ажлын үргэлжлэл болох оюутанд зориулсан нийт 20 гаруй хичээлийн гарын авлага боловсруулах ажил хийгдэж байна. Энэ ажлыг хууль зүйн салбарын нэр хүндтэй, туршлагатай эрдэмтэд, багш нар болон идэвх, санаачлагатай залуу багш нараас бүрдсэн нийт 60 орчим хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэж байна.

*Төслийн зохицуулагч
Большорлоогийн Сафантаяа*

ҮР ДҮНД ЧИГЛЭСЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Боловсрол судлаачид болон багш нар сургалт явуулах үзэл баримтлалыг боловсруулахдаа хоёр янзын хандлагыг баримталж байна. Нэг дэх нь илүү уламжлалт хэлбэрийнх бөгөөд агуулгад чиглэсэн баримтлалыг дагадаг байхад хоёр дахь нь үр дүнд анхаардаг. Агуулгад чиглэсэн хандлагаар бол сургалтын агуулгыг тухайн шинжлэх ухааны мэдлэг, ойлголт тодорхойлдог. Харин үр дүнд чиглэсэн хандлага нь мэдлэгт анхаарахаас гадна суралцагчдын ур чадвар, хандлага үнэт зүйлсийн хөгжилд анхаардаг.

1990-ээд оноос хийсэн эрх зүйн шинэчлэлт нь хууль зүйн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгохыг шаардсан юм. Хууль зүйн яам, Дэлхийн банкны “Хууль зүйн үйлчилгээг сайжруулах” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг дэмжих” дэд төслийн боловсруулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагын шинэлэг тал нь:

- Агуулгад суурилсан хөтөлбөрөөс агуулга, үр дүнд суурилсан хөтөлбөр боловсруулсан.
- Зорилго, хүрэх үр дүнг тодорхой болгосон.
- Онолын мэдлэгийг эзэмшүүлэхийг зорихоос гадна мэргэжлийн чадвар эзэмшүүлэх, үнэт зүйлсийн төлөвшилд нь нөлөөлөх зорилго тавьсанд оршино.

*Төслийн зөвлөх
Ухнаагийн Туяа (Ph.D)*

ЗОХИОГЧИД



Дорждамбын Зүмбэрэлхам

1979-1984 онд ОХУ-ын Мөрдөн байцаагчийн дээд сургууль (хуульч), 1996-2000 онд МУИС-ийн доктрантур, Япон Улсын Хирошимагийн сургууль, Хонг Конгийн их сургууль, Мелбурнын их сургууль, Макс Планкийн институт, Төв Европын их сургуулиудад мэргэжилдээшлүүлсэн. 1984-1989 онд Өмнөговь аймгийн Цагдан сэргийлэх ангид жинхэнэ болон ахлах мөрдөн байцаагч, 1989-1992 онд Улсын Мөрдөн байцаах газарт ахлах мөрдөн байцаагч, албаны дарга, 1992-1995 онд Цагдаагийн Академидахлах багш, сургалтын албаны дарга, дэд захирал, 2000-2005 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд Гэмт явдал судлалын секторын эрхлэгч, 2005-2009 онд Монгол Улсын ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, 2009-2013 онд МУ-ын Төрийн албаны зөвлөлийн даргаар тус тус ажилласан.



Хулуд овгийн Лхагваагийн Мөнхсайхан

1988 онд ОХУ, Волгоград хот дахь Мөрдөн байцаагчийн Дээд сургуулийн бакалавр, 2004 онд мөн хотноо Хуулийн академийн магистрантур, 2011 онд “Монгол Улсын эрүүгийн шүүн таслах ажиллагааг талуудын эрх тэгш байдал, мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчим, түүний эрх зүйн зохицуулалтын асуудлууд” (CRLA 303) сэдвээр хууль зүйн ухааны доктор (Ph.D) - ын зэрэг хамгаалсан,

Говь Алтай аймгийн Цагдаагийн хэлтэс, УМБГ-ын 2-р хэлтэс, Нийслэлийн БЗД-ийн прокурорын газар, УЕПГ, Дархан-Уул, Завхан аймгийн прокурорын газар, ХХААЯ зэрэг байгууллагуудад мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, хяналтын прокурор, орлогч прокурор, аймгийн прокурор, сайдын зөвлөх зэрэг алба хашиж, 2000 оноос Орхон ИС, Улаанбаатар-Эрдэм ДС, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” (USAID), Дэлхийн банкны “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Монголын хүний нөөцийн институт зэрэг боловсролын байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа багш, өмгөөлөгч.



Жадамбын Наранцацрал.

Эрх зүйч, 1999 онд Монгол Улсын Их сургуульд хууль зүйн ухааны магистрийн зэрэг хамгаалсан. 1989-1992 онд Говь-Алтай аймгийн Хууль зүйн зөвлөгөө өгөх газарт хуулийн зөвлөх, 1993-1997 онд Говь-Алтай аймгийн сум дундын шүүхэд шүүгч, 1998 оноос Улаанбаатар, Отгонтэнгэр Их сургуульд багш, 2004-2011 онд МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч, 2004 оноос Монголын Нотариатчдын танхимын гишүүн, нотариатч. Нийт дангаараа болон бусадтай хамтран 11 ном, сурах бичиг, илтгэл, эрдэм шинжилгээний 16 өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгосон.



Мишигийн Батсуурь

Эрх зүйн магистр, 2001-2003 онд “M&P” компанид хуулийн зөвлөх, 2011-2003 онд МУИС, Хууль зүйн сургуульд Захирлын туслах, 2003-2009 онд МУИС, Хууль зүйн сургуульд багш, 2009-2011 онд Монголын Өмгөөлөгчдийн холбоонд өмгөөлөгч, 2008-2009 онд “Легал полиси” ХХК-ийн захирал, 2009-2011 онд Худалдаа хөгжлийн банкны Хуулийн газрын захирал, 2009 оноос хойш Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр ажиллаж байгаа. Олны хүртээл болгон 1 ном, 1 гарын авлага, Орчуулсан болон редактороор ажилласан бүтээл 2, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл 40 орчмыг тус тус хэвлүүлсэн.

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ХУУЛЬЧ МЭРГЭЖИЛ БА МЭРГЭШИЛ. НИЙГМИЙН ӨМНӨ ХУУЛЬЧДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

1.1. Удиртгал 11

Агуулга:

Хуульч мэргэжлийн тухай ойлголт

Хуульч мэргэжлийн онцлог, үйл ажиллагааны эрх зүйн үндэс

Хуульчийн мэргэшлийн тухай ойлголт

АНУ-ын Барын систем

1.2. Нийгмийн харилцаанд хуульчийн гүйцэтгэх үүрэг,
хүлээх хариуцлага 15

Агуулга:

Хуульчийн мэргэжлийн хариуцлагын талаар судлахын ач холбогдол

Нийгмийн өмнө хуульчдын хүлээх хариуцлага

Өмгөөлөгчийн чиг үүрэг, ёс зүйн шаардлага

Прокурорын чиг үүрэг, ёс зүйн шаардлага

Шүүгчийн чиг үүрэг, ёс зүйн шаардлага

II БҮЛЭГ. ЁС ЗҮЙН ТОЙРОГ БА ҮНЭТ ЗҮЙЛС

2.1. Ёс зүйн тойрог ба үнэт зүйлс 22

Агуулга:

Ёс суртахуун ба ёс зүйн тухай ойлголт

Эрх зүй ба ёс зүйн харилцан уялдааны тухай ойлголт

Нийгмийн ёс зүйн тойрог, үнэт зүйлс, ёс зүйн хүрээ, түүнийг тодорхойлох тойргууд

Категорик императив, релятивизм, утилитаризмын үндэслэл, туйлчлах онол

Нийгэм, хувь хүн, хуульчийн мэргэжлийн ёс зүйн гурван тойргийн онолоор ёс зүйн хүрээг тодорхойлох нь

Хуульчийн ёс зүйн ойлголт



2.2. Ёс зүйн шаардлага 29

Агуулга:

Сайн, муу, үнэн, худал, шударга, хүнлэг ёс, зан үйл, нэр төр, хүлцэн тэвчихүйн тухай ойлголтууд
Ёс зүйн шаардлагын тухай ойлголт,
Нийтлэг ба тусгай шаардлага, тэдгээрийн уялдаа
Ёс зүйн шаардлагаас зайлсхийх хандлагууд
Хуульчийн ёс зүйн шаардлагын тухай ойлголт
Хуульчийн ёс зүйн шаардлагын төрлүүд
Харилцагчаас тавигдах ёс зүйн шаардлага
Байгууллагаас тавигдах ёс зүйн шаардлага
Мэргэжлийн ёс зүйд хамт олны нөлөөлөл

2.3. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм 38

Агуулга:

Дүрмийн талаар ойлголт
Хуульчийн ёс зүйн шаардлагууд мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд баталгаажиг ирсэн хөгжил
Хуульчийн ёс зүйн хэм хэмжээнд баримтлах зарчмууд
Хуульчийн мэргэжлийн ёс зүйг эрх зүйгээр хэм хэмжээчлэх шаардлага, ач холбогдол
Хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн ач холбогдол
Ёс зүйн хэм хэмжээг эрх зүйгээр журамлах сул талууд
Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн ялгаатай байдлын тухай ойлголт

2.4. Өмгөөлөгчийн ёс зүйн тухай ойлголт 44

Агуулга:

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн тухай ойлголт
Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм
Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ ба зарчим
Өмгөөллийн үйл ажиллагаатай холбогдох ёс зүй
Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүй
Өмгөөлөгч гуравдагч этгээдийн харилцааны ёс зүй
Өмгөөллийн нууцтай холбоотой ёс зүй
Өмгөөллийн явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх арга зам

2.5. Прокурорын ёс зүй..... 53

Агуулга:

- Прокурорын ёс зүйн тухай ойлголт
- Прокурорын ёс зүйн дүрэм
- Прокурорын ёс зүйн хэм хэмжээ ба зарчим
- Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн хэм хэмжээ
- Хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн хүрээнд баримтлах ёс зүйн хэм хэмжээ
- Хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх

2.6. Шүүгчийн ёс зүй..... 58

Агуулга:

- Шүүгчийн ёс зүйн тухай ойлголт
- Шүүгчийн ёс зүйн дүрэм
- Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ ба зарчим
- Шүүгчийн биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ
- Шүүн таслах ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ
- Шүүн таслах ажиллагаанаас гадуур баримтлах ёс зүйн хэм хэмжээ
- Улс төрийн үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн хязгаарлалт
- Шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх

III БҮЛЭГ. ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

3.1. Ашиг сонирхлын зөрчилдөөн 71

Агуулга:

- Нийгмийн болон мэргэжлийн ёс зүйн тойргоос үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилдөөн
- Ашиг сонирхлын зөрчилдөөний хувилбарууд
- Ёс зүйн ба ёс зүйн бус асуудлуудын тухай ойлголт
- Дилемма буюу ацан шалаа, түүнээс гарах боломжууд

3.2. Хуульчийн ёс зүйн зөрчил 75

Агуулга:

- Ёс зүйн зөрчлийн тухай ойлголт
- Ёс зүйн зөрчил ба эрх зүйн зөрчил, тэдгээрийн ялгаатай болон нийтлэг тал
- Мэргэжлийн алдаа ба ёс зүйн зөрчлийн тухай ойлголт, тэдгээрийн онцлог



Ёс зүйн зөрчлийн онцлог
Ёс зүйн зөрчлийн төрөл, хэлбэр
Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн зөрчлүүд

IV БҮЛЭГ. ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА БА ЁС ЗҮЙН ХЯНАЛТ

4.1. Хуульчийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт84

Агуулга:

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт
Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлага ба шударга ёс
Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын төрлүүд
Хуульчдад нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлага
Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн хариуцлагын төрөл

4.2. Ёс зүйн хяналт.....89

Агуулга:

Мэргэжлийн ёс зүйн хяналтын тухай ойлголт
Хяналт тавих боломж
Хяналтыг хэрэгжүүлэх арга зам
Албан ба албан бус хяналт
Олон нийтийн хяналт, үр нөлөө, ач холбогдол
Мэргэжлийн байгууллагын хяналт, үр нөлөө, ач холбогдол
Мэргэшлийн институтын хяналт, үр нөлөө, ач холбогдол
Боловсон хүчний өөрчлөлт, шинэчлэлт, ач холбогдол
Ёс зүйн хяналтын хүрээ, хязгаар

4.3. Ёс зүйн хариуцлага хүлээлгэх процедур99

Агуулга:

Ёс зүйн хариуцлага хүлээлгэх процедурын тухай ойлголт
Сахилгын хэрэг, түүнийг үүсгэх үндэслэл
Хариуцлага хүлээлгэх институт: Сахилгын хороо, ёс зүйн зөвлөл
Хариуцлага хүлээлгэх институтын бүтэц, зохион байгуулалт
Институтын эрх хэмжээ, гишүүний бүрэн эрх
Хэргийг хянан шийдвэрлэх журам
Шийдвэрийн тухай ойлголт
Гомдол гаргах институт ба гомдол гаргах хугацаа

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

дд	Бүлэг	Сэдэв	цаг
1	Хуульчийн мэргэжил ба мэргэшил. Нийгмийн харилцаанд хуульчийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	Удиртгал	2
		Нийгмийн харилцаанд хуульчийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага	2
2	Ёс зүйн тойрог ба үнэт зүйлс	Ёс зүйн тойрог ба үнэт зүйлс	4
		Ёс зүйн шаардлага	2
		Мэргэжлийн ёс зүйн дүрэм	2
		Өмгөөлөгчийн ёс зүйн тухай ойлголт	4
		Прокурорын ёс зүйн тухай ойлголт	4
		Шүүгчийн ёс зүйн тухай ойлголт	4
3	Хуульчийн ёс зүйн зөрчил	Ашиг сонирхлын зөрчилдөөн	4
		Хуульчийн ёс зүйн зөрчил	2
4	Хуульчийн ёс зүйн хариуцлага ба ёс зүйн хяналт	Хуульчийн ёс зүйн хариуцлагын тухай ойлголт	2
		Ёс зүйн хяналт	2
		Ёс зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагаа	2
НИЙТ ЦАГ			40



I БҮЛЭГ.

ХУУЛЬЧ МЭРГЭЖИЛ БА МЭРГЭШИЛ. НИЙГМИЙН ӨМНӨ ХУУЛЬЧДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Бүлгийн зорилго: *Хуульчийн мэргэжил, мэргэшлийн тухай онолын мэдлэгийг бататгах.*

СЭДЭВ.1.1. УДИРТГАЛ

Сэдвийн зорилго: *Хуульчийн мэргэжлийн тухай ойлголт, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, онцлог, хуульчийн мэргэшлийн талаар цэгцтэй мэдлэгтэй болгох, мэргэжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвшихөд оршино.*

НЭР ТОМЬЁО:

- Хуульч
- Хуульчийн үүрэг
- Бар
- Өмгөөлөгч
- Прокурор
- Шүүгч

Хуульчийн мэргэжлийн тухай ойлголт, онцлог, нийгэмд гүйцэтгэх үүрэг

Нийгмийн хөгжилд мэдлэг, боловсрол, ёс суртахуунтай мэргэжилтнүүд хэрэгтэй байдгаас онцгой байр суурь эзэлдэг нь **хуульч** юм. Тухайлбал, Үндсэн хуулийн (19) “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд хуульчдын дэмжлэг, туслалцаа, зайлшгүй хэрэгцээтэй бөгөөд хуульч мэргэжил нь зөвхөн төрийн салбарт ч биш, нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны зэрэг амьдралын бүх хүрээнд хэрэгцээтэй, эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй, дэлхийн улсуудын хамгийн түгээмэл нэр хүндтэй мэргэжил мөн.

Хуульч бол эрх зүйн мэргэжлийн боловсрол эзэмшсэн, энэхүү мэдлэгээ практик үйл ажиллагаандаа хэрэглэх мэргэшил, ур чадварын шаардлага хангасан хүн бөгөөд 2007 оноос “Хуульчийг сонгон шалгаруулах журмын тухай” хууль мөрдөгдсөнөөр “хуульч” болон “сонгон шалгаруулалт” гэсэн нэр томъёог дараах байдлаар ойлгох болсон. Үүнд:

- **сонгон шалгаруулалт /3.1.1/ гэдэг нь мэргэжлээрээ 2 -оос доошгүй жил ажилласан бэлтгэлтэй эрх зүйч хуульч шүүгчийн албан тушаалтаны шалгаруулалтад орох,**
- **өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах мэргэжлийн шалгалтад оролцох,**
- **прокуророор ажиллах этгээдийн мэргэжлийн хангалттай мэдлэг чадвар эзэмшсэн эсэхийг шалгаж гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэхийг хэлнэ.**

“ХУУЛЬЧ” НЬ

Хууль зүйн их, дээд сургуульд суралцаж эрх зүйч мэргэжил эзэмшсэн эрх зүйч бөгөөд

“Хуульчийг сонгон шалгаруулах журмын тухай хууль”-ийн 3.1.2-д зааснаар **хуульч** - сонгон шалгаруулалтад орж тэнцсэн гэрчилгээ авсан этгээд.

2013 оноос мөрдөгдөх “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 3.1.1-д зааснаар **хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд.**

ХУУЛЬЧ МЭРГЭЖИЛ

Төрт ёсыг бэхжүүлэх, хууль хэрэгжүүлэх, эрх тэгш, шударга ёсыг хангах, гэмт үйлдэл, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, иргэдийн эрх зүйн мэдлэг, хүмүүжлийг дээшлүүлэх, байгууллага, хүмүүст хууль зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, нийгмийн амгалан тайван байдлыг хангах, эрх ашгийг нь хамгаалах **эрхэм зорилготой.**

Төрийн албыг ёс жаягаар нь явуулах, хууль хэрэгжүүлэхэд тусалдаг бөгөөд хуульчийн мэргэжлийн үүрэг нь иргэн төр, нийгэмтэйгээ харилцах эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг нь хамгаалах, сэргээхэд чиглэгддэг.

Хуульч мэргэжил дотроо шүүгч, прокурор, өмгөөлөгч гэсэн 3 төрөлд хуваагдана.



Хуульчдын эрх зүйн байдлын хувьд:	<p>Шүүгчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “шүүгч” гэж “хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдсон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг хэлнэ” гэж заасан.</p>
	<p>Прокурорын эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хуульд “прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасан бол Прокурорын байгууллагын тухай хуульд “1-рт, захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд тавих прокурорын хяналт, 2-рт, эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд тавих прокурорын хяналт, 3-рт, гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт, 4-рт, ял эдлүүлэх шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт, 5-рт, прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох, 6-рт, прокурор иргэний болон бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох” гэж прокурорын эрх хэмжээг ангилсан.</p>
	<p>Өмгөөлөгч (өмгөөлөл - латинаар advocatus буюу урих, уриалах) - хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэн. Өмгөөлөгч нь шүүн таслах ажиллагаа болон нийгмийн бусад харилцаанд оролцож буй иргэнд ямар нэг байдлаар үүсэн бий болсон асуудлыг хууль зүйн үүднээс зохицуулах талаар түүний хүсэлтээр мэргэжлийн зөвлөгөө өгч, эрх зүйн туслалцаа үзүүлж, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалдаг. Өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуульд (55) “шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй, шүүгдэгч энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэшлийн туслалцаа үзүүлнэ” гэж тодорхойлсон.</p>

Шүүгч, прокурор, өмгөөлөгч нь нийгэмд гүйцэтгэх чиг үүргээрээ ялгагддаг, мэргэшсэн шинжтэй, үйл ажиллагааны өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой, мэргэжлийн ёс зүйн нийтлэг болон тусгай шаардлагатай, үйл ажиллагаандаа баримтлах нийтлэг болон тус тусын мөрдөх зарчмуудтай байдаг.

Хуульч мэргэжлийн онцлог: Нийгмийн амьдралын хүрээнд эмч, инженер, эдийн засагч, химич, физикч, биологич гэх мэт өөр, өөрийн чиг үүрэг бүхий мэргэжилтнүүд үйл ажиллагаа явуулж, чухал үүрэг гүйцэтгэдэг ч **хуульч шиг төрийн нэрийн өмнөөс хууль хэрэглэн хүнийг цагдан хорих, баривчлах, мөрдөх, яллах, шийтгэх, албадлага хэрэглэх зэргээр эрх, эрх чөлөөнд хуулийн хүрээнд халдах төр, эрх зүйн статус /онцгой эрх/ эдлэхгүй учир хуульчид төр, нийгмийн өмнө онцгой хариуцлага хүлээдэг онцлогтой. Түүний дотор **прокурорын ажлын онцлог** шүүн таслах ажиллагаанд төрийг төлөөлөн оролцоход оршдог бол **шүүгчийн ажил** нь шүүн таслах ажиллагааны цөм хэсэг буюу хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх цэг болдог онцлогтой.**

Монгол улс шүүх эрх мэдлийн байгуулагуудаас иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаатайгаар хангах хэрэгжүүлэх, шударга ёсыг тогтооход хуульчдыг нэгтгэх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр хэрэгжүүлэх, хуульчдын мэргэжлийн нэгдсэн тогтолцоог эрхэмлэж, тэдний мэргэжлийн нэр хүнд, хариуцлагын тогтолцоог ханган хэрэгжүүлэх зорилгоор “Хуульчдын эрх зүйн байдлын тухай” хуулийг 2012 онд баталсан бөгөөд одоо хэрэгжиж эхлэх гэж байгаа нь үндсэндээ АНУ-ын “Бар” - ын системийн туршлагад тулгуурласан юм.

АНУ-д “Бар”-ын систем нь хуулийн сургууль төгсөөд тодорхой хугацаагаар ажилласны дараа **“Бар”-ын гэх тусгай шалгалт** өгч тэнцсэн нь мэргэжлийн хуульч болдог шалгууртай бөгөөд **“Барын нэгдсэн холбоо”** гэдэг нь муж улсын шүүхийн шүүн таслах ажиллагаанд оролцох эрх олгох буюу лиценз олгох зохион байгуулалтын бүтэц юм.

Зохион байгуулалттай “Бар”-ын систем нь хууль эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход чухал бөгөөд хуульч мэргэжилтнийг ажиллуулах, хөгжүүлэх замаар практикийн хуульчдын дунд өрсөлдөөн бий болгож, мэргэжлээ дээшлүүлэхийг шаардаж, үнэнч шударга байдлыг хангаж, шударга бус болон итгэл алдах байдлыг цээрлүүлдэг. “Бар”-ын холбооны үзэл баримтлал нь бүх шүүгч, өмгөөлөгч, прокурорыг “Бар”-ын холбооны гишүүн байхыг шаардахаас гадна холбооны дүрэм, журам, ёс зүйн дүрэмд захирагдахыг шаарддаг.

Холбооны бус нэгдмэл бүтэцтэй, нэгдмэл шүүхийн тогтолцоотой Монгол улсад хуульч мэргэжлээрээ ажиллах хүсэл сонирхолтой хэн бүхэн заавал нэгдэж түүнд харьяалагдаж байхыг шаардсан Барын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх нь Монгол улсын иргэдийн эрх чөлөөг хамгаалан хангахад тус дэм болох хамгийн төгс систем байх юм” гэж АНУ-ын Азийн институтын захирал Жой Спурлок /Техасын Веслайн хууль зүйн их сургууль/ - ын хэлсэн нь ийнхүү хэрэгжих гэж байна.



ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хуульч гэж хэн бэ?
- Ардчилсан, эрх зүйт нийгэмд түүний гүйцэтгэх үүргийг тодорхойлно уу.
- Хуульч мэргэжлийн бусад мэргэжилтэй төстэй болон ялгарах шинж нь юу вэ?
- Барын тогтолцооны талаар та юу мэдэх вэ?
- Шүүн таслах ажиллагаан дээр өмгөөлөгч, прокурор, шүүгчийн чиг үүрэг?

СЭДЭВ 1.2. НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ХУУЛЬЧДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Сэдвийн зорилго: *Хуульчийн мэргэжлийн хариуцлагын тухай ойлголт, түүний ач холбогдол, төрлүүдтэй танилцан, ёс зүйн тухай цэгцтэй мэдлэгтэй болох, мэргэжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвшихөд оршино.*

НЭР ТОМЬЁО:

- Хуульчийн мэргэжлийн хариуцлага
- Өмгөөлөгчийн чиг үүрэг
- Прокурорын чиг үүрэг
- Шүүгчийн чиг үүрэг

Хуульчийн мэргэжлийн хариуцлагын талаар судлахын ач холбогдол

Хуульчийн ёс зүй, мэргэжлийн хариуцлагатай холбоотой хууль, дүрмийг судлах нь зөвхөн хуулийн чиглэлээр суралцагч оюутнуудын хувьд төдийгүй хуульчдад “үүрэгт ажлаа зохих ёсоор нь гүйцэтгэж дадах”-д нэн чухал ач холбогдолтой.

Энд өөрийгөө хамгаалахаас гадна шүүх засаглалын тогтолцооны нэр хүндийг унагахгүй байх асуудал ч яригдана.

Хууль зүйн их, дээд сургуульд суралцан хуульч болох гэж байгаа хүний хувьд, тухайн хүний хувийн шинж чанарын ихэнх хувийг ард түмний хууль зүйн хэрэгцээ шаардлагад үйлчлэх үүрэг хариуцлага болон энэ үүргээрээ бахархах бахархал эзлэх учиртай. Ийм үзэл бодолтой хүний хувьд хуульч

хүний мэргэжлийн хариуцлагын асуудлын хүрээ, жишиг нь **“сонсоод мартах, хараад санах, хийгээд ойлгох”** гэж үг байдагчлан сонсох төдийгөөр сурчих зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Урьд нь тогтсон жишгийг өөриймшүүлж дагаж мөрдөх нь мэдээж боловч тогтсон жишиг, тогтолцоонд шүүмжлэлтэй хандаж, сайжруулах арга замыг байнга эрэлхийлж байх чадвар, эерэг хандлагыг өөртөө төлөвшүүлэхийн тулд суралцах хэрэгтэй.

Ийм чадвартай хуульч энгийн үйлчлүүлэгчтэйгээ болон бусад хуульчидтайгаа харилцахад хялбар байх бөгөөд энэ хандлага нь хуульчдад итгэх итгэл үнэмшлийн суурь болдог. Жишээлэхэд, хуульчийн ёс зүйн хувьд Японы хуульчид дэлхийд бахархагддаг билээ.

Хуульчийн мэргэжлийн хариуцлага гэсэн ойлголтод ёс зүйн үүрэг, хариуцлага, хүн чанар, нэр төр, амьдралын утга учир, хүний жаргал, зовлон гэх зэрэг олон асуудал хамаардаг. Хуульчийн алдааны төлөө хүмүүс хэтэрхий өндөр үнэ төлөх учраас хуульч туйлын хариуцлагатай, ёс зүйтэй байх нь чухал. Нийгэм, олон нийт ч ийм байгаасай гэж хүсэж байдаг

Ард олны хувьд **найдвартай шүүх засаглал** гэж дараах 3 нөхцөлийг агуулсан хуулийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх боломжтой нийгэм, шүүхийн тогтолцоог хэлдэг:

Шударга

Ойлгомжтой

Шуурхай

Хэрэв хууль, шүүхийн тогтолцоо нь хүмүүсийн эрх ашгийн эсрэг ажиллах, эсхүл ийнхүү ажиллаж байгаа мэт ойлгогдвол хууль тогтоомж хүмүүсийн эрх чөлөөг хангах арга хэрэгсэл байхаа болих учир хуульчийн ёс зүйн асуудал хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэглүүр гэж хэлж болно. Хуульчид ямар ч хамаагүй үнээр хуулийг улс төрийн явуургүй зорилгод гуйвуулахаас хамгаалах ёстой. Энэ бол нийгмийн бусад гишүүдийн өмнө хүлээсэн тэдний зүй ёсны үүрэг” (эрх зүйн онолын эрдэмтэн Х.Келзен)

“Үүрэг нь хувь хүнээс бусдын өмнө болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт. Үүргээ ухамсарлах нь хүн өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаандаа ямагт бодолтой, ухаалаг хандахад нөлөөлдөг” /Сенека Младший/ гэсэн байдаг бол академич Ж. Амарсанаа “Шүүгчийн ёс зүйн асуудлаар тавьсан илтгэл” - дээ “Зураач муу зураг зурсан бол түүнийг



хэн ч худалдан авахгүй, зохиолч тааруухан зохиол бичсэн бол хэн ч уншихгүй тул зураач, зохиолч өөрсдөө л эдийн засгийн хохирол хүлээхээс биш өөр хэн ч хохирохгүй. Харин хуульч, шүүгч хэзээ ч тийм гологдол гаргах ёсгүй” гэж дурьдсан байх бөгөөд **хуульчийн мэргэжлийн хариуцлагын гол зангилаа бол эрх мэдэл дор хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх явдал** учир өөрт олгогдсон эрх мэдлээрээ өөртөө давуу байдал олгох зүй бус шийдвэр гаргах бус шударга ёсыг сахигч байх ёстой. Иймд төр эрх зүйн тусламжтайгаар шударга ёсны наад захын түвшнийг хадгалах, хуульчдыг ёс зүйтэй байлгах, нийгэмд шударга ёсыг тогтоон төлөвшүүлэх нь чухал.

Шударга ёсны талаар эртний сэтгэгч Сократ “шударга ёс бол бусдад үйлдэх буян”, “сайн хүн гэж шударга хүнийг хэлнэ”, “сайн хүн шударга бусыг үйлдэхгүй”, Платон “Төр” зохиолдоо: “шударга ёс алтнаас үнэтэй, түүн шиг буян гэж үгүй, шударга бус шиг муу, муухай юм гэж байхгүй”, “шударга ёс бол агуу их баялаг” гэсэн байдаг бол Францын хаан Напельон “шударга байх нь хамгийн сайн бодлого юм”, Гельвиция “хувь хүмүүсийн үйлдэл нийтийн сайн сайханд нийцэх нь шударга ёс” гэж тус тус тодорхойлсон байна.

“Шударга ёс” гэдэг бол нийгмийн хөгжил дэвшлийн шаардлага, ард олны ашиг сонирхол хүсэл эрмэлзлэл, үнэнийг эрхэмлэх ёс, тэгш эрхийн зарчмыг тусгасан ухагдахуун бөгөөд

“Шударга ёс” нь хүн нийгмийн харилцаанд бодитой, зохистой хандах зүй ёсны шаардлага. Өөрөөр хэлбэл, шударга ёс нь хүний хувийн ашиг, сонирхлыг бусдын, нийгмийн ашиг сонирхолтой уялдуулах, нийтлэг чиг шугамд үндэслэгдсэн эрх зүйн зарчим юм.

Өмгөөлөгч байцаан шийтгэх ажиллагаанаас гадуурх харилцаанд **шударга байх үүрэг хүлээх эсэхийн тухайд** гэвэл, өмгөөлөгч олон нийтийн өмнө нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх үүрэг хүлээх бөгөөд гуравдагч этгээд, бүр цаашилбал нийгмийн өмнө үнэнч байх үүрэг хүлээдэг. Хэрэгт холбогдогчийн шударга байх үүрэгт дурьдагдсан **“шударга” гэдэг үгний агуулга** нь объектив бус субъектив шинж чанартай болно. Өөрөөр хэлбэл өмгөөлөгч нь хуульчийнхаа хувьд ёс зүй, ухамсрын үндсэн дээр “бодит үнэн” гэж итгэж буй зүйлийг хэлэх бөгөөд шүүх өмгөөлөгчийн үнэн хэмээн итгэж мэдүүлсэн, хамгаалсан зүйлийн эсрэг дүгнэлт гаргалаа ч тэр даруй “өмгөөлөгч шударга байх үүргээ зөрчсөн” гэж хариуцлага тооцохгүй.

Өмгөөлөгч нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шударга байх үүрэг хүлээхийн зэрэгцээ үйлчлүүлэгчийн өмнө үнэнч байх, нууц хадгалах үүргийг хүлээдэг.

Манай өнөөгийн нөхцөлд хуульчдыг ёс зүйтэй байлгахын тулд тэдний ажил, мэргэжлийн онцлогт тохирсон, үйл ажиллагааныхаа хүрээнд дагаж мөрдөх дүрэм хэрэгтэй учир шүүгч, прокурор, өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тавигдах шаардлагыг шүүгч, прокурор, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмээр тусгайлан хэм хэмжээчилдэг ба зөрчсөн хуульчид сануулах, албан тушаал, зэрэг дэв бууруулах, ажлаас халах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гэх мэт сахилгын хариуцлага хүлээлгэдэг.

Хариуцлагатай байх нь хуульчийн хараат бус байдлын тулгын чулуу бөгөөд хариуцлагаа ухамсарласан хуульч өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг тул хариуцлагын дархлааг өөртөө бий болгохын тулд хичээх ёстой. Хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах ёстой ч бүрэн төгс боловсрогдсон ёс зүйн дүрэм гэж үгүй тул дүрмийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байх нь зүйтэй.

Хүн эрх, үүргээ хэрхэн ухамсарлах, үйл ажиллагаандаа ямар сэтгэлээр хандах нь “ёс зүй” - тэй холбоотой. Хуульчид шударга ёсыг тогтоохын тулд “ёс зүй” - тэй байх, үүний тулд сэтгэхүй, оюун ухаанаа өөрчлөн, шаардлагатай бол хуучин арга барилаасаа ангижирч, ёс зүйн үнэт зүйлсийг эрхэмлэх сурах ёстой.

Ёс зүйтэй хуульч байхын тулд:

Олж мэдсэн зүйлээ ашиглаж чаддаг байхыг хэлэх тул мэдлэгтэй байх хэрэгтэй. Үүний тулд мэдлэгийг өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд “зайлшгүй болон мэдэх хэрэгтэй, мэдэхэд илүүдэхгүй” байдлаар нь ангилан өөрийгөө хөгжүүлэх,

Бодлоо хянаж, аливаа сайн зүйлийг болох, бүтэх талаас нь эргэцүүлэн бодож сурах,

Хандлага нь мэдлэг, чадвар хоёрыг амьдралд зөв хэрэглэхэд туслах тул аливаа юм болон хүнд сайн сайхан, эерэг талаас нь хандах хандлагыг өөртөө төлөвшүүлэх. Өөрөөр хэлбэл, эерэг бодол, мэдрэхүй, үйлдэлд дадах.

Хүн өөртөө агуулж, өдөр тутам харьцаж байдаг эд хөрөнгө, цаг хугацаа, нэр хүнд, эрүүл мэндийн ач холбогдол, агуулгыг ойлгож, зан үйл буюу бодол сэтгэлээ өөрчлөх.

Мэдлэгээ хэрэглээ болгох чадвараа хөгжүүлэх.

Эцэст нь өөрийн ажиллаж, амьдарч буй нийгмийн хүрээнд бүрэлдэн тогтсон нийтлэг ёс зүйн сэтгэлгээ, тэрчлэн тухайн хувь хүний үнэт зүйлстэй салшгүй хуульчийн ёс зүй буюу нийгмийн зүгээс өөрт нь тавьж буй тусгай шаардлагыг дагаж мөрдөж хэвших хэрэгтэй.



Хуульчид нийгмийн өмнө мэргэжлийн үйл ажиллагаагаа хувийн сонирхлоос зааглаж, хүний эрхийг хамгаалан хангах үүрэг хүлээснийхээ хувьд хариуцлагатай байх, хувь хүнийхээ зан байдлыг хянах үүрэг ноогддог нь ёс зүйн хувьд тавигдах шаардлагаар хангагддаг. Тухайлбал,

Өмгөөлөгчийн чиг үүрэг, ёс зүйн шаардлага: “Хууль цаазын ажлын чухал бүрэлдэхүүн хэсэг, өмгөөлөгч нь хүний хөндөгдсөн эрхийг хууль зүйн үүднээс сэргээн тогтоож, хамгаалах үүрэгтэй, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч, эрх зүйч” гэж мэргэшлийг нь тодорхойлох өмгөөлөгчдөд тавигдах ёс зүйн шаардлагыг “Өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” - д

- Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхдээ баримтлах нийтлэг хэм хэмжээ,
- Мэргэжил нэгтэнтэйгээ харилцахдаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ,
- Үйлчлүүлэгчтэйгээ харилцахдаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ,
- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчидтой харилцахдаа баримтлах ёс зүйн хэм хэмжээ гэхчлэн ангилсан.

Өмгөөлөгч хэргийг ашигтайгаар шийдүүлнэ гэж амлах, өмгөөллийн ажиллагааны хэмжээнд тохирохгүй өндөр хөлс нэхэх, өөр шан авахаар дарамтлах, үйлчлүүлэгчтэй архи дан согтуурах, зүй бус харилцаа тогтоох, үйлчлүүлэгчээр өөрийн хувийн ажил хөөцөлдүүлэх, өмгөөлж буй асуудлынхаа хүрээнд хуулийн байгууллагын ажилтнуудтай холбоо тогтоох, гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй, хэрэг шийдэгдээгүй байхад урьдчилсан дүгнэлт хийж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тараах, бусдыг үндэслэлгүйгээр гутаах зэргээр өмгөөллийн мэргэжлийн нэр хүндэд харш үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг.

Прокурорын чиг үүрэг, ёс зүйн шаардлага: “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох эрх бүхий, прокурорын байгууллагад томилогдон ажиллаж буй, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой төрлийн хуулийн биелэлтэд хяналт тавих үндсэн үүрэгтэй, хууль ёсыг сахиулагч, хуульч” прокурор нь (procurator - лат. анхаарал тавих, хангах, зайлуулах) гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, дахин гаргуулахгүй байхад үйл ажиллагаагаа чиглүүлдэг.

Прокурор үйл ажиллагаагаа явуулахдаа удирдлага болгох зарчим:

- Хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах
- Хуулийг хүндэтгэн дээдэлж, чанд сахин биелүүлэх
- Прокурорын байгууллагын нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх
- Прокурор гадны нөлөөнд үл автах
- Хуулийг нэг мөр хэрэглэх
- Прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгах зарчмыг удирдлага болгох

Тухайлбал, прокурор хяналтын чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх, хэргийн оролцогч, өмгөөлөгчтэй харилцахдаа ялгавартай байдал гаргахгүй хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга зөв шийдвэрлэж чадахуйц мэдлэг, харилцааны соёлтой байх, прокурорт хандаж гаргасан гомдол, хүсэлт, мэдээлэлд анхааралтай хандаж шуурхай шийдвэрлэх, ойр дотны харилцаатай хүмүүс, өмнө нь ажиллаж байсан, эрх ашгийг нь ямар нэгэн хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэний хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй байх үүрэгтэй.

Дээрх үүргээ эс биелүүлж, хэргийн оролцогч, өмгөөлөгч, бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа аашилж зандах, айлган сүрдүүлэх, догшин хэрцгий харилцах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргах, хувийн сонирхлын үүднээс харьяаллын бус, бусдын хяналтад байгаа хэрэг материалтай танилцах, зөвлөгөө өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавих, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож дарамт шахалт үзүүлэх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах, саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэрэг материалын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэх юм бол хариуцлага хүлээнэ.

Шүүгчийн чиг үүрэг, ёс зүйн шаардлага: Шүүгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зохих шатуудаар дамжуулан шалгасан хэргийг тал бүрээс нь нягтлан, шүүхээр шийдвэрлэх эрх зүйн үндэслэлийг тогтоон, зохих журмыг баримтлан шүүх хуралдаанаар хэлэлцүүлсний эцэст гаргах шийдвэр нь хэрэг, маргааны хууль зүйн шийдэл юм.

Эрүү, иргэн, захиргаа, хөдөлмөр, гэр бүл, байгаль орчны зэрэг олон талын харилцааг хамаарсан хэрэг, маргааныг шүүгдэгч, хариуцагчийн үйлдэл, эс үйлдлийн гэм буруу, учруулсан хохирлын хэмжээ, хоорондын шалтгаант холбоо, шүүгчдэгч, хариуцагчийн хувийн байдал, уг хэрэг, маргаан гарахад нөлөөлсөн хүчин зүйлийг харгалзан хэрэг, маргааны талаар эцсийн шийдвэр гаргах шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг “Шүүгчийн ёс зүйн дүрэм” - д нь:



“биеэ авч явах ёс зүй, мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах буюу шүүн таслах ажиллагаанд тавигдах, хэргийн оролцогчтой харилцахад тавигдах, шүүхийн захиргааны удирдлагын хүрээн дэх шүүгчийн ёс зүй, шүүн таслах ажиллагаанаас гадуур баримтлах, бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд, шүүгчийн үндсэн чиг үүргээс гадуур үйл ажиллагаа эрхэлсний орлоготой холбоотой, улс төрийн үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлагууд болон бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах журам мөрдөх, нууц хадгалах, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх, шударга байх үүрэг гэж ангилсан ба зөрчвөл хүлээх хариуцлага, хариуцлага хүлээлгэх процедурыг “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” - д нь тодорхойлсон байдаг.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хуульчийн мэргэжлийн хариуцлага гэж юу вэ?
- Хуульчдыг өндөр хариуцлагатай байлгах нийгмийн шалтгаан нь юу вэ?
- Хуульчдын мэргэжлийн хариуцлагын ямар төрлүүд байдаг вэ?
- Хуульчийн ёс зүй гэж юу вэ?

II БҮЛЭГ.

ЁС ЗҮЙН ТОЙРОГ БА ҮНЭТ ЗҮЙЛС

Бүлгийн зорилго: Ёс суртахуун ба ёс зүй, нийгмийн ёс зүйн тогтолцоо ба мэргэжлийн ёс зүйн тогтолцооны тойргууд, тэдгээрийн хүрээ хязгаар, тойргуудад халаарах ёс зүйн үнэт зүйлс, хоорондын харилцан уялдаа, ашиг сонирхлын зөрчилдөөний талаарх мэдлэгтэй болох, мэргэжлийн үйл ажиллагаандаа хуульчийн ёс зүйн үүднээс дүн шинжилгээ хийх чадвар эзэмших, мэргэжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвшихөд оршино.

2. I. НИЙГМИЙН ЁС ЗҮЙН ТОЙРОГ, ҮНЭТ ЗҮЙЛС, ЁС ЗҮЙН ХҮРЭЭ, ТҮҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ ТОЙРГУУД

Сэдвийн зорилго: Ёс суртахуун ба ёс зүй, нийгмийн ёс зүйн тогтолцоо ба мэргэжлийн хариуцлагын тогтолцооны тойрог, хүрээ хязгаар, тойргуудад халаарах үнэт зүйлсийн талаар мэдлэг эзэмших, эрх зүйн болон ёс зүйн асуудлаар мэргэжлийн дүн шинжилгээ хийх.

НЭР ТОМЬЁО:

- Ёс суртахуун
- Ёс зүй
- Ёс зүйн тойрог
- Нийгмийн тойрог
- Дагах тойрог
- Мэргэжлийн ёс зүйн тойрог
- Ёс зүйн үнэт зүйлс

Ёс суртахуун ба ёс зүйн тухай ойлголт

“Ёс зүй” хэмээх ойлголт нь эртний грекийн “Ethos” гэдэг үгнээс гаралтай бөгөөд хамтран амьдрах орон байр, оршин амьдрах газар гэсэн утгыг илэрхийлж байжээ. Хожим энэ ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг гэх мэт утга агуулгаар баяжиж тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлэх болсон байна.



Ёс зүй /этика/ бол нийгмийн тодорхой тогтолцоон дахь хүмүүс өөрсдийн авир үйлдэл, харилцан хамаарлыг тохируулахын тулд аяндаа сайн дураараа баримталдаг янз бүрийн хэм хэмжээний цогц, өөрөөр хэлбэл, ёс суртахууныг судлах зүйлээ болгодог философийн бүрэлдэхүүн мөн.

Нийгмийн харилцаа төлөвшин хөгжихөд зан заншил, уламжлал, улс төр, шашин, эрх зүй зэргийг ашиглаж ирсэн аж.

Ёс суртахуун (“ёс суртахуун”, “зан суртахуун” - *mos moral*, мораль) - хүмүүс өдөр тутмын амьдралын явцад өөрсдийн харилцааг сайн дурын зан аашийнхаа үндсэн дээр зохицуулж байдаг янз бүрийн хэм хэмжээний цогц юм.

Этика буюу “ёс зүй” нь тухайн шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар, мораль буюу “ёс суртахуун” нь энэхүү салбарын судлагдахуун болжээ. Ёс зүй нь зан суртахууны бодит үйл явцыг судлана. Ёс суртахууныг хүний үүсэл хөгжилтэй холбон авч үздэг бөгөөд хүн нэгэнт байгаль, нийгмийн бүтээгдэхүүн болохоор түүнд зан араншингийн шинжүүд тодорхой хэлбэрээр ил далд байдлаар оршиж, шаардлагатай тохиолдолд илрэн гарч байдаг онцлогтой. Хүн өөрийн үйлдлийн учир холбогдлыг зөв ухааран ойлгож, уур хилэн, бүдүүлэг авираа нийгмээс олж авсан соёлоороо далдлан дарж байдаг.

Ёс суртахууныг хүмүүс ямар нэг албадлагагүйгээр өөрсдөө шууд тогтоож уламжлал болгон ирсэн учраас нийгмийн харилцаанд бодитой үйлчилж хүчтэй нөлөө үзүүлдэг. “Ёс зүй” ба “ёс суртахуун” нь нийгмийн харилцаа төлөвшин хөгжих, хуучирч үеэ өнгөрөөх, үүсч бий болох, тэр нь хэрхэн батжин бэхжихэд нөлөө үзүүлдэг чухал хэрэгсэл юм.

Ёс зүйг “ёс зүйн шинжлэх ухаан бол харилцааны тухай, орших ахуйн тухай, зохицон оршихуйн тухай амьдралын утга учрын тухай гүн ухаан бөгөөд ёс зүйг онолын мэдлэгээс ангид биеэ хэрхэн авч явах тухай “практик ухаан”, “ёс зүй бол хүмүүс хоорондын харилцаа, энэ харилцаанаас үүдэн гарах “үүрэг” - ийн тухай шинжлэх ухаан юм”. /П. Гольбах 1723-1789/ гэж, мөн “хүнд юуг хийх, юунаас татгалзах хэрэгтэйг танихад /сайн, мууг ялгахад/ тусалдаг зүйл бол ёс зүй юм” /эртний гүн ухаантан Аристотель/ гэж энгийнээр тодорхойлсон байдаг бол Италийн философич Аббаямо гэгч хүн “Ёс зүй бол хүний тухай асуултуудын хариу нь байдаг” гэж тодорхой бөгөөд товч тодорхойлсон байдаг.

Ёс зүй нь нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд хүмүүс хоорондын харилцаа түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй нийгэм бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буйгаар тодорхойлогддог бол **хуульчийн ёс зүй гэдэг нь** хуульчдад олон нийтийн эрх ашиг, үүрэгт холбогдох шийдвэрийг итгэл найдвартайгаар даатгаж байгаа

үйлдлийн хэм хэмжээ, хуульч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд түүний зан үйлд нийгмийн зүгээс тавьж буй ёс суртахууны тусгай шаардлага юм.

“Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур үндэслэл” илтгэлдээ Х. Тэмүүжин : “Албаны болон мэргэжлийн ёс зүй” гэж бусдын нэрийн өмнөөс, тэдний эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулахаар эрх /эрх мэдэл/ олж авсан этгээд, эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлын дээгүүр тавьж, эл зан суртлаа албаны /мэргэжлийн/ үйл ажиллагаандаа мөрдлөгө болгохыг ойлгоно” хэмээн тодорхойлжээ.


Ёс зүйг судлах нь хүний ёсны ухааныг судалж байгаа явдал бөгөөд нэгдүгээрт, танин мэдүүлэх, хоёрдугаарт, хүмүүжүүлэх, гуравдугаарт, бүтээх ач холбогдолтой бөгөөд ёс зүйг эрхэмлэх, ёс зүйн ойлголтуудыг судалж, мэдсэнийгээ бусдад түгээх, тулгарсан асуудалд ухаалаг хариултыг олж, оновчтой шийдвэр гаргаж явах нь хүн байхын учир утга юм.

Эрх зүй ба ёс зүйн харилцан уялдааны тухай ойлголт: Ёс суртахуун нь эрх зүйгээс өмнө үүсэж нийгмийн харилцааг зохицуулж ирсэн ба “зан үйлээр дамжин амьдрал ахуйд нэвтэрч, бүрэлдэн тогтсон хувь хүний зүгээс нийгэм болон олон түмэнтэй харилцах, тэдний өмнө хариуцлага хүлээх, биеэ авч явах зэрэг олон талын харилцааг зохицуулсан хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ” буюу “бичигдээгүй хууль” юм. Нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын түвшин, амьдралын хэв маяг, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогддог бол **эрх зүй гэж** “төрөөс тогтоосон ба түүний албадлагын хүчээр хангагдан хэрэгжих, нийтээр заавал дагаж мөрдөх (позитив эрх зүй), эсхүл төр ба хуулиас дээгүүр оршин байдаг байгаль, хүний оюун ухаан, зайлшгүй шаардлагаас үүдэгдэн гардаг (жам ёсны эрх зүй) нийгмийн хэм хэмжээний (зан үйлийн журмын) тогтолцоо” - г хэлдэг. **Эрх зүй, ёс суртахуун хоёр нийгмийн харилцааг зохицуулах нийтлэг шинжтэй** ч эрх зүй нь төрөөс тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгжиж, зөрчигдөх тохиолдолд төрийн албадлага хэрэглэн, хуулийн цээрлэл хүлээж байдаг бол ёс суртахуун нь олон нийтийн сэтгэл зүйгээр илэрч тогтоогдон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгждэг.

Ёс зүйн сургаалиуд хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад янз бүрийн үзэл урсгалуудыг өөртөө багтааж хөгжиж ирсэн түүхтэй. Тухайлбал: Эртний Грекийн философийг бүхэлдээ ёс зүйн сургууль байсан, тухайлбал Грекийн ёс зүйн сургаалийн анхны том төлөөлөгч Сократын үзлээр “амьдралын утга учир бол жаргал мөн” бөгөөд /ийм үзлийг эвдемонизм гэх/ “жаргал бол сайн үйлтэй гарцаагүй холбоотой гэж үйлэнд уран, үгэнд цэцэн, эрэлхэг зориг, төлөв зан, шударга ёс”- ыг онцолсон байдаг бол Эртний Грекийн “ёс зүйн оргил” Аристотелийн хувьд “этик бол зан суртахууны тухай практик шинжлэх ухаан бөгөөд этикийн гол зорилго бол яавал сайн үйл бүхий байхыг хүмүүст сургахад оршдог” аж.



Энэтхэгийн ёс зүйн сэтгэлгээ, “буддизм”-ын ёс суртахууны сургаал нь “буян үйлдэж, зөв сэтгэж бодож явбаас энэ насандаа жаргаж, хойд насандаа ч сайн сайхныг эдлэх” гэх номлол байсан бол Хятадад Күнзийн “хариуцлагаа ухамсарладаг байх нь шударга байхын нөхцөл мөн” гэж үздэг ёс суртахууны номлол хүчтэй байсан. XIX зууны үеийн Германы сонгодог философийн төлөөлөгч И. Кант “Практик оюун ухаан бол ухаанлаг хүсэл эрмэлзлэл мөн” гэж үздэг байсан агаад “тэр нь хүмүүс хувь хүний шинж бүхий үйлдлээсээ татгалзаж, бүхэнд ач холбогдолтой, объектив, практик зарчимд захирагддаг байх ёстой” гэсэн үг мөн. “Хэрэгжүүлэх ёстой зорилгыг санал болгодог захирамж”, “заавал хэрэглэх шаардлага тавьдаг шийдмэг захирамж” гэсэн хэлбэртэй байсан тийм, өөрөөр хэлбэл, хүн үүргээ албадуулахгүйгээр биелүүлдэг байх ёстойг заадаг” зарчмыг “Кант захирамж” /императив/ гэж нэрлэсэн ба “хүн энэ хуулийн шаардлагыг биелүүлдэг байвал өөрөө өөрийгөө дээш татаж, байгалийн эрхшээлээс мултарч, хүсэл эрмэлзлийнхээ эрх чөлөөг эдэлдэг болно” гэж үздэг байжээ.



Хуулийг шинэчлэгч Философич Жэрэми Бентам “Ёс суртахуун ба хуулийн зарчмууд”-даа /1789/ “Нийгэм, улс төрийн шийдвэр нь аль болох их аз жаргалтай болоход чиглэгдэх ёстой” хэмээсэн. Ийм шийдвэрийн ёс суртахууны үнэт чанар нь аз жаргал, сэтгэл ханамжийг дагуулдаг ашигт чанар ба үр дүнтэй холбогддог аж. “Ашигт чанарыг” удирдлага болгодог нийгэмд /утилитари гэдэг нь “ашиг” гэсэн утгатай латин үг/ хувь хүмүүсийн эрх ашгийн зөрчлийг зөвхөн сэтгэл ханамжийн зарчмаар удирдлага хийсэн хууль тогтоогчид шийдвэрлэнэ.

Хүн бүрийг аз жаргалтай болгох боломжгүйгээс хойш олонхийн эрх ашгийг дээдэлж, цөөнхийг таягдахаас аргагүй” гэсэн агуулга бүхий үзэл баримтлал.

Ёс зүйн релятивист байр суурь нь “нэг хүнд үнэн зүйл нөгөө хүнд худал байж болно” гэж үздэг үзэл агаад ийм релятивист байр суурь нь зөв, буруу гэсэн ёс суртахууны баримтлалыг илэрхийлдэг ажээ.

Нийгэм, хувь хүн, хуульчийн мэргэжлийн ёс зүйн гурван тойргийн онолоор ёс зүйн хүрээг тодорхойлох нь

Чех математикч Курт Годэлийн “гурван тойргийн онол” нь ёс зүйн дүрмээр зохицуулагдахгүй асуудлыг хэрхэн ёс зүйн асуудал болгон зохицуулж болохыг харуулсан онол юм. Ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалж хуульчид ёс зүйн дүрмээр хязгаарлагдахгүйгээр илүү өргөн хүрээнд сэтгэж ёс зүйг дагаж мөрдөх хэрэгтэй болдог. К. Годэлийн нээлтээр бол “ямар ч ёс зүйн тогтолцоо бүх асуудлыг шийдэж чадахгүй. Тухайн асуудлыг шийдэж чадахгүй тогтолцоог хүчингүй тогтолцоо гэж болохгүй” гэж үзэх явдал юм.

Хуульчийн ёс зүйн сургалтад Годелийн онолыг авч үзснээр дүрмээр зохицуулагдахгүй асуудалд хуульчдыг бэлдэх замаар ёс зүйтэй байлгах нь чухал бөгөөд зөвхөн дүрмийг дагаж мөрдөхөөр хязгаарлагдахгүй байхын тулд доорх зурагт үзүүлснээр илүү их өргөн хүрээгээр сэтгэх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, ёс суртахуунтай хуульчийн хувьд дүрэм дангаараа хангалтгүй учир ажил мэргэжлийн хувьд оноогдсон үүргээ зохих ёсоор гүйцэтгэхийн тулд гурван тойргийг харгалзан үзэх ёстойг Годэлийн онол баталдаг. Үүнийг доорх байдлаар дүрсэлнэ.






- **Голын тойрог буюу хувь хүний үнэт зүйлсийг агуулсан тойрог нь хувь хүний өөрийнх зан чанар, үнэт зүйлсийг төлөөлдөг.** Энэ тойрог нь хуульчийн хувьд дагаж мөрдөх хуульчийн ёс зүйн тойргоос хэдий чинээ хол байна та төдий чинээ зөрчилтэй буюу зөвхөн хууль, дүрмийг ёсчлон биелүүлэх төдийгөөр аливаа зүйлд хандах хандлага нь тодорхойлогддог “баяр баясгалангүй” хуульч болно гэсэн үг.
- **Гуравдах буюу зарим хэсэг нь нийгмийн ёс зүйн тойргоос гадагш хальсан хэсэгтэй тойрог нь мэргэжлийн хувьд дагаж мөрдөх ёс зүйн тойрог.** Энэ тойргийн нийгмийн тойрогтой давхцахгүй илүү гарч байгаа хэсэг нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй боловч хуульч мэргэжлийн хувьд дагаж мөрдөх ёстой ёс зүйн элементүүд юм. Өөрөөр хэлбэл, нийгэм ёс бус гэж үздэг боловч хуульчийн ёс зүйд байх ёстой зүйлийг төлөөлдөг. Энэ нь хуульчийн ёс зүйн дүрэм, хуульчийн ёс зүйн үзэл бодол, тэдгээрийг тайлбарласан шийдвэр, хэм хэмжээнүүдээс бүрдэнэ. Дагаж мөрдөх тойрог хуульчийн ёс зүйн хүрээг зохих ёсоор тогтоосон байдаг ба ёс зүйн тогтолцооны үндсэн зарчмуудын ойлголт ч хамаарна.

Энэхүү онолоор **гурван тойргийн хоорондын харьцаа чухал** бөгөөд зурагт байгаа шиг харьцаа хамгийн сонгодог зөв харьцаа аж. Нийгмийн тойргоос мэргэжлийн тойрог хол байх тусам ёс зүйн тойргийн илүү гарсан хэсэг ихэсдэг тул онолын хувьд нийгэм, хамт олноос тасархай “аз жаргалгүй” хуульч гэсэн ойлголтыг бий болгодог бол нийгмийн тойрогтой давхцаж байвал шийдвэрийг хууль зүй, ёс зүйн хүрээнд биш эргэн тойрны нөлөөлөлд автаж шийдвэр гаргадаг ёс зүйгүй хуульч гэж үздэг учир зөв харьцаатай байх нь хамгийн чухал юм.

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн асуудалтай холбоотой онолын агуулгыг Америкийн “Бар”-ын Холбооны мэргэжлийн сахилгын загвар дүрмэнд *“Хуулийн мэргэжлээр ажиллахад зөрчилтэй үүрэг хариуцлага тулгардаг. Хуульчийн үйлчлүүлэгчийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, нийт эрх зүйн тогтолцооны өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, амьдрахад хангалттай мөнгө олонгоо үнэнч шударга хүн хэвээр үлдэх сонирхлын хоорондох зөрчлөөс ёс зүйн бүх хэцүү асуудал гарч ирдэг. Мэргэжлийн сахилгын дүрэм ийм зөрчлийг шийдэх нөхцөлийг тусгасан байдаг. Эдгээр дүрмийн хүрээнд мэргэжлийн эрхтэй холбоотой олон хэцүү асуудал гарч ирдэг. Ийм асуудлыг дүрмийн үндэс болсон зарчмуудыг баримтлан мэргэжлийн болон ёс суртахууны тэдрэлтэй дүгнэлт хийх замаар шийдэх ёстой”* гэж тусгасан байдаг.

Эцэст нь дүгнэхэд зөвхөн ёс зүйн дүрэм дагаж мөрдөх нь чухал биш бөгөөд эдгээр гурван тойргийн онолыг харгалзаж зөв шийдвэр гаргадаг байх ёстой гэдгийг энэ онол баталсан байдаг.

ЁС ЗҮЙН ТОЙРГИЙН ҮНДСЭН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛ ЁС ЗҮЙН ҮНЭТ ЗҮЙЛС



Хувь хүний ёс зүйн үнэт зүйлс гэдэг нь нийгэм сайн гэж хүлээж авсан, сайн сайхан үр дүн гарах, бусад хүмүүс дагаж дууриавал зохих биеэ авч явах байдал, бодол санаа, зан чанар юм. Тухайлбал: Итгэл даах чадвар, чин үнэнч харилцаа, зарчимч, найдвартай байдал, аливаад чин сэтгэлээсээ хандах, нууцыг хадгалах, эелдэг боловсон чанар, ёс журам, хүлцэл, бие даасан байдал, чадварлаг, тэсвэртэй байх, хэрсүү ухаан, ил тод, алагчлахгүй байх, халамжтай хандах, өгөөмөр сэтгэлтэй байх гэх мэт үнэт зүйлс нь ёс зүйн суурь ухагдахуун болдог төдийгүй мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний ч эх сурвалж болдог тул хуульчид ёс зүйн дүрэмд тусгагдаагүй үнэт зүйлсийг ч хувь хүнийхээ хувьд мөрдөх нь зүйтэй.

Монголчуудын хувьд нүүдэлчдийн амьдралын хэв маяг, харилцааны, ахуйн, зохицон оршихуйн, ертөнцийг үзэхүйн үнэ цэнтэй оюуны баялгийг бүтээж хойч үедээ өвлүүлэн ирсэн нь хүн өөртэйгөө, байгаль ахуйтай, хүн хүнтэйгээ харилцах ёс суртахууны соёлыг бий болгож, үүнийгээ “монгол ёс заншил”, “монгол уламжлал” гэж томьёолж ирсэн нь бидний эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс юм.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Ёс суртахуун гэж юу вэ?
- Ёс суртахуун ба ёс зүйн хоорондын харилцан хамаарлыг тайлбарлана уу.
- И.Кантын категорик императив гэж юу вэ?
- Ёс зүйн релятивизм гэж юу вэ?
- Туйлчлах онолын үндсийг тайлбарлана уу?
- Ёс зүйн талаарх утилитаризмын онолын гол онцлог?
- Нийгмийн ёс зүйн тойрогт ёс зүйн ямар үнэт зүйлс байдаг вэ? Тэдгээрийг нэг бүрчлэн ярилцана уу.
- Хуульчийн мэргэжлийн тойрогт ёс зүйн ямар үнэт зүйлсд хамаардаг вэ?



2.2. ЁС ЗҮЙН ШААРДЛАГА

Сэдвийн зорилго: Ёс зүйн тойргуудаас үүдэн ёс зүйн шаардлага, шаардлагын төрлүүдийн талаар мэдлэгтэй болгох, ёс зүйн шаардлагыг үнэлэх тэргээжлийн чадвар эзэмшүүлэх.

НЭР ТОМЬЁО:

- Ёс зүйн шаардлага
- Ёс зүйн шаардлагын төрөл
- Сайн, муу
- Хүнлэг ёс
- Нэр төр
- Үүрэг
- Хүлцэн тэвчихүй
- Шударга ёс

Сайн, муу, үнэн, худал, шударга, хүнлэг ёс, зан үйл, нэр төр, хүлцэн тэвчихүйн тухай

Ёс зүй нь хүний нийгмийн хөгжлийн зүй тогтлоор бий болсон өдөр тутмын бичигдээгүй хууль болон тогтсон хамгийн нийтлэг түгээмэл сайн чанаруудыг илэрхийлэх агаад хүн хүнтэйгээ харилцах харилцааг зохицуулахаас гадна хүмүүсийн биеэ авч явах хэм хэмжээг тодорхойлдог учир ёс зүйг дур зоргоороо өөрчилж болдоггүй. Ёс зүй, ёс суртахуун нь нийгмийн үнэт чанар ерөнхий зарчмын үүднээс хүмүүсийн зан чанарын байдлыг үнэлж байдаг.



Иймээс ёс суртахууны үнэлэлтийг сайн, муу хэмээх ерөнхий ойлголтод нэгтгэн бататгасан үзэл бодол, төсөөлөл байдаг. Нийгэм хүмүүсийг ийм ёс зүйтэй байхыг шаардаж, ийм ёс суртахууныг хүн нийгэм дундаас төлөвшүүлдэг.

Сайн, муу гэдэг бол ёс зүйн ухаанд суурь ойлголт болсоор ирсэн бөгөөд хүмүүсийн үйл амьдралын зохистой, зохисгүй шинж чанар, хандлагын тухай анхны ойлголт юм. Сайн муугийн утганд амьдралын хүн ёсны эрхэмлэл, цээрт ёсны утга багтдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүний амьдралд нийцтэйг эрхэмлэх, нийцгүйг жигших ухаан юм.

Харин **шударга ёсны ухагдахуунд** бодит байдал, үнэн бөгөөд зүй ёсны харилцаа гол утга нь болдог. Шударга ёс алдагдахад бодит үнэнийг үгүйсгэх, зүй бусыг зөвтгөх хандлага бий болно.

Үнэнч шударга гэж юу вэ гэвэл үнэнч гэдэг нь ямар нэг юмны байсан байдал, байх ёстой зүйлийг тэр хэвээр нь илэрхийлж, бодол санаа, үг хэл хоёроо ямар ч зөрчилгүй байлгахыг хэлнэ. Үнэнч шударгын тухай бидний өвөг дээдэс “үнэнээр явбал өдөр бүр түвшин, хуурамч явбал өдөр бүр түгшүүр” хэмээн сургасан байдаг.

Шударга зан бол үнэн явдлыг шулуун цайлган, илэн далангүй илэрхийлэх явдал мөн. Үнэнч шударга, зөв шулуун зан бол ямар ч нөхцөлд зарчимч байр суурин дээрээ зогсож түүнээс ухрахгүй хулчийхгүй байх явдал бол, худал, хуурмаг, бөөрөнхий, зориггүй, зусар, бялдууч, авилгач зан нь сөрөг зан авир юм. Ийм зан авир, мөхөс ухаантай хүний амьдрах арга нь явган заль байдаг.

Нэр төр гэдэг ойлголт ёс суртахууны бусад ойлголтуудын нэг адил нийгмийн харилцааны өөрчлөлттэй уялдан агуулга, хэлбэр нь хувиран өөрчлөгдсөөр ирсэн. Энэ нь **“хүний хувийн эрхэм чанар, хүн өөрийн нийгэмд эзлэх байр сууриа ухамсарлаж байгаа байдал, нөгөө талаас тэрхүү үнэ цэнийг нийгмийн зүгээс үнэлж байгааг, нийгмийн зүгээс бие хүнийг үнэлэх үнэлэмжийг илэрхийлдэг”**. Өөрөөр хэлбэл, хүний үнэ цэнийг нийгэм, хамт олон, найз нөхөд, гэр бүл бодитойгоор хүлээн зөвшөөрч буйг нэр төр гэнэ. Нэр төрийг олох амаргүй, алдах нь амархан. Архичин болох, бусдыг гомдоох, өөрийн бодолгүй бусдыг дуурайх, найз нөхдөө аюул зовлонд орхих, арга саам хайх, зусарч байх, хулгай хийх зэрэг нь нэр төрөө гутаах шалтгаан болно. Нэр төрөө хүн өөрөө л унагадаг байна.

Амьдралын утга учир нь ёс суртахууны үнэт зүйл болдог учир сайн, муугийн болон, шударга ёс, хүлээсэн үүргийн тухай зөв эргэцүүлэн амьдралынхаа утга учрыг тодорхойлох ёстой. Амьдралын утга учир бол хүний амьдралын үйл ажиллагааны чиглэл бөгөөд зан суртахууны үнэлэмжтэй шууд холбоотой. Н.А Бердяев “Бид амьдралын утга учир юунд байдгийг мэдэхгүй, харин түүнийг хайж олох нь амьдралын утга учир юм” гэсэн байдаг. Амьдрал утгаа алдах нь хүнийг, ёс суртахууныг оюун санааны талаар эвдэж сэтгэлийн хямрал, өвчлөлд хүргэдэг.

Ёс зүйн шаардлагын тухай ойлголт

Бид өмнө дурьдсан ёс зүйн тойргуудын харилцан хамаарлын хүрээнд авч үзвэл нийгмийн тойрогт хамаарах үнэт зүйлс нь **ёс зүйн нийтлэг шаардлагыг илэрхийлэх** агаад нийгмийн хүрээн дэх ёс зүйн сэтгэлгээг хүн нийгэм дунд амьдрахдаа үе тэнгийнхэн, гэр бүлийн орчин, уран зохиол, урлаг, шашин шүтлэг



туршлагаас сурсан, тогтоосон байдаг. Харин нийгмийн гишүүн хувь хүнийхээ хувьд зан суртахууны хувьд төлөвшсөн үнэт зүйлстэй. Энэ нь сэтгэл хөдлөл, уур бухимдал, атаа хорсол, аймхай хулчгар, эр зориг, энэрэнгүй, нинжин сэтгэл, өрөвч зан гэх мэт хүний өөрийнх нь мөн чанарыг илэрхийлэх үнэлэмж байдаг.

Ёс суртахууны нийтлэг шаардлагад “хүнлэг, энэрэнгүй байх, бусадтай харилцахдаа хүндэтгэлтэй, соёлтой байх, ажилч хичээнгүй байх гэх мэт шаардлагууд хамаардаг бол мэргэжлийн ёс зүйд - эрхэлсэн ажил, албан тушаал, байгууллагынхаа нэр төрийг эрхэмлэх, үнэнч шударга байх, үүрэг, хариуцлагаа ухамсарлах” гэх мэт шаардлагууд хамаарна.

Хувь хүнийг ийн төлөвшүүлэх нь ёс суртахууны нийтлэг шаардлага бол ажил, мэргэжлийн онцлог, хариуцлагын хүрээнд тавигддаг тусгай шаардлага байдаг. Тухайлбал: Хуульчдад нийгмийн ёс зүйгээс шууд хамаарах шударга байх, хууль дээдлэх, хуулийг нэг мөр хэрэглэх гэх мэт шаардлага нь тусгай шаардлага юм.

Ёс зүйтэй байхад шаадлагатай зан чанар /үнэт зүйлс/:

- Хувиа үл хичээх
- Сэтгэлийн тэнхээ
- Тэвчээр, хатуужил
- Хөдөлмөрч, шургуу зан.
- Ёс зүйн хамгийн чухал үнэт зүйл бол **эр зориг**.

Ёс зүйн цөм тойрог буюу нийгмийн ёс зүйн тойрогт байдаг хувь хүний өөрийнх нь мөн чанар мэргэжлийн хүрээнд дагаж баримтлах үнэт зүйлстэй зөрчилдөж, ацан шалаанд орсноор ёс зүйн бус асуудал тулгарах нь бий. **Жишээ нь**, Прокурор Х-гийн хөршийнх нь хүүхэд гэмт хэрэгт холбогдсон ба тэрээр мөрдөн байцаалтад шалгагдаж байгаа тул хөрш нь прокурорынхоор орой орж ирж хүүгээ харж үзэхийг гуйжээ. Прокурор энэ тохиолдолд ямар сонголт хийх вэ гэвэл ёс зүйгээ баримтлах иргэний **эр зориг** л хэрэгтэй.

Ёс зүйн шаардлагаас зайлсхийх хандлагууд, түүнээс хэрхэн зайлсхийх: Ёс зүйн бус асуудал гэдэг нь “зөв, буруу” гэдэг дээр үндэслээгүй, “аюулгүй байдал, эрүүл мэнд, хайр дурлал, өш хонзон, уур бухимдал, гэмшил, өрөвдөх, шунал, ахиж дэвших хүсэл, тачаал” гэх мэт хүний нөлөөтэй бодол санаа юм. Ёс зүйн бус асуудлууд нь “хараат бус, биеэ даасан, аль нэг талыг бариагүй гэж болох шийдвэрийг ёс зүйн бус зорилго руу чиглүүлэх” гэх мэт далд хор хөнөөлтэй. Иймээс хуульчид ёс зүйн шийдвэр гаргахдаа эдгээр зарчим шийдвэрийн аль талд, хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг үнэлж дүгнэн, аль болох зөв гарцыг олох ёстой.

Тулгарах ёс зүйн асуудалд бэлэн байх, түүнийг үүсгэгч нөхцөл байдлаас зайлсхийх, тэдгээрийг шийдэх чадвартай байх ёстой. Үүний тулд нийгмийн ёс зүйн тойрог буюу цөм тойрогт байх хувь хүний өөрийгөө зөвтгөх шалтгуудаас өөрийгөө чөлөөлөх нь чухал.

Хувь хүний өөрийгөө зөвтгөх шалтгууд олон байдгаас төлөөлүүлж авч үзвэл:

- “Хүн бүр л ингэдэг шүү дээ”
- “Тэд эхлээд ингэсэн”
- “Надад өөр сонголт алга”
- “Тэмцэхээс өөр аргагүй”
- “Гэм хоргүй бол зөрчил биш”
- “Хэн ч энэ тухай мэдэхгүй”

АНУ -ын профессор Жак Маршалл “Үнэт зүйлсийг ёс зүй болгох нь” лекцэндээ “Тулгарах асуудалд бэлэн байж, ёс зүйн шатрын дараах нүүдлийг хийх нь хуульчдыг ёс зүйтэй байхад нөлөөлнө. Үүнд:

- Ёс зүйн урхинд орохоос болгоомжил.
- Ёс зүйн талаар өдөр бүр бод.
- Таны биеэ авч явах байдал бусдад нөлөөлнө гэдгийг сана.
- Дүрмээ байнга унш.
- Хэний өмнө үүрэг хүлээж байгаагаа тодруул.
- Эргэлзвэл тусламж хүс.
- Бодлогыг ёс зүйтэй бүү хольж хутга.
- Сэтгэл хөдлөлийг ёс зүйтэй бүү хольж хутга.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Ёс зүйн шаардлагыг тодорхойлно уу?
- Ёс зүйн тойргуудад ёс зүйн ямар шаардлагууд байх талаар ярилцана уу.
- Ёс зүйн шаардлагын төрлүүдийг нэг бүрчлэн ярилцана уу.
- Ёс зүйн шаардлагаас зугтах хандлагуудын талаар тайлбарлана уу?



ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ШААРДЛАГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хуульчийн ёс зүй гэдэг нь хуульч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд түүний зан үйлд нийгмийн зүгээс тавьж буй ёс суртахууны тусгай шаардлага бөгөөд мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд нь түүний зан үйлд нийгмийн зүгээс болон албаны зүгээс тавьж буй тусгай шаардлагууд, дотоод хийгээд гадаад хүчин зүйлээс урган гардаг, хуульч хүн бүрт байх ёстой үнэт зүйлсийн тогтолцоо юм.

Хуульчдад нийгмийн зүгээс /гадаад хүчин зүйлс/ дараах шаардлагыг тавьдаг. Үүнд:

Тэгш хандах, ялгаварлахгүй харилцаж, нэр төрийг нь хүндэтгэх

Шударга байх

Хүнлэг байх

Албан тушаал, эрх мэдлээ урвуулж, хэтрүүлэхгүй байх

Аливаа асуудалд бодитой хандах

Бусдын нууцыг задруулахгүй байх

Мэргэжлийн нэр хүнд, ажил албан тушаалын хувьд /дотоод хүчин зүйлс/ дараах нийтлэг шаардлагыг тавьдаг. Үүнд:

Бие даасан, хараат бус байх
Байгууллагынхаа нэр төрд сөв суулгахгүй байх

Хууль дээдлэх

Мэргэжлийн өндөр ур чадвартай байх

Харилцан ойлголцох, хүндэтгэлтэй хандах, итгэлцэх

Ажил, албан тушаалдаа хүндэтгэлтэй хандах

Хуульчид мэргэшлийн ёс зүйн нийтлэг шаардлагыг НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ний 34/169 - р тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-иар тавьсан. Үүнд:

- Хуулиар хүлээсэн үүргээ байнгын өндөр хариуцлагатай биелүүлэх
- Үүргээ биелүүлэхдээ хүний нэр төрийг хүндэтгэж, хүний эрхийг хамгаалах, дэмжих
- Гарцаагүй тохиолдолд үүргээ биелүүлэхэд л шаардагдах хэмжээгээр албадлага хэрэглэх

- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харилцах аливаа үйлдэл хийх, өдөөн хатгах, ийм үйлдэлд эвлэрэнгүй хандахгүй байх
- Авилгын шинжтэй үйлдэл хийж болохгүй бөгөөд үүний эсрэг тэмцэх
- Саатуулагдагчийн эрүүл мэндийг хамгаалах, тусламж үзүүлэх арга хэмжээ авах
- Хууль ёсыг болон энэ дүрмийг хүндэтгэх үүрэгтэй гэж тус тус заажээ.

Олон улсын эрх зүйн зохицуулалтын хүрээнд түүнчлэн 1990 оны 8 сарын 27-ноос 9 сарын 7-нд Кубын Гавана хотноо хуралдсан НҮБ-ийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаар хуралдсан 8-р их хурлаас баталсан “Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд”, 1985 онд Италийн Милан хотноо хуралдсан НҮБ-ийн 7-р их хурлаас баталсан “Шүүхийн хараат бус байдлын үндсэн зарчмууд, 1990 онд Кубын Гавана хотноо хуралдсан НҮБ-ийн 8-р их хурлаас баталсан “Яллагчдын үүргийн удирдах зарчмууд”, Олон улсын Барын холбооны стандарт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн пакт, Эдийн засаг, соёлын эрхийн тухай Олон улсын пакт болон хүний эрхтэй холбоотой Олон улсын гэрээ конвенцуудад тус тус тусгасан байдаг.

Хуульчид хүний амьдралын ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэхдээ ухаалаг, шударга, хүмүүнлэг хандахыг нийгэм шаарддаг бөгөөд одоогоор Монгол Улсын хуульчдын тухайд нийтлэг шаардлагыг зохицуулсан зохицуулалт одоогоор байхгүй ч 2003 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабанди: “Хуульчдад хандсан санамж бичигт” “Эрх зүйч мэргэжлийн нэр төрийг эрхэмлэн дээдлэх, хуульч гэсэн алдар нэрийг ариун байлгах, төрийн тусгай албаны онцлог үүргийг шударгаар биелүүлэх” ёстойг дурьдаад “Хуульч нийгэмд биеэ зөв авч явах, бусадтай эелдэг зөв боловсон харилцах, хэнд ч хүмүүнлэг хандах, төлөв төвшин, ухаалаг байхаас хуулийн байгууллага, хамт ажиллагсдын нэр хүнд шууд хамаарахыг ямагт санаж, өөрийн зан үйлдээ байнга хяналт тавьж байх, ажлын байранд, албан үүргээ гүйцэтгэж явахдаа согтууруулах ундааг хэрэглэхгүй байх, ажлын бус цаг, амралт, баяр ёслолын үеэр ч архийг хэтрүүлэн хэрэглэж, олны анхааралд өртөх, таагүй сэтгэгдэл төрүүлэхгүй байх, ажлын байрыг архи, тамхигүй орчин болгоход өөрөөс шалтгаалах бүхнийг хийх, байгууллагын дотоод дэг журмыг сахих, цаг ашиглалтыг сайжруулах, иргэдийг чирэгдүүлэхгүй, хүнд суртал гаргахгүй байх, шуурхай үйлчлэх, мэргэжлийнхээ чиг үүргийг өндөр түвшинд гүйцэтгэх, мэдлэг, чадвартай, соёлч байдлаараа итгэл үнэмшил төрүүлэх, албан үүргээ гүйцэтгэх явцдаа илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний болон ажил үүргийн нууцыг задруулахгүй байх, хэрэг маргааны талаар санал бодлоо урьдчилан илэрхийлэхгүй байх, хэрэгтэн, хохирогч аль нэгэнд үйлчлэхгүй, ийм сэтгэгдэл төрүүлэх үг хэллэг, үйл



хөдлөл хийхээс сэргийлэх, хуулийн байгууллага, хуульчийн нэр төрд харшлах, сөргөөр нөлөөлөх бизнес, санхүүгийн үйл ажиллагаанд оролцохоос татгалзах, хэргийн оролцогч болон тэднийг төлөөлөх ах, дүү, төрөл садан, найз нөхдийн тусалцааг авах, үйлчлүүлэх, хөнгөлөлт эдлэх, давуу эрх олж авах, бэлэг шан харамж авах, бусдаас харамж авахаар шаардахыг цээрлэвэл зохистой” гэсэн нь хуульчдын дагаж баримтлах ёс зүйн нийтлэг шаардлага юм.

Мэргэжлийн ёс зүй нь тодорхой мэргэжлийн хүмүүсийн ёс суртахууны өвөрмөц хууль (кодекс) - ийг өөртөө багтаах ба хуульч мэргэжлийн тухайд ч мөн адил үйл ажиллагаа, гүйцэтгэх чиг үүргийнх нь шинж чанараас урган гарах ёс зүйн тусгай шаардлага тавигдана. Мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, зарчмууд нь мэргэжлийн ёс зүйн судлагдахуун болно.

Харилцагчдаа үнэнч байх, ашиг сонирхлыг нь хамгаалах, итгэл даах гэх мэт харилцагчаас тавигдах ёс зүйн шаардлага:

- Ичих, айх, нэрэлхэх, өсөрхөх г. м. сэтгэл зүйн хүчин зүйлсээс чөлөөлөгдөхөд чиглэсэн “өөрөөсөө чөлөөлөгдөх шаардлагууд”,
- Өөрийн болон хөндлөнгийн ашиг сонирхлоос харилцагчийн сонирхлыг дээгүүр тавихад чиглэсэн “харилцагчийн бус сонирхлоос чөлөөлөгдөх шаардлагууд”,
- Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх шаардлагууд.

Ёс зүйн нийтлэг шаардлагуудаас ангид хуульчийн ёс зүй гэж үгүй бөгөөд харин мэргэжлийн онцлогоос нь хамааран ёс суртахууны үндсэн хэм хэмжээнүүд өвөрмөц шинжтэй болж нарийсдаг тул хуульчдад ёс суртахууны нийтлэг шаардлагуудын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн тусгай шаардлага давхар тавигддаг онцлогтой. Ёс суртахууны шаардлагыг биелүүлээгүй хуульч олон нийтийн зүгээс зэмлэл хүлээх ба мэргэжлийн ёс зүйн шаардлагыг зөрчвөл мэргэжлийн ёс зүйн дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

Дээрх байдлаас үзвэл хуульчийн мэргэжлийн ёс зүй нь ерөнхий ойлголт бол мэргэшлийн ёс зүй нь түүнээс урган гардаг ойлголт юм. Мэргэшлийн ёс зүй нь мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээнээс салбарлан мэргэшлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэн, түүний онцлогоос хамаарч улам нарийссан байдаг бөгөөд хуульчийн өдөр тутмын ажилд илэрч байдаг тул түүнийг хуульч мэргэжлийн ёс зүйн нэгэн адил биелүүлэхгүй бол үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ.

Монгол Улсын Үндсэн хууль болон шүүх, прокурор, өмгөөллийн тухай хуулиудад тусгалаа олсон ардчилал, шударга ёс, эрх тэгш байдлыг үйл ажиллагаандаа дээдлэн мөрдөх зарчмууд хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд тусгалаа олсон нь уг дүрмүүдийг нийтээр дагаж мөрдөх эрх зүйн шинжийг тодотгож өгсөн явдал юм.

Хуульчийн мэргэжлийн ёс зүй нь хуульчийн мэргэшлийн төрөл, үйл ажиллагааны онцлогт нийцүүлсэн **тусгай шаардлагуудыг** “Шүүгчийн ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” зэргээр тус бүр зохицуулсан байдаг бөгөөд мэргэшлийн онцлог, нийгэмд гүйцэтгэх үүргийг нь харгалзан тус тусын дүрмээр мэргэшлийн зан үйлийн хүрээнд баримтлах тусгай шаардлагуудыг тавьдаг. Тухайлбал: Үйлчлүүлэгчийн хүсэлтээр эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх зэргээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд туслах үүрэгтэй **өмгөөлөгч** үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг нь хамгаалахын тулд түүний талд байх үндсэн чиглэл баримтлах ёстой ч, **тухайн нөхцөл байдлаас хамаарч, өмгөөлөгчийн “үнэнч шударга байх үүрэг” - ийн дагуу үйлчлүүлэгчийн талд ажиллахдаа ёс зүйн зохих хэм хэмжээг баримтлах зайлшгүй шаардлага урган гардаг.** Тухайлбал, эсрэг талтай үүсгэх харилцаанд хуульчийн ёс зүйн хэм хэмжээг ягштал баримталж ажиллах ёстой.

Мэргэжлийн ёс зүйн шаардлагаас зайлсхийх хандлага, нөлөөлөх хүчин зүйл: Хуульч нь хувь хүнийхээ хувьд бусдад үлгэрлэдэг, мэргэжилдээ үнэнч, өөдрөг үзэлтэй, нийгмийн үнэт зүйлсийг жинхэнэ утгаар нь тээгч байх ёстой ч нийгмийн ёс зүйн сэтгэлгээ эерэг ба сөрөг нөлөөллийг үзүүлдэг онцлогтой. Нийгмийн сэтгэлгээний нэг хэсэг нь хамт олны нөлөө бөгөөд **хамт олны сэтгэл зүйн дараах байдал ёс зүйн зөрчил, гажуудалд хүргэж болзошгүй.** Үүнд:

- Хамт олны нэг үндсэн шинж хэт өөдрөг, эрч хүчтэй байдал нь эрсдэл гаргаж болзошгүй
- Хамт олон аливаа асуудал, шүүмжлэлд ямагт шалтгаан тайлбар олсон байдаг
- Өөрсдийн үйлдлээ ёс суртахуунтай, зөв гэж бодох, үр дагаврыг нь үл тоомсорлодог
- Өөр хамт олны санаа бодол болон шүүмжлэгчдийг сөргөөр авч үздэг
- Хамт олны хэв маяг, төсөөлөл, зорилгын эсрэг үг дуугарсаныг дарамталдаг
- Хэн боловч хамт олны шийдвэрийг үг дуугүй дагах ёстой гэж ойлгодог

Түүнчлэн хуульчийн ёс зүйг гажуудалд хүргэдэг “хүн бүр л ингэдэг, тэд ийм байдлыг бий болгосон, хор уршиггүй л бол буруу зүйл биш, эсэргүүцээд дэмий” гэх зэрэг нийгмийн ердийн ухамсарт нөлөөлдөг сөрөг хандлагуудыг энд дурьдаж болно.



ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хуульчийн ёс зүйн шаардлагыг тодорхойлно уу.
- Хуульчийн ёс зүйн шаардлага нь нийтлэг ёс зүйн шаардлагаас юугаараа ялгаатай болох?
- Хуульчийн ёс зүйн шаардлагын ямар төрлүүд байж болох вэ?
- Харилцагчийн зүгээс тавих шаардлага нь ямар онцлогтой вэ?
- Өөрөөсөө чөлөөлөгдөх гэдэг нь ямар утгатай вэ?
- Шүүн таслах ажиллагаанд хуульчид ёс зүйн ямар шаардлагуудтай тулгарах вэ?
- Мэргэжлийн нэр хүнд, хуулийн байгууллагаас тавигдах ёс зүйн шаардлагууд юу болох?
- Ёс зүйн шаардлагаас зайлсхийх шалтгуудын талаар ярилцана уу.

2.3. МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Сэдвийн зорилго: *Мэргэжлийн ёс зүйн зарчим, үнэт зүйлсийг хэм хэмжээчлэх шаардлага, ач холбогдол, хуульчийн ёс зүйн шаардлагууд мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд хэрхэн баталгааждаг, ёс зүйн дүрмийн хөгжлийн талаар мэдлэг эзэмших, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах хандлага төлөвшихөд оршино.*

НЭР ТОМЬЁО:

- Ёс зүйн хэм хэмжээ
- Эрх зүйн хэм хэмжээ
- Дүрэм

“Дүрэм” гэдэг ойлголтыг (анг. statute; ор. устав) эрх зүйн төрөлжсөн актын нэг төрөл, тодорхой байгууллага, эсхүл улсын юуны өмнө аж ахуйн үйл ажиллагааны аливаа нэгэн хүрээний эрх зүйн байдлыг зохицуулсан хэм хэмжээний иж бүрдэл акт; олон улсын байгууллагын эрх зүйн байдлыг тогтоосон хэм хэмжээний акт, (анг. charter; ор. положение) - тодорхой төрийн байгууллага, албан газрын эрх зүйн статус, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам буюу нэг төрлийн байгууллага, албан газрын тогтолцоог нарийвчлан зохицуулсан, түүнчлэн эдгээрийн бусад байгууллага, албан газар ба иргэнтэй харилцах харицааг тодорхойлсон эрх зүйн хэм хэмжээний акт. Дүрмийг хууль тогтоох төдийгүй эрх зүй бүтээх бусад байгууллага баталсан байж болно гэхчлэн тайлбарлагддаг бол **мэргэжлийн ёс зүйн дүрэм** нь тухайн хуульчийн наад захын дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоож өгсөн, өөрөөр хэлбэл, хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг багтаасан байдаг.

Мэргэжлийн ёс зүйн дүрэм нь харилцагчийг хамгаалах, ялгаваргүйгээр эрх зүйн үйлчилгээ үзүүлдэг, хуульчдын үүрэг, оролцоог тодорхой болгодог, эрх зүйн тогтолцоонд итгэл бий болгодог, өмгөөллийн өрсөлдөөн бий болгодог гэх мэт чухал ач холбогдолтой бөгөөд хуульчийн ёс зүйн дүрмээр зохицуулсан хэм хэмжээг л зөрчвөл ёс зүйн зөрчил, бусад хууль тогтоомж болон эрх зүйн зарчмыг зөрчвөл ёс зүйн зөрчил биш гэж үзэх нь өрөөсгөл учир хуульч шийдвэр гаргахдаа миний шийдвэр нь ямар нэгэн эрх зүйн зарчмыг зөрчих нь үү гэдэг талаас нь анхаарч, нягталж байх ёстой.



Хуульчийн ёс зүйн шаардлагууд ёс зүйн дүрмүүдэд баталгаажиж ирсэн хөгжил

Хуульчийн мэргэжлийн ёс зүй нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн өвөрмөц хэм хэмжээнээс гадна хүнлэг, энэрэнгүй байж, ажлаа өндөр ур чадвартай хийж гүйцэтгэх, шударга байхыг давхар шаардах ба үйл ажиллагаа нь ямагт хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндийг хөндөх тул түүний үйлдэл бүхэн зөвхөн хуулийн хүрээнд хийгдсэн байх шаардлага тавигддаг.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, улс төрийн нэг намын тогтолцоотой байхад нийгмийн ёс суртахуун социалист аж төрөх ёсны зарчимд үндэслэж байсан бол 1992 оноос өмчийн олон хэвшил бүхий эдийн засаг, олон намын тогтолцоо бүхий нийгэмд шилжиж өмчийн “тэгш эрх” - ийг хангаж, үзэл бодол, итгэл үнэмшлээр “үл ялгаварлах” явдлыг хуульчилснаар нийгмийн ёс суртахууны шаардлага Монгол улсын Үндсэн хуульд тунхаглагдсан байна.

НҮБ - ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны 34/169-р тогтоолоор батлагдсан **“Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”** - д хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээ тусгагдсан байдаг бол **Монгол Улсын шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв байгууллагын ёс зүй хариуцсан албадын уулзалтаас 2003 онд нийт хуульчдад хандаж гаргасан “Санамж бичиг” нь хуульчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ тогтоох ажиллагааны эхлэл болсон юм.**

Өдгөө манай хууль, хяналтын салбарт ёс зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичиг бараг байгууллага болгонд байдаг ч НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1996 оны 51 / 59 - р тогтоолын хавсралт “Төрийн албан тушаалтны ёс зүйн Олон улсын дүрэм”, 2003 оны 58 / 4 тоот тогтоолоор баталсан “Авилгын эсрэг НҮБ-ын Конвенц”, 1979 оны 34 / 169 - р тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль” зэрэг олон хууль, дүрэм байх ба “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль” - ийн “ёс зүйн зөрчилтэй эвлэрэхгүй байх, илрүүлэн арилгах ёстой” - г тогтоож өгсөн чухал ач холбогдолтой заалтууд тэр бүр тусгагдаагүй, тусгагдсан нь тэр бүр бүрэн хэрэгжихгүй байна.

Ёс зүйн хэм хэмжээнд баримтлах зарчмууд: **Нийгмийн үнэт зүйлс** нь соёл, мэдлэг, туршлага бөгөөд **нийгмийн ёс зүйн сэтгэлгээнд** гэр бүл, хамт олон, шашин шүтлэг, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хандлага, урлаг, соёл, уран зохиол, нийгмийн ёс зүйн тухай ойлголтууд багтах бол **хувь хүний үнэт зүйлсэд** хувь хүний хүмүүжил, соёл, нийгэмд хандах хандлага, мэдлэг, чадвар зэрэг ойлголтууд багтдаг.

Хуульчийн ёс зүй нь дараах нийтлэг зарчим, үүргийн тухай ойлголтыг багтаадаг:

- Ажлыг нь үр дүнтэй болгодог ажил **мэргэжлийн үүрэг**
- **Үүрэгт ажилдаа хариуцлагатай хандах зарчим**
- **Мэргэжлийн нэр төрийг ямагт хамгаалж байх зарчим**
- Тогтоосон хэв загварын дагуу, удирдлагын зөвлөснөөр асуудлыг шийдвэрлэх амархан ч мэргэжлийн **шударга ёс** нь хуульч дарамтад автахгүй байх боломж олгоно
- Давтагдашгүй чанарыг нь ойлгож, хүнд хүндэтгэлтэй хандах, **хүнлэг ёсны зарчим**
- **Өөдрөг үзлийн зарчим:** Гутранги хуульч шударга үнэнийг тогтоож эс чадна.
- Эрх зүйн харилцаанд янз бүрийн хүмүүс татагдан ордог тул элдэв араншин гаргасан тохиолдолд асуудлыг зохицуулж, эвийг нь олж харилцах **мэргэжлийн эв дүйтэй байх**

- **Хариуцлага хүлээдэг байх.** Хуульчийн алдаанаас хүний эрх, эрх чөлөө үндэслэлгүйгээр хязгаарлагдах, гэмтэн ял завших нөхцөл бүрдэж, нийгмийн шударга ёсны тухай ойлголт алдагдахад хүрэх учир хуульч алдаа гаргах эрхгүй.
- Хэрэг маргааныг шийдвэрлэх өндөр хариуцлага бүхий хуульчид **албан тушаалдаа хүндэтгэлтэй хандаж**, өөрийн үйл ажиллагаагаараа шүүх эрх мэдлийн байгууллагын нэр төрийг хадгалж, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй.
- Албан үүргээ гүйцэтгэх болон бусад үед биеэ авч явах байдлаараа хуульчдын нэр хүндийг өндөр байлгахыг ямагт эрмэлзэж, **зохисгүй байдал гаргахгүй байх үүрэгтэй.**

Ёс зүйг дүрмээр хэм хэмжээчлэх шаардлага, ёс зүйн дүрмийн ач холбогдол

Төрөөс тогтоогдсон, түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгжиж, зөрчигдсөн тохиолдолд төрийн албадлага хэрэглэн хуулийн цээрлэл хүлээлгэдэг эрх зүй, олон нийтийн сэтгэл зүйгээр илэрч тогтоогдон түүний хүч нөлөөгөөр дамжин хэрэгжиж, зөрчигдөх тохиолдолд олон нийтийн цээрлэл үзүүлдэг, өөрөөр хэлбэл, тухайн хүний нэр хүнд болон түүнийг үнэлэх нийгмийн үнэлэмж буурдаг ёс суртахуун үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаанд оролцогчид тухайн харилцаанд мөрдөх “тоглоомын дүрэм” - ийг баримтлах



ёстой. Амьдралд шадар цэргийн, монгол бөхийн жудаг зэрэг олон төрлийн албан, албан бус дүрэм байдаг бол хуульчдын мөн адил үйл ажиллагаандаа мөрдөх ёс зүйн дүрмүүд байдаг. Жишээлэхэд “Ковбойн дүрэм ёс” (1939 он, Жин Отри) - нд:

- Ковбой хэзээ ч түрүүлж буудах, өөрөөсөө жижиг эрийг цохих буюу шударга бус давуу талыг ашиглахгүй
- Хэзээ ч хэлсэн үгнээсээ буцахгүй бөгөөд бусдын итгэлийг алдахгүй
- Үргэлж үнэнийг хэлж байх ёстой
- Хүүхэд, хөгшид болон амьтадтай эелдэг, зөөлөн харьцах ёстой
- Арьс өнгө болон шашны хувьд тэвчишгүй үзэл санааг дэмжих буюу гаргаж болохгүй
- Тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа хүмүүст туслах ёстой
- Тэр сайн ажилтан байх ёстой
- Тэрээр өөрийн бодол санаа, үг яриа, үйл хөдлөл болон өөрийн зуршил дадлыг ямагт цэвэр авч явах ёстой
- Эмэгтэйчүүд, эцэг, эх болон өөрийн улс орны хууль, журмыг дээдлэх ёстой
- Ковбой бол эх оронч юм гэсэн байдаг аж.

Аливаа хэрэг маргаантай холбоотой маш олон баримт, нотлох баримт цуглардаг тул шийдвэр гаргах явдал өөрөө бэрхшээлтэй байдаг ч шийдвэр гаргагчийн ёс зүй, оюун дүгнэлтийн хүрээнд хуульд нийцүүлэн гаргах шийдвэр нь цэгцтэй болдог учир хуульчид мэдлэг боловсрол, хууль хэрэглэх ур чадвараа дээшлүүлж, хууль хэрэглэх ажиллагааг тодорхой аргачлалын дагуу хийх нь чухал юм.

Амьдралд гарсан ижил төстэй хэргүүдийн шийдэл илт өөр гарч болохгүй, өөрөөр хэлбэл, “адил хэрэг дээр адил үндэслэл, адил хуулийг хэрэглэх” ёстой байтал шүүхийн шийдвэрийн үндэслэл муу байвал “нийгэмд хуулийг дур зоргоороо ашиглах, авлига газар авах, хэргийн оролцогчид, талууд шүүхийн шийдвэрийг үл ойлгож, улмаар шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх, эрх зүйн баталгаат орчин үгүй болох” зэрэг сөрөг үр дагавар үүсгэдэг.

Ёс зүйцэвэр байвал нийгэмд эерэг нөлөө үзүүлж, хөгжин бэхжих нөхцөл болдог бол, ёс зүй доройтвол сөрөг нөлөө үзүүлж, нийгэм уруудахын үндэс болж нийгмийн уур амьсгал бүрэлдэн тогтоход хоёр талт нөлөө үзүүлдэг

Энэ нь хуульчийн ёс зүйг эрх зүйгээр хэм хэмжээчлэх, өөрөөр хэлбэл, “эрх бүхий байгууллагаас шүүх, прокурор, өмгөөлөгч зэрэг эрүү, иргэн, захиргааны хэргийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогчдын хуульчийн үйл ажиллагааны эрх зүйн байдал, дагаж мөрдвөл зохих зан үйлийг хуульчлан тогтоож, хэрэгжилтийг албадлагаар хангах” шаардлагыг бий болгодог.

Ёс зүйн хэм хэмжээг эрх зүйгээр журамлахын сул талууд

АНУ - ын хуульч Жак Маршалл “дүрэм, журам гэдэг бол хэт тахин шүтэж болохгүй зүйл бөгөөд аливаа зүйлийг хэт хуульчлахаар “хуульчдын сэтгэлгээ” ухамсрын хүрээнд биш материаллаг болдог (дагаж мөрдөх сэтгэлгээнд автдаг) муу талтай. Сүүлийн үед АНУ - ын хуульчийн ёс зүйг зөвхөн дүрэм, журмаар зохицуулахаас илүү зарчмаар зохицуулах хандлагатай болж байна. Эрх зүйн зарчмыг мэддэг, ажилдаа хэрэглэж чаддаг хуульч “Ёс зүйн дүрэм” - ээ хэзээ ч зөрчдөггүй, тэр ч байтугай ёс зүйн дүрмийг уншиж судлах ч шаардлагагүй” гэж Монгол Улсын Хууль зүйн үндэсний хүрээлэнд явагдсан “Хуульчийн ёс зүй” сэдэвт сургалтын үед нэгэнтээ хэлсэнтэй санал нэг байна. Учир нь хуульч хэн нэгний бэлдсэн, өөрийнх нь зан үйлийг хориглосон, үүрэг болгосон заалтыг сохроор дагаж мөрдөх, дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарах хариуцлагаас зайлсхийх арга саам хайх биш, бусадтай харилцахдаа харилцааны соёлыг эрхэмлэж, бусдын нэр төрд хүндэтгэлтэй, үүрэгт ажил, өргөсөн тангарагтаа үнэнч шударга хандсанаар нийгмийн зүгээс хуульчдад хандах хандлага хэрхэн өөрчлөгдөж, ажил үүргээ гүйцэтгэхэд хэрхэн амар хялбар болохыг бие, сэтгэлээрээ мэдрэх нь өөрийгөө эерэг тал руугаа хөгжүүлэхэд илүү нэмэртэй билээ.

Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн ялгаатай байдал

Хууль зүйн мэргэжлийн хөгжлийн тодорхой үр дүнд хууль зүйн ерөнхий мэргэжил нь хууль зүйн тодорхой мэргэшил болон нарийсч, эрх зүйн үүднээс шийдвэрлэвэл зохих ажлын үндсэн чиглэлүүдээр төрөлжих үйл явцааг дагаж мөрдөх хуульч мэргэжил дотроо шүүгч, прокурор, өмгөөлөгч гэсэн нийгэмд гүйцэтгэх чиг үүргээрээ ялгагддаг, мэргэшсэн шинжтэй, өөрийн гэсэн онцлогтой, мэргэжлийн ёс зүйн шаардлагатай, үйл ажиллагаандаа баримтлах зарчимтай мэргэшлүүд бий болсон.



Хэрэг, маргааныг шүүн хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй **шүүгч** нь энэ эрхээ хэрэгжүүлэхдээ хэргийг бодит үнэнд нийцүүлэн шударгаар шийдвэрлэх, хараат бус байх, хууль дээдлэх, шударга ёсны зарчмыг удирдлага болгодог бол,

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, ЭБШАжиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг хянах, түүнчлэн ял эдлүүлэх болон гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцож яллах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагаандаа нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, гадны нөлөөнд үл автах, хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах, хуулийг хүндэтгэж чанд сахих зарчмыг удирдлага болгон баримталдаг байна.

Өмгөөлөгч нь Үндсэн хуулиар олгогдсон иргэд хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах. эрх хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхийг нь хэрэгжүүлэх баталгааг хангаж, иргэн, хуулийн этгээдэд эрэлт хэрэгцээтэй эрх зүйн туслалцаа, үйлчилгээг үзүүлэх, зөрчигдсэн эрхийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгааг ханган оролцох ба үйл ажиллагаандаа үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг тууштай хамгаалах, өмгөөллийн нууцыг хадгалах, хуулийг дээдлэх, шударга ёсыг сахих, хүнлэг, энэрэнгүй байх зэрэг зарчмуудыг удирдлага болгодог.

Хуульчдад тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага хууль тогтоомжид тусгагдсан байх хэдий ч хуульчдын мэргэшлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарах мэргэшлийн ёс зүйн тусгай шаардлагыг Монгол Улсын шүүхийн Шүүгчийн ёс зүйн дүрэм, Прокурорын ёс зүйн дүрэм, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд тус тус хэм хэмжээчилсэн байх бөгөөд тус тусын мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл ёс зүйн дүрмийн шаардлагыг зохих ёсоор биелүүлээгүй санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэхүй нь хуульчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог байна.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Эрх зүйн ба ёс зүйн хэм хэмжээний хоорондын харилцан хамаарал?
- Тэдгээрийн ялгаатай ба төсөөтэй тал юу вэ?
- Ёс зүйн үнэт зүйлс, зарчмуудыг эрх зүйгээр хэм хэмжээчлэх шаардлагатай юу?
- Хуульчийн ёс зүйг өөрт нь найдаж болдоггүй юм уу?
- Ёс зүйн дүрэм гэж юу вэ?
- Мэргэжлийн ёс зүйн дүрмийн ач холбогдол?
- Ёс зүйн хэм хэмжээнд баримтлах ямар нийтлэг зарчмууд?
- Хуульчийн ёс зүйн шаардлагууд мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд хэрхэн баталгаажиж ирсэн бэ?
- Ёс зүйн хэм хэмжээг эрх зүйгээр журамлахын сул талууд юу байж болох вэ?

2.4. ӨМГӨӨЛӨГЧИЙН ЁС ЗҮЙ

Сэдвийн зорилго: *Өмгөөлөгчийн ёс зүйн ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, зарчим, онцлогын талаар цэгцтэй мэдлэг эзэмших, өмгөөлөгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд хууль зүйн болон ёс зүйн хэм хэмжээний үүднээс тайлбар хийх чадвар эзэмшихэд оршино.*

НЭР ТОМЬЁО:

- Өмгөөлөгч
- Өмгөөллийн нууц
- Үйлчлүүлэгч
- Үйлчилгээний хөлс
- Гуравдагч этгээд

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн тухай ойлголт

Өмгөөлөгчийн ёс зүй нь хуульчийн ёс зүйн салшгүй хэсэг төдийгүй өмгөөллийн үйл ажиллагааны онцлогийг илэрхийлсэн, “Монголын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”- ээр тогтоосон тусгай шаардлагууд байдаг.

**Үйл ажиллагааны зарчим:**

- Хүний эрх эрх чөлөө, шударга ёсыг хангах, хууль дээдлэх
- Өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох
- Өмгөөллийн үйл ажиллагаа төрийн ивээлд байх, аливаа байгууллага, албан тушаалтан өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс үл оролцох
- Өмгөөлөгч хуулийн хүрээнд өмгөөлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн тууштай хамгаалах

Хууль зүйн туслалцаа үзүүлэхэд баримтлах зарчим:

- Тодорхой ойлгомжтой байх
- Хууль дээдлэх
- Шударга ёсыг сахих
- Чөлөөт гэрээ, тохиролцоонд үндэслэх
- Хүнлэг энэрэнгүй байх
- Соёлтой харилцааг эрхэмлэх
- Нууцыг хадгалах
- Хүмүүст хөнгөлөлттэй нөхцөлөөр хууль зүйн туслалцааг үзүүлэх

Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг дараах байдлаар ангилсан байдаг.
Үүнд:

Мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхдээ:

- харилцан ойлголцох, итгэлцэх, хүлээсэн үүргээ ягштал биелүүлэх
- гадны нөлөөнд авталгүй, эрх зүйн ухамсраа удирдлага болгох
- эрхэлсэн ажилдаа чин сэтгэлээсээ хандах
- өөрийн хөдөлмөрийг үр ашигтай зохион байгуулах
- мэдлэг, боловсролоо байнга дээшлүүлж байх

Мэргэжил нэгтгэнтэйгээ харилцахдаа:

- хамтран ажиллагсаддаа хүндэтгэлтэй хандах
- төлөв төвшин байх
- өөрийн ажил хэргийн нэр хүндийг дээшлүүлэхийн тулд бусад өмгөөлөгчийн алдар хүнд, нэр төрд сэв суулгахгүй байх

Үйлчлүүлэгчтэйгээ харилцахдаа:

- үйлчлүүлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах
- өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхэд хүндэтгэлтэй хандах
- үйлчлүүлэгчийн эрх ашгийг зөрчилдөөнд хүргэхгүй байх
- өөр өмгөөлөгч урьд нь оролцож байсан хэрэгт ажиллах хүсэлт хүлээн авах эсэх тухай түүнд мэдэгдсэний дараа шийдэх
- хамтран өмгөөлөх асуудлыг нөгөө өмгөөлөгчтэйгээ зөвшилцөж байх
- хэргийг бүрэн шийдвэрлэж дуустал үйл ажиллагаагаа явуулах
- өмгөөллийн тодорхой үйл ажиллагааны үр дүнд үүсч болох үр дагаврын талаар тайлбарлан таниулах,
- ажил хэрэгч, ухаалаг, соёлтой, шуурхай байж хэргийн явцын талаар үйлчлүүлэгчид тогтмол мэдээлэл өгч байх үүрэгтэй.

Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн хангахад чиглэгдсэн баталгааг урьдчилан гаргах ёсгүй бөгөөд хууль тогтоомж хэрэглэх, тайлбарлах асуудлаар өөрийнх нь мэдлэг, хүч бололцоо хүрэхгүй байгааг мэдэрсэн нөхцөлд, мөн бие эрүүл мэндийн байдал болон бусад хүндэтгэн үзэх шалтгаан гарсан үед үйлчлүүлэгчээс өмгөөлүүлэхээр тавьсан хүсэлтийг хүлээн авахаас татгалзах, хэргийн материалд үндэслэн өөрийнх нь ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гарч болзошгүй талаар үйлчлүүлэгчдээ урьдчилан мэдээлэх зэрэг эрхтэй байдаг.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч ба албадан саатуулах, урьдчилан хорих байгууллагын албан хаагчтай харилцах ёс зүйн хэм хэмжээ:

- өмгөөлөгчийн бичсэн өргөдөл, гомдол, хүсэлт тавьсан асуудал нь ЭБШАжиллагааг хэрэгжүүлэгч, уг ажиллагаанд оролцогчдын нэр хүндийг гутаахад чиглэгдээгүй байх
- хэргийг шийдвэрлэх явцад үйлчлүүлэгчийнх нь хууль ёсны эрх, ашгийг хөндсөн тохиолдол үүсвэл түүнийг таслан зогсоохын тулд хуульд заасан бүхий л арга хэрэглүүрийг бүрэн ашиглах
- албадан саатуулах, урьдчилан хорих байранд байхдаа энэ талаарх хууль тогтоомжийн шаардлагыг сахин биелүүлэх
- өмгөөлүүлэгчтэйгээ цагийн хязгаарлалтгүйгээр ганцаарчлан уулзалт хийхийг шаардах эрхээ эдлэх талаар санаачлагатай байх

Шүүхтэй харилцахад баримтлах ёс зүйн хэм хэмжээ:

- Хууль ёсны үндэслэлтэй шийдвэр гаргуулах талаар туслалцаа дэмжлэг үзүүлэх
- Нотлох баримтыг шинжлэн судлахад идэвхтэй оролцож, хуралдааны явцад шалгагдсан хэргийн материалд тулгуурлан өмгөөллийн үндэслэлээ гаргах
- Шүүх хуралдааны тогтоосон дэгийг сахин биелүүлэх
- Шүүх хуралдаанд сайтар бэлдэж оролцох
- Үндэслэлгүйгээр шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх

Өмгөөлөгч дараах тохиолдолд иргэний хэрэгт өмгөөлөгчөөр оролцох саналыг хүлээн авахгүй байж болно.

- Үйлчлүүлэгчийн шаардлага буюу татгалзлын үндэслэгээтэй болгоход шаардлагатай үйл баримт байхгүй болох нь илэрсэн
- Шаардлага буюу татгалзлын үндэслэгээ нь тухайн эрх зүйн харилцааг зохицуулсан хуулийн дагуу нотлох баримтаар батлагдахгүй байгаа
- Өмгөөлөгчийн эрх зүйн байр суурь үйлчлүүлэгчийн байр суурьтай зөрчилдсөн
- Маргаантай асуудал үүссэний улмаас өмгөөлөгч нь нөгөө талтай хувийн үл ойлголцох харилцаатай болсон.



Өмгөөлөгч дараах тохиолдолд өмгөөлөгчөөр оролцох ёсгүй.

- Хэрэв тухайн хэргийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчтэй өмгөөлөгч ойрын садан төрлийн холбоотой бол
- Хэрэв өмгөөлөгч урьд нь тухайн хэрэгт шүүгч, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шинжээч, орчуулагч, гэрч, хохирогч, иргэний хэргийн үндсэн нэхэмжлэгч, хариуцагч, түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол
- Хэрэв өмгөөлөгч урьд нь нөгөө талд хууль зүйн туслалцаа үзүүлж энэ нь хүсэлт гаргагчийн ашиг сонирхолтой зөрчилдөж байгаа бол
- Хэрэв тухайн хэрэгт ачаалал ихтэй учир өмгөөлөгчөөр ажиллаж чадахгүй болох нь өмгөөлөгчид тодорхой болсон бол
- Өмгөөлөгч хуульд харшилсан шаардлага тавьж байгаа буюу өөрийнхөө ашиг сонирхлыг хамгаалуулахын тулд хууль бус арга хэрэглүүр ашиглахыг шаардаж байгаа үйлчлүүлэгчид туслалцаа үзүүлэхээс татгалзах эрхтэй. Түүнчлэн өмгөөлөгч нь үйлчлүүлэгч өөрийнхөө ашиг сонирхлын төлөө зогсохдоо зан суртахууны хувьд эргэлзээтэй арга хэрэглүүр ашиглуулах байр суурин дээр байгаа, түүнчлэн боломжгүй бусад арга хэрэглүүр ашиглуулах байр суурин дээр байгаа, түүнийгээ хэрэглэхийг шаардаж байгаа хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

Өмгөөлөгчийн цээрлэх зүйл:

- Хэрэг асуудлыг урьдчилан ашигтай шийдүүлнэ гэж амлалт өгөх
- Тохиролцооноос гадна өмгөөллийн үйл ажиллагааны хэмжээ, үр дүнд тохирохгүй өндөр үнэ хөлс нэхэх
- Үйлчлүүлэгчтэй ажлын цагаар болон ажлын байранд архи дан согтуурах
- Өмгөөлөгч байгаа байдлаа далимдуулж үйлчлүүлэгчээр өөрийн хувийн ажил төрлийг хөөцөлдүүлэх, зүй бус харилцаа тогтоох
- Өмгөөллийн хөлснөөс өөр шан, харамж, авахаар шахалт дарамт үзүүлэх
- Өмгөөллийн хүрээнд хуулийн байгууллагын ажилтнуудтай хэлхээ холбоо тогтоох
- Гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй, хэрэг маргаан нь эцэслэн шийдэгдээгүй байхад урьдчилсан дүгнэлт хийж хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр тараах, бусдыг үндэслэлгүйгээр гутаах, мэргэжлийн нэр хүндэд харш, үйлдэл, үйл ажиллагаа явуулах

Өмгөөллийн нууц:

- Өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа эрх зүйн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна.
- Өмгөөлөгч өмгөөллийн нууцыг задлах, эсхүл амин хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.
- Өмгөөллийн нууцыг хугацаагүй хадгална. Өмгөөллийн нууцыг хуулиар хамгаална.

Өмгөөллийн үйл ажиллагаанд хориглосон зүйл:

- Аливаа этгээдээс өмгөөлөгчид эрх зүйн туслалцаа хүсч хандсан болон үйлчлүүлэгчид эрх зүйн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор асуух.
- Хуульд зааснаас бусад тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагаатай нь холбогдуулан яриаг чагнах, албан байранд нь үзлэг, нэгжлэг хийх, баримт бичгийг гаргуулан авах.
- Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад нь дарамт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, ямар нэг баталгаа шаардах заналхийлэх.

Өмгөөлөгчийн үйлчилгээний хөлс:

- Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлчлүүлэгчээс өмгөөллийн үйлчилгээний хөлс авна. Хөлсний хэмжээг үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцож тогтооно. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг харгалзан үзэж түүнийг өмгөөллийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлж болно.
- Өмгөөлөгч нь өөрийн гүйцэтгэсэн ажилдаа тохирсон хөлсийг үйлчлүүлэгчээс авах бөгөөд өмгөөллийн хөлсний талаар тохиролцохдоо хэргийн ээдрээ төвөгтэй байдал, зарцуулах зайлшгүй шаардлагатай хөдөлмөр, цаг хугацаа, үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн байдал, өөрийн өмгөөллийн ажлын дадлага, туршлага, нэр хүнд, өмгөөллийн ажлын хөлсний хэмжээ, уг ажиллагааны үр дүн, үйлчлүүлэгчийн үнэлгээ зэргийг харгалзана. Өмгөөллийн хөлс авахгүйгээр ажил, үйлчилгээ үзүүлж болно.



Өмгөөллийн явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх

Өмгөөлөгч хамгийн түрүүн зөвлөгөө авагч өөртэй нь онцгой харилцаанд байгаа эсэхийг мэдэх нь чухал. Зайлшгүй мэдэгдэх ёстой онцгой харилцаа гэдэгт өмгөөлөгчийн хувийн болон нийгмийн бүхий л харилцаан дахь “тухайн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх харилцаанд” шууд болон шууд бусаар нөлөөлж болохуйц нөхцөл болон өмгөөлүүлэгч тухайн өмгөөлөгчийг сонгосноор эрх ашигт нь сөрөг нөлөө үзүүлж болох нөхцөлийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Онцгой харилцаа нь цаг хугацаанаас үл хамаарч дараах нийтлэг хэлбэртэй байж болно:

1. Өмгөөлөгч нь үйлчлүүлэгч этгээд, түүний хамааралтай хүнтэй гэр бүлийн болон хувийн бусад харилцаатай, санхүүгийн хамаарал, өр авлагатай бол,
2. Өмгөөлөл явуулах гэж байгаа хэрэг нь өмгөөлөл явуулж буй хэргийн үйлчлүүлэгчийн ашиг сонирхолд харшлах бол,
3. Хуулийн зөвлөх болгох хүсэлт тавьсан үед өрсөлдөгч Компанитай нь итгэлцэлт харилцаанд байгаа бол,
4. Хүсэлт гаргасан этгээдийн эсрэг ашиг сонирхолтой зохигч нь урьд өмнө үйлчлүүлэгч нь байсан бол

Онцгой харилцааны талаар өмгөөлөгч мэдэгдсэн ч

- үйлчлүүлэгч өөрөө өмгөөллийн үйлчилгээ авахыг зөвшөөрсөн, энэ нь бусад этгээдийн эрх ашигт хор хохирол учруулахааргүй бол,
- мөн одоо үйлчлүүлж байгаа өөр үйлчлүүлэгчийн эрх ашигт харшлах хэргийн хувьд ч үндсэндээ өмгөөллийн үйл ажиллагаа явуулж болохгүй боловч тухайн үйлчлүүлэгч, нөгөө үйлчлүүлэгч хоёул энэ тухай мэдэж, хоёул өмгөөлүүлэхийг зөвшөөрсөн бол өмгөөллийн үйл ажиллагаа явуулж болно.

Энэ нь өөр үйлчлүүлэгчийн өөр үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах үүрэг болон ажил үүргийн хувиар хуулийн өмнө хүлээх бусад үүргээс шалтгаалан мэдүүлэг, баримт, нотолгоо гаргах зэрэг боломжит үйл ажиллагаа нь хязгаарлагдах болно гэсэн үг юм.

Ашиг сонирхлын зөрчилтэй тодорхой тохиолдолд үйл ажиллагаа явуулах, зөвлөгөө өгөхийг хориглож буй гол зорилго нь зохигчийн эрх ашгийг хамгаалах, өмгөөлөгчийн үйл ажиллагаанд шударга ёсыг хангах, өмгөөлөгч үйлчлүүлэгчдээ үнэнч, шударгаар хандан ажил үүргээ гүйцэтгэх баталгааг бий болгох зорилготой. **Зөвлөгөө өгөх** гэдгийг “тодорхой хэрэгт хуулийн тайлбар,

шийдвэр хүссэн зөвлөгөөг хэлэх ба “**өгсөн**” гэдэгт субъектив чанартай байх буюу биечилж өгсөн байхыг шаардана.

Энэ байдлаас харахад ашиг сонирхлын зөрчилдөөнтэй үед үйл ажиллагаа явуулахыг хориглох үндэслэл нь зөвхөн эдийн засгийн ашиг сонирхолтой хэргийн үед гэж зааглахгүй гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч нь зөвхөн эдийн засгийн харилцаан дээр бус бусад төрлийн харилцаа болон бусдын өмнө хүлээсэн үүргийн онцлогоос хамаарч эрхийн хязгаарлалт эдэлж болно.

Жишээ - 1, Эсрэг талын этгээд, эсхүл түүний өмгөөлөгч нь баталгаагүй эхнэр, нөхөр нь байх, цусан төрлийн холбоогүй ч өргөж авсан аав, ээж нь байх, удаан хугацаанд харилцаагүй байсан аав, ээж, эхнэр, нөхөр нь байх тохиолдолд өмгөөлөгч үйлчлүүлэгчдээ үнэнч, шударга үйлчилгээ үзүүлж чадахгүй байхад хүргэж болзошгүй юм.

Жишээ - 2, Өвлүүлэгч А-гийн том хүү Х нь бусад өв залгамжлагч Y1 - Y4-тэй өв хуваах асуудлаар арбитрийн шүүхэд ханджээ. Өмгөөлөгч Л нь Y1 - Y4-ийн итгэмжлэлээр тэднийг төлөөлөх болж хагас жил зарцуулан 4 удаа арбитрийн давхцуултал Y1 болон Y2-Y4 -ийн хооронд өв хуваах талаар зөрчилдөөн үүсчээ. Өв хуваах хэргийн тухайд хэд хэдэн үйлчлүүлэгчийг төлөөлөх тохиолдолд хэд хэдэн эрх ашгийн зөрчилдөөн үүсэх магадлалтай гэдгийг анхаарах хэрэгтэй.

Бодит байдал дээр өв залгамжлагч хүн бүр тус тусдаа өмгөөлөгчтэй байх нь зардлын хувьд ч, өмгөөлөгч олоход ч хүндрэлтэй байдаг. Түүнчлэн эрх ашгийн зөрчилдөөн гаралгүй дуусах явдал байдгаас эрх ашгийн зөрчилдөөн байхгүй байсан тохиолдолд л өмгөөлөгч уг хэргийг хүлээн авахад хүрдэг тохиолдол цөөнгүй байдаг. Гэхдээ дээр өгүүлсэн нөхцөл байдлаас шалтгаалан хүлээн авах тохиолдолд ч өмгөөлөгч үйлчлүүлэгч тус бүрт ирээдүйд ажлаа орхих магадлал байгаа болон тэд хохирол хүлээж магадгүй тухай тайлбарлах ёстой.

Ийм нөхцөл байдлын талаар мэдэгдсээр байтал үйлчлүүлэгч өмгөөлөгчийг саналыг нь хүлээн авахыг санал болгох тохиолдолд өмгөөлөгч хэргийг хүлээн авч болно. Гэхдээ энэ жишээн дээр гарсан шиг хэргийг хүлээн авах үед байгаагүй ашиг сонирхлын зөрчилдөөн хэргийн явцад гарч ирсэн тохиолдолд өмгөөлөгч ажлаа орхих хүсэл санаагаа илэрхийлэх ёстой. Энэ тохиолдолд өмгөөлөгчийн хувьд Y1 - с Y4 - ийн дотроос тодорхой нэг этгээдээс “өөрийг нь төлөөлөн үлдэх” - ийг санал болгох явдал гардаг боловч ашиг сонирхлын зөрчилдөөн анхнаасаа оршин тогтнож байсан тохиолдолд үйлчлүүлэгч хүсэлт тавьсан ч хүлээн авч болохгүй.

Жишээ - 3, өмгөөлөгч Л1 өмгөөлөгч Л2 той хамтран хууль зүйн товчоо ажиллуулдаг. Энэ удаа өмгөөлөгч Л1 нь А-гийн итгэмжлэлээр Б-гээс хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах үед Б нь өмгөөлөгч Л2-оос тэр маргааны талаар хууль зүйн зөвлөгөө авч байсан нь тодорхой болбол өмгөөлөгч Л1 нь уг хэргийг хүлээн авч болохгүй.



Бодлого 1: Хотын төвийн нэгэн байшингийн хана налж унасан согтуу эмэгтэй бусдад ээмэг бөгж, цүнхтэй мөнгөө алдсан хэрэгт Ц - г сэжигтэнээр татсан байна. Ц өмгөөлөгч авахдаа “Хохирогч эмэгтэй 19 цагийн үед гэж цагаа андуурч мэдүүлсэн байна, тэр үед 20 цаг болж байсан юм. Би 19 цагийн үед найзуудтайгаа байсан та тэднийг гэрчээр асуулгах санал тавьж намайг ямар ч буруугүйг нотолж өгөөч гэж гуйсан. Өмгөөлөгч саналыг хүлээн авчээ.

- Өмгөөлөгч ёс зүй зөрчсөн үү?

Бодлого 2: Өмгөөлөгч А-гийн үйлчлүүлэгч Б автомашины осол гаргаж Г-гийн хүүд хүнд гэмтэл учруулсан тул Г жолоочоос хүүхдийн бие эрүүл мэндэд учруулсан хохирлыг төлүүлэхээр мөнгө нэхэмжилсэн. Хэргийг шүүх шийдвэрлэх үед “гэмтлийн улмаас хүүгийн нурууны гол судсанд аневризм буюу бөглөрөл гарсан тэр нь амь насанд нь аюул учруулахуйц нөхцөл үүссэн” гэсэн эмчийн дүгнэлт гарсан байна. Энэ мэдээллийг нэхэмжлэгч тал, түүний өмгөөлөгч мэдвэл мөнгөний хэмжээ эрс нэмэгдэнэ тиймээс мэдээлэхгүй байна уугэж өмгөөлөгчөөсөө хүссэн тул өмгөөлөгч энэ талаар эсрэг талд мэдэгдээгүй, шүүх энэ асуудлыг хэргийг шийдвэрлэхэд огт анзаараагүй байна.

Өмгөөлөгч А хэргийг шийдвэрлэсний дараа ажил дээрээ ирж найз өмгөөлөгчдөө энэ тухай хэлж “бидний талд шийдвэрлэгдлээ, азтай юм боллоо, нэхэмжлэгч тал хүүгийн гэмтлийг олж мэдсэнгүй” гэхэд найз өмгөөлөгч нь “хүүгийн амь насанд аюул учрах нь байна, аав ээжид нь мэдэгдэх ёстой” гэж маргалдахад “би хариуцагчид үйлчилсэн болохоос, хүүд үйлчлээгүй” гэжээ.

- Дараах хариултуудаас сонголт хийж ярилцана уу ?

1. Ёс зүй зөрчөөгүй, хариуцагчийн өмгөөлөгч хүүгийн өмнө үүрэг хүлээгээгүй
2. Хүүгийн амь насанд учирсан аюул нь мэргэжлийн ямар ч үүргээс илүү чухал асуудал
3. Хариуцагчийн өмгөөлөгчид сонголт байхгүй. Хариуцагч дээрх сонголтыг хийх ёстой
4. Үнэнч бус байсан гэж мэргэжлийн байгуулагын зүгээс шийтгэл хүлээх байсан ч мэдэгдэнэ
5. Хэрэв хариуцагч нэхэмжлэгчид мэдэгдэхгүй бол өмгөөлөгч үйлчилгээнээсээ татгалзана
6. Өөр хариулт байна.

Бодлого 3: Гадаадын хөрөнгө оруулалттай компаниас хувьцаанд ногдох хөрөнгөө нэхэмжилсэн хэргийг шийдвэрлэх маргаанд нэхэмжлэгч тал шүүхэд хүсэлт гаргаж уг нотлох баримтыг албадан гаргуулахаар хандсан ч хариуцагч тал хэргийн гол чухал нотлох баримт ганц хувь байсныг устгасан тул уг шаардлагыг биелүүлэх боломжгүй болсон учир шүүхэд “тийм нотлох баримт байхгүй” гэсэн тайлбарыг өгсөн ба өмгөөлөгчдөө “нэхэмжлэгч тал болон шүүхэд битгий хэлээрэй” гэсэн.

1. Өмгөөлөгч ёс зүй зөрчсөн үү?
2. Зөрчөөгүй, нууцыг хадгалах үүрэгтэй
3. Үйлчлүүлэгчдээ энэ нь хууль бус гэдгийг ойлгуулах ёстой
4. Өмгөөлөхөөс татгалзах ёстой
5. Үнэн байдлыг шүүхэд хэлнэ

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Өмгөөлөгчийн ёс зүй нь ямар онцлогтой вэ?
- Өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудын талаар ярилцана уу.
- Мөн чанартай холбоотой ёс зүйн хэм хэмжээ гэж юу вэ?
- Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй харилцахдаа ёс зүйн ямар хэм хэмжээг баримтлах ёстой вэ?
- Өмгөөллийн нууцлалтай холбоотой ёс зүйн ямар хэм хэмжээнүүд үйлчилдэг вэ?
- Өмгөөлөгч гуравдагч этгээдтэй харилцахдаа баримтлах ёс зүйн хэм хэмжээний талаар ярилцана уу.
- Өмгөөллийн явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөний талаар тайлбарлана уу.



2.5. ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙ

Сэдвийн зорилго: *Прокурорын ёс зүйн ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, зарчил, онолын талаар цэгцтэй мэдлэг эзэмших, прокурорын мэргэшлийн үйл ажиллагаанд хууль зүйн болон ёс зүйн хэм хэмжээний үүднээс тайлбар хийх чадвар эзэмшихэд оршино.*

НЭРТОМЬЁО:

- Прокурор
- Хяналт
- Улс төрийн хязгаарлалт
- Мэргэжлийн нэр хүнд

Прокурорын ёс зүйн тухай ойлголт

Прокурор нь төрийн тусгай албан хаагч, өвөрмөц чиг үүрэг бүхий албан тушаалтны хувьд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ, түүнчлэн нийгэм, хамт олон, гэр бүлийн хүрээнд дагаж мөрдвөл зохих зан үйлийн нийлбэр цогцыг прокурорын ёс зүйн хэм хэмжээ гэнэ.

“Прокурорын ёс зүйн дүрэм” - ийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 -р Зарлигаар батлан хэрэгжүүлж байна. Бусад мэргэшлийн хуульчийн ёс зүйн дүрмийг тухайн хуулийн буюу төрийн зохих байгууллагын удирдлага өөрийн эрх хэмжээний актаар батлан, ихэвчлэн хориглосон, зарим нь зөвшөөрсөн шинжтэй хэм хэмжээг шууд тогтоож байсан бол шинээр батлагдсан “Прокурорын ёс зүйн дүрэм” (“Төрийн мэдээлэл, 2002, № 33,(275)”) бүтэц, агуулгын хувьд нэлээд онцлогтой болжээ. Тухайлбал, дүрэм оршил, нийтлэг үндэслэл, прокурорын ёс зүйн тусгайлсан хэм хэмжээ, түүний дотор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад баримтлах 7 заалт бүхий хэм хэмжээ, хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах 7 заалт бүхий хэм хэмжээ, прокурорын улс төрийн үйл ажиллагаанд тавигдах 3 заалт бүхий хязгаарлалт, прокурор биеэ хэрхэн авч явах талаарх 5 заалт бүхий хэм хэмжээ, прокурорын ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрэх 7 заалт бүхий хэм хэмжээ гэсэн бүтэц нь тус бүрдээ тодорхой хэм хэмжээг агуулсан нь хуулийн хэлбэрийг ашигласан байдалтай, ёс зүйн хэм хэмжээг агуулгаар нь тодорхой ангилалд оруулсан байна.

Прокурорын ёс зүйн дүрэмд “Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, хамгаалах зарчим, хэм хэмжээ, хуульд нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий прокурорын шийдвэрийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгаж, чиг үүргээ шударгаар хэрэгжүүлэх гол нөхцөл мөн. Прокурор ёс зүйн зөрчил гаргах нь нийгмээс прокурорт итгэх итгэлийг алдагдуулах, прокурорын байнууллагын нэр хүндийг бууруулах сөрөг үр дагавартай тул прокурор бүр ёс зүйн хэм хэмжээг чанд сахин мөрдөнө” гэж заасан байдаг.

Прокурорын ёс зүйн дүрмийн зорилт нь прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүй, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, прокурорын нэр төрийг хамгаалахад оршдог.

Прокурорын ёс зүйн онцлог нь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцож, улсын яллагчийн үүрэг гүйцэтгэхдээ дан яллах хатуу байр сууринаас хандаж, хэргийн үнэн мөнийг олж харахгүй өнгөрчих байдлаас зайлсхийх хэрэгтэй байдаг хэдий ч хяналтын үүргээ гүйцэтгэхдээ хэлбэрдэхгүй байж, асуудалд хандахдаа бодит баримтад тулгуурлах, үнэн зөв мэдээлэлд итгэхгүй дан хардах, сэрдэх талаас нь хандаж туйлшрахгүй байх, зүй ёсны юманд эмзэглэхгүй байхад оршино.

Прокурорын ёс зүйн шаардлага нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж, хамгаалах зарчим, хэм хэмжээ, хуульд нийцүүлэн гаргасан УЕП -ын шийдвэрийг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь прокурорын нэр төрийг цэвэр, ариун байлгаж, чиг үүргээ чин шударгаар хэрэгжүүлэх гол нөхцөл мөн.

Прокурорын ёс зүйн хэм хэмжээ ба зарчим

Прокурорын ёс зүйн зарчмууд:

- Хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах
- Хуулийг хүндэтгэн дээдэлж, чанд сахин биелүүлэх
- Прокурорын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх
- Прокурор гадны нөлөөнд үл автах
- Хуулийг нэг мөр хэрэглэх
- Прокурорын нэр төрийг цэвэр ариун байлгах



Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн хэм хэмжээ:

- Хяналтын чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд, хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.
- Хэргийн оролцогч, өмгөөлөгчтэй харилцахдаа ялгавартай байдал гаргахгүй хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга зөв шийдвэрлэж чадахуйц мэдлэг, харилцааны соёлтой байна.
- Хэргийн оролцогч, өмгөөлөгч, бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа ашилж зандрах, айлган сүрдүүлэх, догшин хэрцгий харилцах, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авир гаргахгүй байна.
- Хувийн сонирхлын үүднээс харьяаллын бус, бусдын хяналтад байгаа хэрэг материалтай танилцах, зөвлөгөө өгөх, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор нарт өөртөө ашигтай болон үндэслэлгүй шийдвэр гаргуулах хүсэлт тавихыг цээрлэж, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцож дарамт шахалт үзүүлэхгүй.
- Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг материалын талаар урьдчилан дүгнэлт гаргах, саналаа илэрхийлэхээс зайлсхийж, хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэрэг материалын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж, нэвтрүүлэхгүй байна.
- Прокурорт хандаж гаргасан гомдол, хүсэлт, мэдээлэлд анхааралтай хандаж шуурхай шийдвэрлэж байна.
- Ойр дотны харилцаатай хүмүүс, өмнө нь ажиллаж байсан, эрх ашгийг нь ямар нэгэн хэлбэрээр хамгаалж байсан байгууллагатай холбогдсон эрүү, иргэний хэрэг, материалыг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй.

Прокурорын улс төрийн үйл ажиллагаанд тавих хязгаарлалт:

- Улс төрийн аливаа байгууллагын албан тушаал эрхлэх,
- Улс төрийн байгууллага, нэр дэвшигчийг дэмжиж, эсвэл эсэргүүцэж үг хэлэх,
- Сонгуулийнх нь сурталчилгаанд аливаа хэлбэрээр оролцох,
- Улс төрийн байгууллага, нэр дэвшигчид санхүүжилт олж өгөхийг эрмэлзэх, хандив өгөх.

Прокурор нийгмийн бусад үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ:

Прокурор дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- Хяналтын чиг үүрэгт холбогдолгүй асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох,
- Багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэхдээ тэдгээр байгууллагуудын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох,
- ХМХэрэгслээр прокурорын байгууллагын нэр хүндэд харш сурталчилгаа хийх,
- Нийгэм, соёлын үйл ажиллагаанд оролцохдоо уг арга хэмжээ нь прокурорын байгууллагын нэр хүндэд харшлахаар бол түүнээс татгалзана.
- Албан үүргээ хэрэгжүүлэхэд харшлах, эсхүл сөргөөр нөлөөлөх, шүүгчийн албан тушаалыг ямар нэг байдлаар ашиглахыг санаархсан аливаа хэлцэл, үйл ажиллагаанаас зайлсхийх,
- Прокурорын албан тушаалд харшилж болох аливаа хөрөнгө оруулалт, бизнесийн бусад ашиг сонирхлоос татгалзах,
- Албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон олж авсан аливаа мэдээллийг өөрийн санхүү, эдийн засгийн аливаа хэлцэл, үйл ажиллагаанд ашиглах.

Прокурорын биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ:

- Өөрийн бүхий л үйл ажиллагаа, биеэ авч явах байдлаараа прокурорын байгууллагын нэр хүндийг хамгаалж, олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж байна.
- Албан үүргээ хэрэгжүүлэх болон эрх бүхий байгууллагаас шаардсанаас өөр тохиолдолд бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар тодорхойлохгүй.
- Хувийн журмаар эрдэм шинжилгээний ажил эрхлэх, багшлах, зохиол бүтээл туурвих, хэвлэн нийтлэх, гэрээ хэлэлцээр байгуулахад прокурорын албан тушаал, прокурорын байгууллагын нэр хүндийг ашиглахаас зайлсхийнэ.
- Дүрэмт хувцастай яваа үедээ, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж явах үедээ, ажлын байранд, эсвэл ЭБША -ны явцад, хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгчид, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчтэй ууж согтуурахыг хориглоно.
- Ууж согтууран эрүүлжигдэх, захиргааны арга хэмжээ авагдах, бусдыг доромжлохыг цээрлэнэ.

Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх: Хувь хүний мөн чанар нь янз янз байдгаас прокурор өөрийн хувийн сөрөг зан чанараа давж гарахгүй, ашиг сонирхлын зөрчилдөөнт байдлаас зайлсхийж чадахгүй байснаас үйлдэл нь мэргэжлийн ёс зүйтэй зөрчилдөх, ёс зүйн бус асуудал гаргах хандлагыг бий



болгодог. Тухайлбал, хайрлах, үзэн ядах, өрөвдөх, нэр төр, өнгө мөнгөнд шунах, атаархал, хардалт зэрэг нь ёс зүйг зөрчих үйлдлийг хийлгэхэд дотроос нь өдөөгч хүчин зүйлс юм. Хуульч мэргэжлийн хүрээнд дагаж мөрдөх ёс зүйн шударга байх, хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэх, хараат бус байх, хэн нэгний нөлөөнд автахгүй, хувийн харилцаа тогтоохгүй байх, хэрэв хувийн харилцаатай, садан төрлийн холбоотой, хэргийг шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ төрвөл хуульд заасны дагуу татгалзах зэрэг шаардлагуудаар **ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх арга механизмыг тодорхойлсон** байдаг. **Прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад ашиг сонирхлын зөрчилдөөн үүсвэл хуульд заасан үндэслэл журмын дагуу татгалзан гарах үүрэгтэй. Тухайлбал, Монгол Улсын ЭБШХуулийн 49, 53 - р зүйлд прокурорын татгалзан гарах үүргийн талаар тусгасан байгаа.**

Гэтэл хүссээр байгаад ийм байдалд орох нь хуульчийн ёс зүй зөрчсөн, үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй асуудал болно.

Иймд үйл ажиллагаандаа болон нийгмийн бусад харилцаанд орохдоо прокурор мэргэжлийнхээ ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, өөрийн зан үйл, үйл ажиллагаандаа эргэлзээ төрвөл мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Прокурорын ёс зүй ямар онцлогтой вэ?
- Прокурорын ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудын талаар ярилцана уу.
- Хяналтын чиг үүрэгтэй холбоотой ёс зүйн хэм хэмжээ гэж юу вэ?
- Прокурорын хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн хүрээнд баримтлах ёс зүйн ямар хэм хэмжээнүүд байдаг вэ?
- Прокурорт улс төрийн ямар хязгаарлалтууд байдаг вэ?
- Прокурорын байгууллагаас ёс зүйн ямар шаардлагуудыг тавьдаг вэ?
- Прокурор ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх боломжуудын талаар ярилцана уу.

2.6. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Сэдвийн зорилго: *Шүүгчийн ёс зүйн ойлголт, ёс зүйн хэм хэмжээ, зарчил, онцлогийн талаар цэгцтэй мэдлэг эзэмших, шүүгчийн мэргэшлийн үйл ажиллагаанд хуульзүйн болон ёс зүйн хэм хэмжээний үүднээс тайлбар хийх чадвар эзэмшихэд оршино.*

НЭРТОМЬЁО:

- Шүүгч
- Шүүгчийн ёс зүй
- Шүүн таслах ажиллагаа
- Хөндлөнгийн байр суурь
- Шүүгчийн нэр хүнд

“Ардчилсан бүгд найрамдах засаглалтай улсад хүмүүс хуулийг хэрэглэх замаар үр шимийг нь хүртэж, түүгээр хамгаалуулахыг эрмэлзэх цорын ганц зам бол шүүгчид ийм боломжийг хангаж, хэрэгжүүлэхэд оршино. Хэрэв хууль, шүүхийн тогтолцоо нь хүмүүсийн эрх ашгийн эсрэг ажиллах буюу ийнхүү ажиллаж байгаа мэт ойлгогдвол хууль тогтоомж хүмүүсийн эрх чөлөөг хамгаалах арга хэрэгсэл байхаа больж, ардчилсан бүгд найрамдах засаглал нуран унана”. Алексис Де Токвиль.

ШҮҮХ ЭРХ МЭДЭЛ БА БА ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Иргэний эрх, эрх чөлөө нь хар аяндаа ирдэг заяа төөрөг биш учир иргэний эрх, эрх чөлөөг нийгэмд бодит зүйл болгон төлөвшүүлэхэд нэг талаас ардчилсан төрийн институт, нөгөө талаас хараат бус шүүх эрх мэдлээр хамгаалуулсан жинхэнэ бат бэх хуулийн тогтолцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Төрийн байгууллага, албан тушаалтан нь хууль зөрчиж, иргэний эрх, эрх чөлөөнд халдсан гэж үзвэл иргэд нь тухайн төрийн байгууллага, албан тушаалтны талаар шүүхэд хандах боломжтой байдаг бөгөөд энэ нь эрх зүйт төрийн шинж юм. Эрх зүйт төрд эцсийн шийдвэр гаргадаг зангилаа нь шүүх байдаг учир шүүх эрх мэдлийг бие даасан, шүүхийг хараат бус байлгаснаар улс төрийг хууль зүйн арга хэрэгслээр хазаарлах боломжтой.

Гэхдээ шүүх хараат бус байна гэдэг нь түүнийг огт хяналтгүй орхино гэсэн үг бас биш юм. Шүүх нь нэг талаас нийгэмд шударга ёсыг тогтоогч төрийн эрх мэдлийн нэг институт мөн боловч нөгөө талаас энэхүү эрх мэдлийг хэрэгжүүлэгч хувь хүмүүсийн бодитой үйл ажиллагаа байдаг. “Хэн дор эрх мэдэл байна, түүн дор хилэнц байна” гэсэн эртний мэргэдийн онч цэцэн үг шүүгчдийг ч мөн



тойрохгүй учир хүний эрх чөлөөний баталгаа болсон шүүх эрх мэдлийг зүгээр л түүнд ажиллаж буй хувь хүмүүсийн дур зоргод найдаад орхих бус, харин ухаалаг боловсруулсан ёс зүйн хэм хэмжээгээр баглах нь чухал.

Тэгэхлээр шүүгчийн ёс зүй нь шүүхийн хараат бус, бие даасан байдлын баталгаа төдийгүй шүүх эрх мэдлийн хэвийн үйл ажиллагааг хадгалж, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэглүүр гэж хэлж болно.

Шүүгчийн ёс зүйн тухай ойлголт


“Ёс зүйгүй хүнд шүүх эрх мэдлийг шилжүүлнэ гэдэг нь галзуу хүнд буу өгсөнтэй адил”

Шүүгчийн буруутай үйл ажиллагааны үр дүнг шүүгч өөрөө биш, маргалдагч талууд буюу иргэд нэр төр, эрх, эрх чөлөө, эд хөрөнгөөрөө төлөх учир шүүгчийн ёс зүй гэдэг нь нэг талаас шүүгчийн үүргээ ухамсарласан хувийн соёл, нөгөө талаас маргалдагч талуудаас тавьж буй нийтлэг шаардлагаас урган гарсан хэм хэмжээ юм. Энэхүү шаардлагыг шүүгчийн зан үйлийг журамласан үнэт зүйлс бүхий хэм хэмжээний тогтолцоо буюу шүүгчийн ёс зүй гэж хэлж болно.

Шүүгчийн ёс зүйн үнэт зүйлс нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үндэс болсон хараат бус, хөндлөнгийн байх, шударга байж алагчлалгүй хандах зарчмуудаас бүрдэж байдаг.

Шүүгч энэ ёс зүйн хэм хэмжээгээ сайн сахиж, мөрдөж чадваас иргэдийн эрхээ шүүхээр хамгаалуулах сэдлийг өдөөж, шүүхэд итгэх итгэлийг сэргээж, үүгээрээ дамжуулан хууль дээдлэх үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Шүүгчийн ёс зүйн онцлог



Хэдийгээр хууль зүйн мэргэжлийн тогтолцоо нь бүхэлдээ эрх зүйт ёсыг төлөвшүүлэхэд чиглэгддэг боловч өөр өөрсдийн хуулиар ногдуулсан чиг үүргийн дагуу шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог. Шүүн таслах үйл ажиллагаа нь хамгийн ерөнхий байдлаар өмгөөлөх (хувийн өмгөөлөл), яллах (эсхүл нийтийн өмгөөлөл), шүүх гэсэн гурван үндсэн чиг үүргийг агуулдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөх чиг үүргийг иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлдэг мэргэжлийн өмгөөлөгч гүйцэтгэдэг бөгөөд яллах, гэм бурууг тогтоох чиг үүргийг прокурор хэрэгжүүлдэг бол иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд ихэнхдээ хувийн эрх ашгийг өмгөөлөх ажиллагаа явагдаж байдаг. Харин захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг талаас хувийн эрх ашгаа хамгаалан иргэд, хуулийн этгээд, түүнийг өмгөөлөх ажиллагаа явагддаг бол нөгөө талаас төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нийтийн эрх ашгийг төлөөлөн оролцож байдаг.

Өмгөөлөгч, прокурор нь шүүх эрх мэдлийн оролцогч бөгөөд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд тусалдаг бол шүүгч хөндлөнгийн байр сууринаас эрх зүйн үнэлгээ өгч, эцсийн шийдвэрийг гарган шүүх эрх мэдлийг удирдан хэрэгжүүлдэг. Эндээс л түүний мэргэшлийн ёс зүйн онцлог урган гардаг. Шүүгч нь хувийн болон нийтийн эрх ашгийн өмгөөллийн дундаас шударга ёсыг тогтооход оролцдог учир маргалдагч талуудад шүүхийн өмнө ялах адил тэгш боломжоор хангаж, алагчлалгүй хандах, төвийг сахисан байх, шударга байх зэрэг гагцхүү түүний чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамаатай ёс зүйн хэм хэмжээ үйлчилдэг.

СЭДВИЙН ХҮРЭЭНД ТАВИГДАХ АСУУЛТ:

- Шүүгчийн ардчилсан нийгэмд гүйцэтгэх чиг үүргийн талаар дахин ярилцана уу.
- Хүний эрхийг хамгаалахад шүүгч нь ямар үүрэгтэй оролцдог вэ?
- Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ гэж юу вэ?
- Шүүгчийн ёс зүй хуульчийн бусад мэргэжил болох өмгөөлөгч, прокурорын ёс зүйгээс ямар онцлогтой вэ?

ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ҮНЭТ ЗҮЙЛС БА ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ

Хэдийгээр шүүгч шударга байх тухай үзэл сургаал нь хамгийн эртний хууль, ном зохиолд таарах ч шүүгчийн ёс зүйг хүний эрх, эрх зүйт ёсны үзэл баримтлалаас авч үзэх хандлага нь орчин үеийн эрх зүйн түүхтэй холбогддог. Ялангуяа, дэлхийн II дайны дараа шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлыг хангах нь хүний эрхийг хамгаалах чухал хөшүүрэг гэдгийг хүн төрөлхтөн хүлээн зөвшөөрч, олон улсын эрх зүйн түвшинд чухалчлан авч үзэх болжээ. Үүний тод илрэл нь НҮБ - ын Ерөнхий Ассамблейн 217 /А/ III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Хүний эрхийн



түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй”, 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” хэмээн хараат бус, хөндлөнгийн, шударга шүүхээр шүүлгэх хүний эрхийг тунхагласан нь орчин үеийн шүүгчийн ёс зүйн хэм хэмжээний үндэс болжээ.

Үүний дараа 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр НҮБ - ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактыг баталж, 1976 оны 3 дугаар 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд энэхүү пактын 14 дүгээр зүйлд “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” хэмээн шударга, хараат бус, хөндлөнгийн шүүхийн үзэл баримтлалыг олон улсын эрх зүйн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ болгон баталгаажуулсан

Хүний эрхийн дээрх томоохон олон улсын баримт бичгүүдэд үндэслэн мөн НҮБ - ын 1985 онд хуралдсан 7 дугаар чуулганаар “НҮБ - ын Шүүхийн Хараат бус Байдлын Үндсэн Зарчим” хэмээх томоохон баримт бичгийг баталж, шүүгчийн хараат бус байдлын үндэслэлийг заажээ.

2001 онд Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх шүүгчдийн бүлгээр дэмжигдэж, хожим 2002 оны 11 сарын 25-наас 26-ны хооронд Хаг дахь Энх тайвны ордонд Ерөнхий Шүүгч нарын дугуй ширээний уулзалтаар хэлэлцэгдэж, тухайн хуралд оролцсон 81 улсын Ерөнхий шүүгч нарын саналаар баталсан “Шүүгчийн ёс зүйн Банглорын зарчим” нь эдүгээ шүүгчийн ёс зүйн үнэт зүйлсийг тусгасан чухал баримт бичиг хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, олон улсад дотоодын шүүгчийн ёс зүйн дүрмийг энэхүү зарчимд тулгуурлан шинэчилж байна. Энэхүү баримт бичигт шүүгчийн ёс зүйн дараахь үндсэн зургаан зарчмыг тунхагласан байна. Үүнд:

- Хараат бус байх;
- Хөндлөнгийн байх;
- Чадварлаг хичээнгүй байх.



- Шударга байх;
- Зохистой байх;
- Тэгш байх;

Шүүхийн бие даасан, хараат бус байдал нь хууль зүйн зайлшгүй шаардлагатай асуудал бөгөөд шүүхийн үйл ажиллагааг шударга явуулах үндсэн баталгаа мөн. Шүүгч нь хүний хувьд мөн байгууллагын гишүүний хувьд шүүхийн хараат бус, бие даасан байдлыг чанд хадгална.

Шүүгчийн хараат бус байдлын хүрээнд дараах хэдэн зүйлс багтана:

- Шүүгч хэргийг шийдвэрлэхдээ бодит үйл баримтад тулгуурлан үнэлж, хуулийн заалтыг бүрэн ойлгон шүүх эрх мэдлээ бие даан хэрэгжүүлэх ба гадны аливаа нөлөө, дарамт, шахалт, заналхийлэл шууд буюу шууд бус оролцоогүйгээр үүргээ гүйцэтгэнэ.
- Шүүгч олон нийтийн үйл ажиллагаа, тодорхой нам хүчнээс хамааралгүйгээр маргааныг шийдвэрлэнэ.
- Шүүгч хууль тогтоогч болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай зохистой харилцах бөгөөд тэдний нөлөөлөлд автахгүй байх үүрэгтэй.
- Бусад шүүгч нараас хараат бус байж шийдвэрийг бие даан гаргана.
- Шүүх байгууллагын болон шүүгч өөрийн үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлж, өөртөө итгэлтэй, тууштай үүргээ биелүүлнэ.
- Шүүгч шүүхийн стандартыг хэрэгжүүлэхдээ бусдад үлгэр дууриал болохуйц байж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн шүүхийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэхэд анхаарна.

Шүүгч хөндлөнгийн байх нь хэргийн оролцогчдоос хамааралгүй байх тухай бол хараат бус байх нь нийгмийн бусад институтээс хамааралгүй байх тухай юм. Энэ утгаараа хөндлөнгийн байх нь шүүх хуулийн дагуу үүргээ биелүүлэх чухал урдчилсан нөхцөл мөн. Энэ нь дан ганц шүүхийн шийдвэрт бус мөн шүүхийн шийдвэрийг гаргах үйл явцад хамааралтай.



Банглорын зарчимд хөндлөнгийн байх үзэл баримтлалыг тусгасан нь:

- Шүүгч үүргээ хэрэгжүүлэхдээ шударга бус, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхлаас ангид байна.
- Шүүгч шүүхийн танхим болон шүүх ажиллагаанаас бусад аль ч үед хуулийн мэргэжлийг хүндэтгэн нийгэмд итгэл төрүүлэхүйц биеэ авч явах бөгөөд хэргийн оролцогчид шүүгч болон шүүхийн байгууллагын хараат бус байдлыг өөрийн үйлдлээр илэрхийлэн бэхжүүлнэ.
- Шүүгч нь шүүх хурлыг удирдах явуулах, шүүхийн шийдвэрийг гаргахдаа мэргэжлийн алдаа гаргахгүй байж, хэргийг шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргахад хүргэх үйлдлийг гаргахгүй байх учиртай.
- Шүүгч нь шүүх хурлын үед болон шүүгч хүний зүгээс хуралдааны үйл явцыг шударга шийдвэрлэхэд нөлөөлөхүйц аливаа мэдэгдэл, тайлбарыг санаатайгаар хийхийг хориглоно. Нийтэд болон бусдад хэн нэгний эсхүл аливаа үйлдэлийн талаар шударга шийдвэрлэхэд нь нөлөөлж болох ямарваа мэдэгдэл, тайлбар хийхийг хориглоно.
- Шүүгч аливаа хэргийг шударгаар шийдвэрлэх боломжгүй, эсхүл шийдвэр гаргах боломжгүй тохиолдолд орсон гэж өөрийгөө үзсэн бол шүүх хуралд оролцохоос татгалзах зэргийг тусгасан байна.

Шүүгч шударга байх гэдэг нь хараат бус, хөндлөнгийн байх, талуудад алагчлалгүй хандах зэрэг ёс зүйн зарчмуудтай нягт уялдаатай бөгөөд илүү ёс суртахууны агуулгатай. Банглорын зарчимд:

- Шүүгч нь шүүх байгууллагын үйл ажиллагааны чухал зүйл болох шүүхийн хараат бус байдлыг өөрийн үйл ажиллагаанд удирдлага болгох үүднээс бодит байдлыг ажиглан, дүгнэлт хийнэ.
- Шүүгч өөрийн үйл ажиллагаа, зан байдлаар бусдын шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллана гэсэн хоёр үндсэн нөхцөлийг заасан байна.

Зохистой байх: Шүүгчийн ёс зүй нь зөвхөн шүүх танхим, ажлын байраар хязгаарлагдахгүй, олон нийтийн газар биеэ авч явахаас авахуулаад нийгмийн бусад харилцаанд оролцоход хамааралтай, өргөн хүрээтэй ойлголт юм. Тиймээс шүүгч нь өөрийн бүхий л үйл ажиллагаа, үйлдэлд зүй зохисгүй байдал гаргахгүй байх үүрэгтэй.

Энэ хүрээнд Банглорын зарчимд олон зүйл тусгаснаас дараах зүйлс нэлээд чухал юм :

- Олон нийтийн өмнө өөрийн ухамсараар жирийн иргэний хувьд зохисгүй гэж дүгнэгдэх үйлдэл хийхгүй байх үүрэгтэй.
- Шүүгчийн гэр бүлийн хэн нэгний төлөөлөн оролцож буй, эсхүл гэр бүлийн хэн нэгэнтэй холбоотой хэргийг шүүх ажилд оролцох эрхгүй.
- Шүүгч бусад иргэний адил үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх эрхтэй боловч энэ эрхээ хэрэгжүүлэхдээ шүүх байгууллагын нэр хүндийг хамгаалан, шүүгчийн бие даасан, хараат бус байдлыг чанд сахина.
- Шүүгчийн бүрэн эрхийнхээ хүрээнд олж авсан нууц мэдээллийг өөрийн ажил үүргээс бусад тохиолдолд задлах, бусдад дамжуулах, мэдээлэхийг хатуу хориглоно.
- Шүүгчийн үйл ажиллагаанд нь хамааралтай зохих шагнал урамшуулал авах эрхтэй боловч олон нийтийн анхаарлын төвд байнга хараа хяналтад байдгаа ухамсарлаж, аливаа шагнал урамшуулал нь шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөхөөр бол татгалзах үүрэгтэй зэрэг чухал зарчмуудыг тусгасныг дурьдаж болно.

Тэгш байх буюу тэгш хандах нь шүүгчийн ёс зүйн чухал бүрэлдэхүүн хэсэг нь юм. Шүүгч маргаанд оролцож буй талуудад тэгш хандаагүй тохиолдолд хэрэг маргааныг шударга шүүж, шийдвэрээ гаргасан гэж дүгнэх боломжгүй. Энэ нь зөвхөн шүүн таслах ажиллагааны хүрээнд, хэргийн оролцогчоор хязгаарлагдахгүй, нийгмийн харилцаанд оролцохдоо ч бусдыг ялгаварлан гадуурхсан аливаа зан үйл хийхгүй байхад хамааралтай.

Тэгш байх зарчмыг заримдаа алагчлалгүй хандах гэж томъёолдог бөгөөд шүүгч:

- Үндэс угсаа, гарал үүсэл, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн байдал, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, бэлгийн чиг хандлага, нийгмийн болон эдийн засгийн байдал болон бусад асуудлаарх үзэл бодол, өөрчлөлт, хандлагын талаар мэдлэг, мэдээлэл, ойлголттой байх;
- Өөрийн үүрэгт ажлаа гүйцэтгэж байхдаа үг хэл, үйлдлээрээ аливаа этгээд, хэсэг бүлгийг ялгаварлан гадуурхаж, үл хүндэтгэсэн байдал гаргахгүй байх;
- Оролцогчид, гэрч, хуульч, өмгөөлөгч, шүүхийн ажилтан, хамтран зүтгэгч зэрэг хүн бүрт журамтай, зохистой байдлаар, ялгаварлалгүйгээр харилцах ёстой.



“Шүүгчийн хараат бус байдлыг хангахын тулд бүх насаар нь томилдог” нь шүүгч энэ байдалдаа сэтгэл ханаж, өөрийгөө хөгжүүлэхгүй орхино гэсэн үг биш юм. Нийгмийн харилцааны хөгжлийг даган хууль, тогтоомж байнга өөрчлөгдөж байдаг тул шүүгч өөрийгөө хөгжүүлэхэд байнга анхаарч, мэдлэг, чадваргүй байдлаас чөлөөлөгдөх ёстой. Энэ нь хараат бус байдлын баталгаа болж байдаг тул шүүгч **чадварлаг, хичээнгүй байх ёстой**.

Банглогрын зарчимд тусгагдсан хэд хэдэн зүйлээс заримыг нь чухалчлан авч үзвэл:

- Шүүгч нь өөрийн мэргэжлийн ур чадварыг шүүн таслах үйл ажиллагаанд бүрэн зориулах ба үүнд шүүн таслах, шийдвэр гаргах үүрэг хариуцлага төдийгүй, шүүхийн байгууллагатай холбоотой бүхий л үйл ажиллагаа хамаарна.
- Өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, шүүн таслах үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хувийн зан чанараа сайжруулахад ямагт анхаарах үүрэгтэй ба шүүх байгууллага, шүүгч нарын дунд зохион байгуулагдах сургалтад хамрагдах эрх, үүрэгтэй.
- Олон улсын хууль, гэрээ, конвенц болон хүний эрхийн хэм хэмжээг тогтоосон бусад баримт бичгүүд, холбогдох өөрчлөлтүүдийн талаар тогтмол мэдээлэлтэй байх ёстой.
- Шүүх хурлыг дэг журмын дагуу явуулах ба хэргийн оролцогчид, иргэдийн төлөөлөгч, гэрч, хуульч, өмгөөлөгч болон бусад этгээдтэй харилцахдаа найрсаг, тэгш, хүндэтгэлтэйгээр хандаж, тэвчээртэй, ёс зүйтэй, энгийн байна.

СЭДВИЙН ХҮРЭЭНД ТАВИГДАХ АСУУЛТ:

- Шүүгчийн ёс зүй нь олон улсын ямар баримт бичгүүдээс үүдэлтэй вэ?
- Шүүгчийн ёс зүйн Банглогрын зарчимд ямар үнэт зүйлс, зарчмуудыг тусгасан бэ? Тэдгээрийн харилцан хамаарлыг тайлбарлана уу?
- Шүүгч хараат бус байх, хөндлөнгийн байх зарчмын ялгаа?
- Шүүгчийн зохистой байх нь яагаад чухал зарчим бэ?
- Шүүгчийн хувцаслалт биеэ авч явах байдалтай холбогдох уу?

СЭДВИЙН ХҮРЭЭНД ХАМААРАХ БОДЛОГО

Бодлого 1. Иргэний хэргийн 1-р тойргийн шүүхэд иргэний эрх зүйн мэдлэгээр маруухан шүүгч ажиллаж байсан бөгөөд удахгүй тэтгэвэрт гарах болсон байжээ. Тиймээс шүүгчдийн зөвлөлгөөнөөр хэлэлцээд түүнд хэргийг хуваарилахгүй байхаар шийдвэрлэжээ.

Асуулт: Шүүгчдийн зөвлөлгөөний тогтоол шүүгчийн хараат бус байдлыг зөрчсөн үү? Банглогрын зарчмын үүднээс тайлбарлана уу.

МОНГОЛ УЛС ДАХЬ ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд 14 дэх хэсэгт “...шударга шүүхээр шүүлгэх...” гэж, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” хэмээн **“шүүхийн үйл ажиллагааны үндсэн зарчим” - ыг тодорхойлжээ.**

Шударга шүүхээр шүүлгэх гэдэгт нэг талаас шүүн таслах ажиллагаа нь хуульд заасан журмын дагуу явагдсан байхын зэрэгцээ нөгөө талаас тухайн шүүн таслах үйл ажиллагааг удирдан явуулж байгаа шүүгч нь хууль болон ёс зүйн шаардлага хангасан байхыг бүхэлд нь хамруулдаг. Тиймээс шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ нь иргэний Монгол Улсын Үндсэн хуульд заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад чухал үүрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуульд шүүгч татгалзан гарах зохицуулалтыг тусгасан байдаг. Тухайлбал, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 64 дүгээр зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал шүүгч тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай зохицуулсан нь “иргэний шударга шүүхээр шүүлгэх” эрхийг хамгаалсан зохицуулалтууд юм.

Гэхдээ шүүгчийн ёс зүйн үнэт зүйл, хэм хэмжээг Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүгчийн ёс зүйн дүрмээр илүү нарийвчлан зохицуулдаг бөгөөд шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг дараах үндсэн хэсэгт хувааж болно.

ШҮҮГЧИЙН БИЕ АВЧ ЯВАХ ЁС ЗҮЙ

Ардчилсан нийгмийн хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэгч шүүгч нь энэхүү өндөр хариуцлагатай албан тушаалдаа ямагт хүндэтгэлтэй хандаж, өөрийн үйл ажиллагаагаар шүүх эрх мэдлийн нэр төрийг хадгалж, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх үүрэгтэй. Шүүгч биеэ хэрхэн авч яваагаас олон нийт шүүх байгууллагыг бүхэлд нь дүгнэх хандлагатай байдаг тул түүнд дараах хязгаарлалтууд зүй ёсоор тавигддаг. Үүнд:

- Шүүгчийн хувьд мөрдвөл зохих зарим эрхийн хязгаарлалтыг мэдэрч, сахин биелүүлэх;
- Бусдын зан төлөв, ёс суртахуун, нэр төр, алдар хүндийн талаар эс тодорхойлох;



- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй мөрдөх;
- Хэрэг маргаан шүүхээр хянан шийдлэрлэгдэх гэж байгаа хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, найз нөхөд, садан төрлийн хүмүүстэй хувийн харилцаанд орохгүй байх;
- Хувийн зүгээс хийж буй аливаа үйл ажиллагаандаа шүүгч, шүүхийн нэр хүндийг ашиглахаас зайлсхийж, асуудалд зөвхөн иргэний байр сууринаас хандах зэрэг болно.

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ШААРДЛАГА

Шүүгчийн хувьд шүүн таслах ажиллагаа хамгийн чухал ажил учир бусад ажлаас ямагт илүүд үзэж, мэргэжлийн өндөр түвшинд хуульд заасан журмын дагуу явуулах, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхдээ ёс зүйн дараах зарчмуудыг хангаж ажиллах үүрэгтэй. Үүнд:

- Хэргийн оролцогчидтой тэгш, ялгаварлалгүй харилцах;
- Хэргийн оролцогч болон бусад хүмүүстэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлахгүй байх;
- Эцэслэн шийдлэрлэгдээгүй байгаа хэрэг маргааны тухай, талуудын тавьсан үндэслэл, гаргах шийдвэрийн талаарх саналаа урьдчилан илэрхийлэхгүй, нийтэд мэдээлэхгүй байх;
- Хэрэг маргааныг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, хуульд зааснаас өөр шалтгаан, үндэслэлээр хэргийн шийдвэрлэлтийг удаашруулах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдааныг хойшлуулахгүй байх зэрэг үүргийг сахих ёстой.

ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА БА ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Шүүгч нь багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх болон хуульд заасан бусад аргаар орлого олох эрхтэй ч энэ эрх нь хязгаарлагдмал бөгөөд өөрийн болон гэр бүлийнхээ орлого, төлбөр, хөрөнгө оруулалтын талаар зохих журмын дагуу үнэн зөв мэдүүлж байх үүрэгтэй.

Мөн шүүгч нь хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд бэлэг авч болно. Гэхдээ шүүхэд ашиг сонирхол нь ямар нэгэн байдлаар хөндөгдөж байгаа аливаа байгууллага, этгээдээс үнэ цэн бүхий аливаа зүйлийг нэхэн шаардах буюу хүлээн авах, үйлчилгээг нь хүртэхийг хориглодог.

УЛС ТӨР БА ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ

Шүүх эрх мэдэл нь зарим тохиолдолд улс төрийг хууль зүйн арга хэрэгслээр хянахад чиглэж байдаг учир шүүгч улс төрийн ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой. Үүнд дараах үйл ажиллагааг хамруулдаг:

- улс төрийн аливаа байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх;
- улс төрийн байгууллага, нэр дэвшигчийг дэмжиж эсвэл эсэргүүцэж нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь суратлчилгаанд аливаа хэлбэрээр оролцох;
- улс төрийн байгууллага, нэр дэвшигчид санхүүжилт олж өгөхийг эрмэлзэх, хандив өгөх.

Хэрвээ шүүгч улс төрийн сонгуульд аль нэг намаас буюу бие даан нэр дэвшихээр шийдсэн бол сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж, зохих журмын дагуу шийдвэрлүүлсэн байх ёстой.

ШҮҮГЧЭЭС ОЛОН НИЙТИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ НЬ

“Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүч шүүгчийн шийдвэрт нөлөөлдөг” гэсэн сэтгэгдлийг нийгэмд төрүүлж болзошгүй байдаг тул шүүгч нь ёс зүйн хяналтыг хэрэгжүүлэх институтын нэг болох олон нийтийн хэвлэл мэдээлэлтэй харилцахдаа ёс зүйн хэм хэмжээгээ чанд баримтлах ёстой ба хэвлэл мэдээллийн хэрэгслийг өөрийгөө магтах зорилгоор ашиглаж болохгүй.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдсан шүүгчийн талаарх санал шүүмжлэл үндэслэлтэй бөгөөд шүүгч ёс зүйн дүрмийг зөрчсөн байвал энэ нь түүнд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болдог. Хэрвээ шүүгчийн талаар цацагдсан мэдээ, нийтлэл үндэслэлгүй бол тухайн шүүгч, эсвэл түүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага харьяалах шүүхэд хандаж шүүгчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэх, эд хөрөнгийн бус гэм хорын хохирлыг арилгуулахыг шаардах эрхтэй.



ШҮҮГЧИД ХОРИГЛОХ ЗҮЙЛС

Дараах үйл ажиллагаа нь шүүгчид итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулж, шүүгчийг ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй байдаг тул ёс зүйн хэм хэмжээгээр хориглодог. Үүнд:

- Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх;
- Арьс өнгө, яс үндэс, нас, хүйс, нийгмийн байдал, гарал, үүсэл, хөрөнгө, чинээ, үзэл бодол, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах үйл ажиллагаа явуулдаг аливаа төрийн бус байгууллагын гишүүн байх, үйл ажиллагааг нь дэмждэг талаар нийтэд илэрхийлэх;
- Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, өмчийн аливаа хэлбэрийн их дээд сургууль, коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох;
- Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгохоос бусад асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орох.

СЭДВИЙН ХҮРЭЭНД ТАВИГДАХ АСУУЛТ:

- Монгол Улсын хууль тогтоомжид шүүгчийн ёс зүйн талаар хэрхэн тусгасан бэ?
- Шүүгчийн татгалзан гарах үндэслэл, тэдгээрийн талаар нэг бүрчлэн ярилцана уу.
- Шүүгчийн биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ яагаад зайлшгүй вэ? Энд ямар шаардлагууд тавигддаг вэ?
- Шүүгчийн шүүн таслах ажиллагаанд тавигддаг ёс зүйн шаардлагыг тайлбарлана уу?
- Шүүгчийн шүүн таслах ажиллагаанаас гадуур тавигддаг шаардлагуудад ямар шаардлагууд багтдаг вэ?
- Шүүгчийг улс төрийн үйл ажиллагаанаас ангид байлгах үндэслэлийг талаар ярилцана уу.
- Шүүгчид хориглох зүйлсийг нэг бүрчлэн ярилцана уу.

СЭДВИЙН ХҮРЭЭНД ХАМААРАХ БОДЛОГО

Бодлого 2. А хууль зүйн сургуулийг төгссөн шүүгчид А хууль зүйн сургуулийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох хэрэг хуваарилагдсан байна. Энэ үед А хууль зүйн сургуулийн төгсөгчдийн хүлээн авалтад шүүгчийг төгсөгчийн хувьд урьсан байна. Уг арга хэмжээг ТВ - ээр шууд дамжуулахаар төлөвлөсөн байна.

Асуулт: Та уг арга хэмжээнд оролцох уу?

Бодлого 3. А, Б компаниуд нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, бизнесийн салбарт өрсөлдөгч тээврийн компаниуд. Та А компанид тодорхой хэмжээний хувьцаа эзэмшдэг байв. Гэтэл төрийн захиргааны байгууллагаас Б компанийн тээврийн тусгай зөвшөөрлийг цуцалсныг эс зөвшөөрч гаргасан Б компанийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг Таньд хуваарилагджээ.

Асуулт: Та ямар шийдвэр гаргах вэ ?

Хариултын хувилбар:

- а. Хуульд ийм үндэслэлээр татгалзан гарах зохицуулалт байхгүй учир хэргийг шийдвэрлэнэ.
- б. Татгалзах нь зүйтэй. Учир нь....

Бодлого 4. Б нь өмнө нь Г шүүгчийн туслахаар 3 жил ажиллаж байгаад Т ХХК-д хуулийн зөвлөхөөр ажиллах болжээ. Гэтэл С ХХК нь Т ХХК-г гэрээний үүргээ зөрчсөн гэсэн үндэслэлээр шүүхэд өгсөн бөгөөд Г шүүгч хэргийг шийдвэрлэхээр болсон байна.

Асуулт: Б шүүгч болон Г нарын хороондын өмнөх харилцааг хувийн харилцаатай байсан гэж үзэх үү. Энэ нь Б шүүгч уг хэргээс татгалзан гарах үндэслэлтэй юу?



III БҮЛЭГ.

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

Бүлгийн зорилго: Мэргэжлийн болон хувийн ашиг сонирхол зөрчилдсөн тохиолдолд цаг тухайд нь тодорхойлж, асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх чадвар эзэтишүүлэх.

3.1. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Сэдвийн зорилго: Ашиг сонирхлын зөрчил, ацан шалааны талаар цэгцтэй тэдлэгтэй болж, мэргэжлийн үйл ажиллагаандаа эрх зүйн болон ёс зүйн үүднээс дүн шинжилгээ хийх чадвар эзэмших, хуульчийн ёс зүйн дадалтай болоход оршино.

НЭР ТОМЬЁО:

- Ашиг сонирхол
- Зөрчилдөөн
- Дилемма
- Ацан шалаа

НИЙГМИЙН ЁС ЗҮЙН ТОЙРОГ БА МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ТОЙРОГ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Нийгэмд сайн хэмээн хүлээж авдаг, сайхан үр дүн гарах, хүмүүс дагаж дууриавал зохих биеэ авч явах байдал, бодол санаа, зан чанар бол нийгмийн үнэт зүйлс байдаг. Энэхүү үнэт зүйлсээс хувь хүн өөрийгөө олж сайн гэх зан чанаруудыг эрхэмлэж өөрийн төлөвшилийг олдог. Ингэхдээ зан суртахууны эерэг ба сөрөг ойлголтуудаар ёс зүйн ба ёс зүйн бус үнэлэмжийг бусдаас авч өөрийгөө мөн ажил хэргийн нэр хүндээ үнэлүүлдэг. Мэргэжлийн хувьд дагаж мөрдөх ёс зүйн шаардлага, дүрэм, журам ч бас нийгмийн үнэт зүйлсэд суурилсан байдаг. Ямар ч мэргэжлээр ажилласан гэсэн “мэргэжлийнхээ үүрэг, хариуцлагын ухамсарлаж, мэргэжлийн онцлог дагаж мөрдөх шаардлагыг биелүүлэх ёстой” болдог. Нийгмийн тойргоос улбаалсан сайн чанарууд, тухайлбал, зориг, тэвчээр, энэрэнгүй байх, даруу зан, шударга байх, өөрийгөө үл хайрлах, хүндэтгэлтэй байх гэсэн чухал үнэт зүйлс нь муу үр дагавартай хэцүү сонголтуудаас гарах арга замыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Хувь хүний мөн чанар нь янз бүр учир хүний мөн чанартай холбоотой уурлах, гэмших, өрөвдөх зэрэг сэтгэл хөдлөлүүд, тэрчлэн шунал, тачаал, ахиж дэвших гэсэн хүсэл зэрэг өөрийн зан чанараа дагаж давж гарахгүйгээс мэргэжлийн ёс зүйтэй зөрчилдөх нь ашиг сонирхлын зөрчлийг бий болгож, ёс зүйн бус асуудлуудыг гаргах далд хор хөнөөлийг бий болгодог. Үүнийг ацан шалаа ба диллема гэж тодорхойлдог байна.

Ёс зүйн бус асуудлууд: “Ёс зүйг зөрчих үйлдлийг хийлгэхэд дотроос нь өдөөж байдаг хүчин зүйлс. Тухайлбал, хайрлах, үзэн ядах, өрөвдөх, өнгө мөнгөнд шунах, нэр төр, атаархал, хардалт зэрэг хамаарна. Эдгээр ёс зүйн бус хүчин зүйлс нь ёс зүйг зөрчихөд хүргэдэг байна. Хуульч мэргэжлийн хүрээнд дагаж мөрдөх ёс зүйн шаардлагаар шударга байх, хэргийг хуулийн хүрээнд шийдвэрлэх, хараат бус байх, хэн нэгний нөлөөнд автахгүй, хувийн харилцаа тогтоохгүй байх, хэрэв хувийн харилцаатай, садан төрлийн хлбоотой, хэргийг шударгаар шийдвэрлэхэд эргэлзээ төрвөл хуульд заасны дагуу татгалзах зэрэг шаарлагуудаар ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх арга механизмыг тодорхойлсон байдаг. Гэтэл хүссээр ийм байдал орох нь хуульчийн ёс зүй зөрчсөн, үүрэг, хариуцлагаа ухамсарлаагүй асуудал мөн.

“Сонирхлын зөрчил гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн сонирхол нийтийн сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдал” гэж тодорхойлсоноос үзвэл:

“Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь албаны болон мэргэжлийн ашиг сонирхлоос амин хувийн ашиг сонирхлыг илүүд үзснээр бий болдог ёс зүйн бус асуудал юм”.

Жишээ нь: Шүүгч Д - гийн оюутан ахуйн найз нэг ангид хамт сурч байсан О шүүгчтэй уулзаж түүний дүүгийн хэрэг өөр дээр нь байгаа, шүүх хуралдаан нь зарлагдсан байгаа тул дүүгээ харж үзэхийг хүсч гуйгаад найздаа уулзаагүй удсан учраас гэж гарын бэлэг сэлт өгсөн байна. Шүүгч ч харж үзнэ хэмээн амалсан ба тэрээр найзынхаа гуйлтыг биелүүлж хэргийг нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

- Шүүгч ашиг сонирхлын зөрчилд орсон уу ? Ийм тохиолдолд найзыгаа гомдоох уу, эсвэл хуульчийн ёс зүйн хүрээнд дагаж мөрдөх хууль дүрмээ баримтлах уу гэдэг асуудал тулгарахад “хуульчийн ёс зүйг даган мөрдөх” эр зориг л хэрэгтэй.

Шүүгчийн ёс зүйн дүрмийн 7.2.2 - д “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хуулийн заалтыг хэлбэрэлтгүй мөрдөхийн зэрэгцээ урьд нь ойр дотно харилцаатай байсан хүмүүс, эсхүл өмнө нь ажиллаж байсан буюу эрх ашгийг нь ямар нэг хэлбэрээр хамгаалж байсан байгууллага, хуулийн этгээдийн хооронд үүссэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд оролцохгүй байх” мөн 7.2.3-д “Хэрэг маргаан нь шүүхээр шийдвэрлэгдэх гэж байгаа хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, найз нөхөд, садан төрлийн хүмүүстэй нь хувийн харилцаанд орохгүй байх” зэрэг хязгаарлалтыг хийсэн байгаа нь ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх шаардлага мөн.



Мөн нийгмийн сэтгэл зүй хүлээн зөвшөөрдөггүй гэхдээ хуульчид дагаж мөрдөх тойргийнхоо хүрээнд заавал дагаж мөрдөхөөс аргагүй тийм хүнд байдал ацан шалаанд ч ордог. Тухайлбал, өмгөөлөгчийн хувьд мэргэжлийн дагаж мөрдөх ёс зүйн шаардлагаар үйлчлүүлэгчийн эрх ашгийг тууштай хамгаалах, нууцыг хадгалах үүрэгтэй. Гэтэл нийгмийн сэтгэлгээ гэмт хэрэгтэнг үзэн ядаж, өмгөөлөгчийг өмгөөлж хамгаалах ёсгүй мэтээр ойлгож болно.

АНУ-ын хуулийн сургуулийн ёс зүйн хичээлд ашигладаг хийсвэр жишээг энд дурьдая.

Тохиолдол-1. “Утаа нь арилаагүй буу” Нэгэн өмгөөлөгчийн байнгын үйлчлүүлэгч Ц өмгөөлөгчийн өрөөнд маш их сандарсан байдалтай орж ирсэн ба утаа нь ч арилаагүй халуунаараа бууг өмгөөлөгчид сандран өгсөн. Өмгөөлөгч бууг авч гол руу хаясан. Үйлчлүүлэгч нь өмгөөлөгчид та бууны талаар юу ч битгий асуу гэсэн. Хэд хоногийн дараа нөгөө үйлчлүүлэгч өмгөөлөгчийн өрөөнд ирж хөршийнхөө амь насыг хохироосон хэрэгт сэжиглэгдэж байгаагаа хэлж өөрийгөө өмгөөлөхийг хүсэхэд өмгөөлөгч зөвшөөрсөн.

Энэ тохиолдолд хуульчдын сонгож хэрэглэж болох аргачлал чухал гэдгийг санаж өмгөөлөгч ёс зүй зөрчсөн эсэх болон дараах шийдлээс алийг нь сонгож ацан шалаанаас гарах боломжтой талаар ярилцана уу.

- Бууны талаар үйлчлүүлэгчээсээ асууна.
- Цагдаад бууны талаар үнэнээр нь ярьж мэдэгдэнэ.
- Үйлчлүүлэгчийнхээ гаргасан занг нууцлана.
- Огт буу байгаагүй юм шиг өмгөөлнө.
- Өөр санал байна.

Тохиолдол-2. Ашиг сонирхлын зөрчилдөөн ба диллема нь ёс зүйн бус асуудалд хүргэнэ. Тохиолдол тус бүрт ёс зүйн дүрмийн шаардлагаар дүгнэлт хийнэ үү?

- 2 жилийн өмнө үйлчлүүлж байсан үйлчлүүлэгчийн нь эсрэг тал болж байсан хүн таныг өөр хэрэгт өмгөөлж өгөхийг хүсчээ.
- Таны хуучин найз бүсгүй өөрийн чинь үйлчлүүлэгчийн эсрэг талд төлөөлөн оролцож байвал.
- Таны хуучин үйлчлүүлэгчийн амь насанд халдсан хэрэгт буруутгагдаж байгаа этгээдийг өмгөөлөх санал авсан бол.
- Үйлчлүүлэгчийн хүссэн зүйл таны бодлоор ой гутмаар зүйл боловч түүнд үүнийг хийх эрх нь хуулиар олгогдсон бол.
- Та үйлчлүүлэгчийнхээ хэргийг шийдвэрлэх гэж байгаа шүүгчтэй хайр сэтгэлийн холбоотой болсон тохиолдолд.

Тохиолдол-3. “Хурим”. Шүүгч өөрийн том охиноо боломжийн сайн залуутай гэр бүл болж байгаад сэтгэл ханамжтай байлаа. Хуримын урилгыг шүүгч өөрийнхөө болон эхнэрийнхээ нэрээр тараасан ч хүргэний талын олон найзууд уригдсан томоохон хурим гэртээ хийжээ. Ёслолын үеэр охин ямар ямар үнэтэй бэлэг авснаа аавдаа хэлжээ. Хамгийн сайхан бэлэг нь хүргэнийх нь найзын аялалаар Хавайн арал руу бүтэн 7 хоног явах зардлыг нь дааж өгсөн бэлэг байлаа. Шүүгч тэр даруй хүргэнийх нь тэр найз аялал зуучлалын компанитай нэгэний хэрэг шүүгч дээр байгааг санаж ирэх долоо хоногт болох шүүх хурлын нэхэмжлэгч гэдгийг таньсан.

- Шүүгчийн ёс зүйн үүрэг юу вэ ?
- Тэр охиноо аялалаас татгалзахыг шаардах ёстой.
- Тэр хэргээс татгалзана.
- Тэр нэхэмжлэгчтэй уулзаагүй ба түүнээс юу ч аваагүй учир ёс зүй зөрчөөгүй.
- Өөр хувилбар байна. Ашиг сонирхлын зөрчил байгаа эсэх талаар ярилцана уу?

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?
- Мэргэжлийн үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчлийн талаар нэг бүрчлэн ярилцана уу.
- Дилемма гэж юу вэ?
- Ацан шалааны нөхцөлд зөв шийдвэр гаргах талаар ярилцана уу.



3.2. ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

Сэдвийн зорилго: *Мэргэжлийн ёс зүйн зөрчил, түүний бүрэлдэхүүн, төрөл, хэлбэрийн талаар цэгцтэй мэдлэг эзэмших, ёс зүйн зөрчлөөс өөрийгөө сэргийлэх, мэргэжлийн ёс зүйн хэл хэмжээг баримтлах хандлага төлөвших, хуульчийн ёс зүйн дадалд сургах.*

НЭР ТОМЬЁО:

- Эрх зүйн зөрчил
- Ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа
- Мэргэшлийн онцлогоос үүдэн гарах ёс зүйн зөрчил

ЁС ЗҮЙН ЗӨРЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Монгол Улсын “Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм” - ийн 3 дугаар зүйлд: “Шүүгчийн ёс зүйн зөрчил гэж холбогдох хууль болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ.”, “шүүгчийн гаргасан зөрчил нь нийгмээс шүүх эрх мэдэл, шүүгчдэд итгэх итгэлийг бууруулах төдийгүй эрх зүйт төрийн нэр хүнд, хууль дээдлэх зарчимд хохирол учруулдаг учраас шүүгч бүр Үндсэн хууль, бусад хууль болон энэхүү дүрмийн хэм хэмжээнд захирагдах үүрэгтэй” гэж заасан. (“Холбогдох хууль зөрчсөн” гэдэг нь шүүгчийн хууль зөрчсөн үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинжгүй боловч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хуульд заасан үүрэгт ажлаа зориуд, эсхүл хайнга хандаж гүйцэтгээгүй байх, эсхүл эрх мэдлээ урвуулах буюу хэтрүүлэн хууль бус шийдвэр гаргах, нөгөө талаас шүүгч иргэнийхээ хувьд бүх хуулийг биелүүлэх үүрэгтэй ба хуулийг санаатай болон болгоомжгүйгээр зөрчихдөө шүүх, шүүгчийн нэр хүндийг ашигласан, унагасан, харш үйлдэл хийсэн байхыг ойлгоно)

“Прокурорын ёс зүйн дүрэм” - ийн 7 дугаар зүйлд “Прокурорын ёс зүйн зөрчил гэж энэ дүрмээр тогтоосон прокурорын ёс зүйн хэм хэмжээг санаатай буюу санамсаргүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдлийг хэлнэ” гэж,

МӨХолбооны 2001 оны 1 -р сарын 12 ны өдрийн Их хурлаар баталсан “Монголын өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” - ийн 17 -р зүйлд “өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, өмгөөлөгчийн нэр хүндийг гутаасан үйлдэл хийсэн тохиолдлыг сахилгын хариуцлага хүлээлгэх зөрчил гэж үзэх бөгөөд түүнд сахилгын буюу зан суртахууны нөлөөллийн арга хэмжээ хэрэглэнэ”, мөн Холбооны 2003 оны 9-р сарын 19-ны өдрийн Их хурлаар шинэчлэн баталсан “Монголын өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” - ийн 5 - р зүйлд “Мэргэжлийн ёс зүйн дүрмийг аливаа соёлт иргэншсэн нийгэмд хүлээн зөвшөөрдөг бөгөөд өмгөөлөгчид үүргээ хэрэгжүүлэх явдлыг хангах зорилгоор нийт өмгөөлөгч дагаж мөрдөнө. Өмгөөлөгч эдгээр хэм хэмжээг сахин биелүүлээгүй нөхцөлд сахилгын хариуцлага хүлээнэ” гэж тус тус заасан.

Ёс зүйн зөрчил ба эрх зүйн зөрчил, тэдгээрийн ялгаатай болон нийтлэг тал

Эрх зүйн зөрчил (анг.violation of law; ор. правонарушение) - ямар нэгэн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлийг тэмдэглэсэн төрлийн шинжтэй ухагдахуун. Дараах эрх зүйн зөрчил байдаг: иргэний (бие махбодид болон иргэний буюу байгууллагын эд хөрөнгөд гэмт хор учруулсан), захиргааны (жишээ нь, замын хөдөлгөөний журам зөрчсөн), сахилгын зөрчил (ажлын цаг хийдүүлсэн). Эрх зүйн зөрчлийн нэлээд аюултай төрөл нь гэмт хэрэг. Эрх зүйн зөрчилд иргэний, захиргааны, сахилгын ба эрүүгийн хариуцлагыг хуулиар тогтоосон байдаг

Захиргааны эрх зүйн зөрчил (англ. administrative offence / violation, ор. административное правонарушение) - тодорхой улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатай буюу болгоомжгүй зөрчсөн, захиргааны хариуцлага хүлээлгэхээр хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүй. Захиргааны эрх зүйн зөрчлийн үндсэн шинж: эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн, нийгэмд хор уршигтай, гэм буруутай, захиргааны шийтгэл хүлээх үйлдэл, эс үйлдэхүй.

Сахилгын зөрчил (англ. disciplinary offence, ор. дисциплинарный проступок) - дагаж мөрдөж буй хууль тогтоомжид сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан, хууль зөрчсөн, гэм буруутай ажилтны хөдөлмөрийн буюу албан ажлын сахилгын зөрчил.

Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил (анг. constitutional violation, ор. конституционное правонарушение) - Үндсэн хуулийн заалтыг (хэм хэмжээг) зөрчсөн ба ингэхдээ гэмт хэрэг, захиргааны, иргэний ба сахилгын эрх зүйн зөрчлийг бүрдүүлээгүй, үндсэн хуулийн эрх зүйн субъектын гэм буруутай зан үйл ба үндсэн хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.



Эрүүгийн эрх зүйн зөрчил (англ. criminal action (acts), ор. преступное действие) - эрүүгийн эрх зүйд эрүүгийн хуулиар хориглосон хэрэг үйлдсэн, эрүүгийн хууль зөрчсөн нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй

Ёс зүйн зөрчил ба эрх зүйн зөрчлийн нийтлэг тал нь ямар нэгэн эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл бол **ялгаатай тал** нь эрх зүйн зөрчил нь нийтлэг субьекттэй бол ёс зүйн зөрчил нь тусгай субьекттэй байдаг. Эрх зүйн зөрчилд хүлээлгэх иргэний, захиргааны, сахилгын болон эрүүгийн хариуцлагыг хуулиар тогтоосон байдаг бол ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг тухайн хуульчийн мэргэшлийн ёс зүйн дүрмээр тогтоодог.

МЭРГЭЖЛИЙН АЛДАА БА ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ

Хүний өдөр тутмын амьдрал ахуй, улс төр, эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан, хууль эрх зүй зэрэг нийгмийн бүхий л салбарын үйл ажиллагаа нь харилцааны тусламжтай хэрэгждэг. **Хүний харилцаа** нь агуулга, хэлбэр, бүтэц, хэрэгжүүлэх арга хэрэгслээрээ янз бүр бөгөөд зорилго нь ертөнцийн талаар мэдлэг эзэмших - **танин мэдэхүйн**, хамтын үйл ажиллагааг зохицуулах - **нийгмийн**, өөр хоорондоо амин хувийн, ажил хэргийн холбоо тогтоох - **ёс суртахууны** гэх мэт олон янзын хэрэгцээг хангахад чиглэдэг. Харилцаа нь хүмүүсийг хооронд нь холбох, хүнийг төлөвшүүлэх, бие хүнийг хүнийх нь хувьд оршиж буйг батлан нотлох, хүмүүсийн өөр хоорондын хандлагыг илэрхийлэх зэрэг олон үүрэг гүйцэтгэхээс гадна **харилцаа нь дотоод хандлагын үүрэгтэй**. Энэ нь хүн өөрөө өөртэйгээ дотоод, гадаад ярианы тусламжаар харилцах сэтгэхүйн түгээмэл арга юм.

Дээрх байдлаас “ёс зүйн зөрчил” гэж “ёс зүйн дүрэм зөрчсөн зөрчил” - ийг хэлнэ гэж тодорхойлж болох байна. Хуульчийн гаргасан алдаа нь ёс зүйн зөрчил мөн үү гэдгийг зөв тодорхойлохын тулд ёс зүйн дүрэмд ёс зүйн шаардлагаа зөв тодорхойлох нь юу юунаас чухал юм. Үүнээс гадна тухайн мэргэшлийн ёс зүйн дүрэмд тухайлан заагдаагүй ёс суртахууны бусад зөрчил гаргасан хуульчид нөлөөллийн ямар арга хэмжээ авах вэ гэдэг асуудал ёс зүйн дүрмүүдэд, тухайлбал, шүүгч, прокурор, өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмүүдэд тодорхой зохицуулагдаагүй байдаг.

Тухайлбал, өмгөөлөгчийн мэргэжлийн “мэдлэг, чадвар” - гүйгээс хууль хэрэгжүүлэхдээ алдаа гаргасан тохиолдолд “ёс зүйн зөрчил” - д тооцон сахилгын хэрэг үүсгэх бус харин мэргэжлийн хороо дүгнэлт гарган, ямар шалтгаанаар уг алдаа гарсан, уг алдааг арилгах ямар арга зам байгааг тогтоох шаардлагатай болно. Тэгвэл ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа хоёрыг яаж ялгах вэ ?

Хуульчид хууль хэрэгжүүлэхдээ:

1. хэм хэмжээний агуулгыг буруу ойлгох
2. андуурах
3. онолын мэдлэг дутах
4. тайлбар шаардлагатай, практик тогтоогүй хэм хэмжээг өөрийн дотоод итгэл, оюуны дүгнэлтэд тулгуурлан үндэслэл болгож гаргасан шийдвэр нь буруу байх
5. үүрэгт ажилдаа хайнга, хайхрамжгүй хандсанаас мэргэжлийн алдаа гаргадаг нь дээд шатанд залруулагддаг байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр, тогтоол нь давж заалдах болон хяналтын шатны шүүхээр залруулагдах ба хууль хэрэглэхдээ гаргасан ийм алдааг мэргэжлийн алдаа гэж үзэх нь оновчтой бөгөөд сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлгүй юм.

Жишээ - 1, Эрүүгийн хуульд зааснаар А гэгч аргагүй хамгаалалт хийн Б - гийн биед хүндэвтэр гэмтэл учруулсанд прокурор яллах дүгнэлт үйлдэн ирүүлснийг шүүх үндэслэлтэй гэж үзэн ял оноохдоо “Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр уг зүйл, заалт хүчингүй болсон” - ыг өөрийн хэрэглэж буй хуулийнхаа зохих хэсэгт тусгаагүй, хуучин хэвээр нь орхисон байснаас тухайн үед анзаараагүй байсан аж.

- Ялтан шүүхийн тогтоолыг эс зөвшөөрч гомдол гаргаснаар уг алдаа залруулагдсан ба энэ алдааг Шүүхийн сахилгын хороо биш мэргэжлийн хороо хянан шийдвэрлэх ёстой.

Жишээ - 2, Шүүх хуралдаан дээр шүүгдэгч Л гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй, үйлдлээ илт буруу ярьж байгаад бухимдсан шүүгч түүнийг “чи өөрийгөө хэн гэж бодов, чам шиг хүн эцэст нь өөрийгөө хохироосноо ойлгодог юм. Бухын хүзүү хатуу ч сүхний дор, эрийн зориг хатуу ч хуулийн дор гэдэг юм” гэж загнажээ.

- Шүүгчийн ёс зүйн дүрэмд “Шүүгчээс хэргийн оролцогчтой харилцах” - даа “ялгавартай байдал гаргалгүй, тэгш хүндэтгэлтэй хандаж, шүүгчийн зүгээс хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл үнэмшлийг үйл ажиллагаа, үг яриагаараа төрүүлж чадахуйц мэдлэг, харилцааны соёлыг эзэмшсэн байх үүрэгтэй. Хэргийн оролцогчид, бусад хүмүүсийг аашилж зандарч, үзэл бодлоо тулгах зэргээр зүй бус авирлаж болохгүй, хэрэг маргааны талаар урьдчилан санал бодлоо илэрхийлэх, нийтэд мэдээлэхгүй байх” гэсэн шаардлагыг зөрчсөн явдал байх учир энэ нь ёс зүйн зөрчил гэдэг нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, **ёс зүйн дүрмээр тодорхойлогдсон хуульчийн бусадтай харилцах харилцаанд биеэ хэрхэн авч явах горимыг зөрчсөн ёс зүйн зөрчил** гэж үзэх нь зүйтэй.



Ёс зүйн зөрчил мөн эсэхийг Сахилгын хорооны гишүүд сахилгын хэрэг үүсгэн шалгаж тогтоох ба хэрэв ёс зүйн зөрчил мөн бол хариуцлага тооцно. Гэхдээ ёс зүйн зөрчил нь шүүх эрх мэдлийн нэр хүндэд хэрхэн, ямар хэмжээгээр нөлөөлсөн нь хариуцлага хүлээлгэх чухал шалгуур болно. Тухайлбал, шүүх эрх мэдлийн нэр хүндэд ихээхэн хохирол учруулахааргүй ялимгүй зөрчилд “зөвлөх, анхааруулах” гэх мэт дахин тийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Хуульч өөрийн болон бусдын үйлдэл зөв эсэх, энэ нь ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн эсэх талаар эргэлзэж байвал Сахилгын хорооноос асууж зөвлөгөө авч болно.

Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжлийн алдаанаасаа илүү ёс зүйн алдаа гаргах нь олон байдаг ба энэ нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдэг тул үүнээс л ёс зүйг чухалчлах, ажил амьдралдаа баримталж байх шаардлага үүдэн гарч байна.

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЙН ОНЦЛОГ, ТҮҮНИЙ ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн зөрчлүүд

Аливаа мэргэжил өөрийн ёс суртахуунтай байдаг ба мэргэжлийн ёс зүй нь мэргэжил тус бүрийн гүйцэтгэх үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан шүүгчийн, прокурорын, өмгөөлөгчийн гэх мэтээр мэргэжлийн ёс зүй болж өөр өөрийн өвөрмөц зохицуулалттай болдог тухай өмнөх хэсэгт дурьдсан билээ. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөн байцаагч нарын нийтлэг алдаа нь 1-рт, харилцааны соёлгүй, албан тушаалаа ашиглан танил найз нөхдөдөө туслах, албан тушаалаа ашиглан амины ажилдаа ашиг хонжоо гаргах зэрэг байгаа боловч энэ талаар бодит мэдээлэл зохих газар ирдэггүй тул хэрэг үүсгэгдэж шийдвэрлэгддэггүй гэсэн ойлголт олон нийтийн дунд байна. Үүнээс гадна шүүгч, прокурор, өмгөөлөгч нар бусдад дарамт үзүүлсэн, хэрэг дарагдуулсан, үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон, торгуулийн мөнгө хувьдаа завшсан, ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн, ажилдаа согтуу ирсэн, бусдаас архи нэхсэн, бусдыг хэл амаар доромжилсон, бусдаас шан харамж авсан, бусдын гэр бүл үймүүлсэн, татвар төлөөгүй зэрэг нийтлэг зөрчил мөн гаргадаг бол дээрх зөрчлүүдийг гаргуулахгүй байх талаар хуульчдын ёс зүйн дүрмүүдэд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

Шүүгчийн ёс зүйн дүрэмд: **шүүгч биеэ авч явахдаа** “албан тушаалдаа хүндэтгэлтэй хандах, зохисгүй байдал гаргахгүй байх, хэргийн оролцогчидтой харилцахдаа алагчлалгүй шударга байх” - аар, **шүүгч мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ** “хэргийн оролцогчидтой харилцахдаа хүндэтгэлтэй шударга байх, хэрэг маргааны талаар урьдчилан санал бодлоо илэрхийлэхгүй байх, хэрэг маргааныг хуулийн хүрээнд шийдвэрлэх, шүүгчээс захиргааны удирдлагын хүрээнд үүрэг гүйцэтгэхдээ хууль дээдлэх”, **шүүн таслах ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд** “шударга ёсыг дээдлэн ёс зүйн дүрмээр хориглосон үйл ажиллагаа эрхлэхгүй байж, шүүгчийн үндсэн чийг үүргээс гадуур үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд бусдын жишгийн дагуу цалинжих, олсон орлогоо нуун дарагдуулахгүй байх, хууль, ёс зүйн дүрмээр хориглосон улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй байх, иргэний эрхээ эдэлж улс төрийн үйл ажиллагаанд оролцох бол шүүгчийн үүрэгт ажлаасаа түдгэлзэх” - арга хэмжээ авч байхаар тусгасан байна.

Ийм байтал практикт шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчих явдал гарсаар байдаг аж. Тухайлбал, Шүүхийн сахилгын хорооноос 2000 - 2001 онд 41 шүүгчид сахилгын арга хэмжээ авчээ. 11 шүүгч мэргэжлийн хороонд шилжсэнээс зөвхөн 2 нь ажилдаа тэнцэнэ гэсэн дүгнэлттэй гарч, бусад нь чөлөөлөгдсөн байна.

Сахилгын арга хэмжээ авагдсан шүүгч нар а/ ажлын цагаар архи хэрэглэсэн, б/ ажил тасалж, ажлаас хоцордог, в/ хайнга хариуцлагагүйгээс мэргэжлийн алдаа гаргасан, г/ хийгээгүй ажлыг хийсэн харагдахын тулд хуурамч материал бүрдүүлэх гэх мэт алдааг ихэвчлэн гаргаснаас гадна “ял оновчтой хэрэглээгүй” зэрэг мэргэжлийн алдаа ч нэлээд гаргажээ.

Дээрх зөрчлүүдэд авилгал авсан, харилцааны соёлгүй гэсэн үндэслэлээр сахилгын арга хэмжээ авагдсан гэсэн баримт үгүй байх ба дээр дурьдсан зөрчлүүдийн 9 - д цалин бууруулах, 17 - д сануулах, 3 - д буруушаах, 11 - д огцруулах арга хэмжээ авчээ.

Энэ байдал төдийлөн өөрчлөгдөөгүй болох нь УДШ - ийн 2008 оны жилийн тайлангаас ч харагдана. Тухайлбал, “Шүүгчийн ёс зүй, зан үйлийг тогтоож хэвшүүлэх, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын тухай: “Монгол Улсын шүүхийн Сахилгын хорооны ажлын алба шүүгчийн ёс зүйтэй холбоотой урьд оны үлдэгдэл 8 шүүгчид холбогдох 8, шинээр 106 шүүгчид холбогдох 72, нийт 114 шүүгчид холбогдох 80 гомдол, хүсэлт хүлээн авсанаас бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчээс 10 хүсэлт, төрийн байгууллагаас 10, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 60 гомдол тус тус ирүүлсэн байна. Тайлангийн хугацаанд Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрхэд хамааралгүй, шүүгчийн ёс зүйтэй холбогдолгүй 68 гомдол ирүүлсэнийг харьяаллын дагуу шилжүүлэх, гомдол гаргагчид нь буцаах зэргээр шийдвэрлэжээ. Ажлын албанд ирүүлсэн гомдол хүсэлтийг Шүүхийн сахилгын хороон дарга, гишүүдэд танилцуулж зохих шалгах ажиллагаа хийснээс 20 шүүгчид холбогдох гомдол, хүсэлтэд сахилгын



хэрэг үүсгэж, 1 шүүгчийг албан тушаалаас огцруулах, 11 шүүгчид сануулах, 1 шүүгчийн зэрэг дэвийг 6 сараар бууруулах зэрэг сахилгын шийтгэлийг нийт 13 шүүгчид оногдуулж, 7 сахилгын хэрэг үүсгэсэн захирамжийг хэрэгсэхгүй болгож, 16 гомдол, хүсэлтэд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж, 30 гомдол, хүсэлтэд зохих хариуг албан бичгээр өгсөн байна.” гэхчлэн тусгагдаж байжээ.

Практикт зарим прокурор хэргийн оролцогч, ялангуяа, өмгөөлөгч нартай ялгавартай байдлаар харилцдаг явдал цөөнгүй ажиглагддаг. Энэ нь хэд хэдэн шалтгаантай ба зөвхөн нэг жишээ дурьдахад прокурорын байгууллага дээр өмгөөлөгч байрлуулах, тэдэнд албан өрөө түрээслэн суулгах нь тухайн өмгөөлөгчид давуу байдлыг бий болгож, прокуроруудтай дотно харилцах, ажил хэргийн шалгуураас илүүтэй дотно танилын шалгуурыг баримтлан үйл ажиллагаагаа явуулах, прокуроруудын хувьд манай өмгөөлөгч гэсэн сэтгэхүйн ойлголт, төсөөлөлд автан тэдэнтэй бусад өмгөөлөгч нараас ялгавартай байдлаар харилцах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Прокурорын ёс зүйн дүрэмд: “хэргийг харьяаллын дагуу шүүхэд шилжүүлэх үед прокурор хэргийн оролцогч, өмгөөлөгчидтэй харилцахдаа ямарваа ялгавартай байдал гаргахгүйгээр хүндэтгэлтэй хандаж, тухайн хэргийг шударга зөв шийлвэрлэх итгэл үнэмшил төрүүлж чадахуйц мэдлэг, харилцааны соёлтой байх явдал нь прокурор бүрийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байвал хэм хэмжээ юм” гэж заасан байна.

Хэдийгээр прокурорын байгууллагын хувьд нэгдмэл төвлөрсөн удирдлагын зарчмаар үйл ажиллагаа явуулдаг боловч “дээд шатны прокурорын шийдвэрийг доод шатандаа заавал биелүүлж ажиллах” зарчмын утга санааг гажуудуулан, албан тушаал, эрх мэдлийн давуу байдлаа ашиглан доод шатны прокурортоо хуульд нийцээгүй шаардлага тавих, түүнийг нь доод шатны прокурор хүссэн хүсээгүй хүлээн зөвшөөрч биелүүлж байгаа нь байж болшгүй зүйл юм.

Шүүхийн хэлэлцүүлгийн үед прокурор шүүх хуралдаанд оролцогчид руу муухай харах, дохих, зангах, загнах, доромжлох, хууль бус асуулт тавих, хариулахыг шаардах, нэг дор олон төрлийн үйл хөдлөл хийх, утсаар ярих, өөр хэрэг, ном сонин унших, нойрмоглох, асуудалд хайхрамжгүй хандах зэрэг олон төрлийн зөрчил гаргадаг нь өөрт нь анзаарагддаггүй боловч хөндлөнгөөс ажиглагсад, шүүх хуралдаанд оролцогчдод мэдэгдэхүйц байдлаар илэрч, энэ нь прокурорыг харилцааны соёлгүй, ёс зүйгүй гэх зэрэг үнэлэмж өгөх үндэслэл болдог.

Жишээ дурьдахад, судалгаа авч байсан шүүх хуралдаан дээр улсын яллагч 40 минутын дотор 20 удаа балаа амандаа хийж байв. Зарим улсын яллагч тогтоол уншиж сонсгоход байлцдаггүй, хурлыг орхиж явдаг зөрчил нь шүүхийн шийдвэр хууль ёсны ба итгэл үнэмшилтэй байх, шүүхийн шийдвэрт хүндэтгэлтэй байх талаар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчиж буй явдал юм. Нөгөө талаас улсын яллагч шүүхийн шийдвэрийг урьдчилан мэдэж байсан, эсхүл үл зөвшөөрсөн байдлыг оролцогчдод төрүүлж хардлага бий болгох учраас шүүхийн шийдвэрийг уншиж сонсгоход заавал байлцах шаардлагатай.

Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд “өмгөөлөгч мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэжил нэгтэнтэй харилцахдаа “ямар нэгэн нөлөөнд автахгүйгээр эрх зүйн ухамсар, мэргэжлийн үүргээ удирдлага болгох, эрхэлсэн ажилдаа чин сэтгэлээсээ хандаж мэргэжлийн үүргээ ёсчлон хэрэгжүүлэх, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж хууль тогтоомж, эрдэм шинжилгээний болон практикийн ном зохиол судалж, шүүхийн практикт дүн шинжилгээ тогтмол хийж байх,

хамтран ажиллагсадтайгаа хүндэтгэх, ойлголцох итгэлцэх, өмгөөлөгчдийн хамт олны дотор зан суртахуун сэтгэл санааны болон эдийн засгийн тааламжтай уур амьсгал бүрдүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцдаа даруу төвшин, өөртөө шүүмжлэлтэй хандах үүрэгтэй бөгөөд өөрийнхөө ажил хэргийн нэр хүндийг дээшлүүлэхийн тулд бусад өмгөөлөгчдийн алдар хүнд, нэр төрд сэв суулгах эрхгүй” гэж өмгөөлөгчийн ёс зүйн шаардлагыг тодорхойлж, Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ харилцахдаа өмгөөлөгчийн нэр хүндэд сэв суулгахгүйгээр үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг цаг ямагт хамгаалах, үйлчлүүлэгч өмгөөлөгчөө сонгох эрхэд хүндэтгэлтэй хандах, үйлчлүүлэгчийнхээ ашиг сонирхлыг зөрчилдөөнд хүргүүлэхгүй байх, үйлчлүүлэгч өөрийнхөө ашиг сонирхлыг өөр ямар нэгэн өмгөөлөгчтэй хамтран хамгаалуулах хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө өмгөөлөгчтэйгээ зөвшилцсөн байхыг, мөн тухайн хэргийг бүрэн төгс шийдвэрлүүлж дуустал үйл ажиллагаагаа тууштай явуулахыг үүрэг болгож, тодорхой тохиолдолд хэрэг маргаанд өмгөөлөгчөөр оролцохыг хориглосон ба өмгөөлөгчийн цээрлэх зүйлийг тухайлан зааж өгсөн, эдгээр хэм хэмжээг зөрчих нь ёс зүйн зөрчил болдог.

Практикаас үзэхэд өмгөөлөгч дараах нийтлэг зөрчийг гаргадаг байна. Тухайлбал:

- хэрэг асуудлыг урьдчилан ашигтай шийдүүлнэ гэж амлалт өгөх,
- тохиролцооноос гадна өмгөөллийн үйл ажиллагаа, үр дүнд тохирохгүй өндөр хөлс нэхэх,
- үйлчлүүлэгчтэй ажлын цагаар болон ажлын байранд архиан согтуурах,



- өмгөөлөгч байгаа байдлаа далимдуулж үйлчлүүлэгчээр өөрийн хувийн ажил төрлийг хөөцөлдүүлэх, зүй бус харьцаа тогтоох.
- өмгөөллийн хөлснөөс өөр шан, харамж авахаар шахалт дарамт үзүүлэх
- өмгөөлж буй асуудлын хүрээнд хуулийн байгууллагын ажилтнуудтай холбоо тогтоох,
- гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй, хэрэг маргаан шийдэгдээгүй байхад урьдчилан дүгнэлт хийж, хэвлэл мэдээллээр тараах, бусдыг үндэслэлгүйгээр дайрч гутаах, мэргэжлийн нэр хүндэд харш үйлдэл, үйл ажиллагаа явуулах зөрчил гаргадаг байна.

Мөн өмгөөлөгч **“харилцан ойлголцох, итгэлцэх”** зарчмыг баримтлан ажиллаагүйгээс байцаан шийтгэх ажиллагаа хэрэгжүүлэгчдийн зүгээс хүсэлтийг нь хүлээн авахгүй байх, ингэснээр үйлчлүүлэгчид нь ашигтай нотлох баримтыг гаргуулан авах, шалгуулах асуудал орхигдох, хэрэг шалгах явц удаашрах зэрэг сөрөг үр дагаврыг үүсгэдэг аж.

Өмгөөлөгч байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа бусад этгээдүүдтэй хүндэтгэлтэй харилцах, ажлын үед биеэ зөв авч явж, гадаад төрхөндөө анхаарах, хэргийн талаар бусадтай харилцахдаа цээртэй үг, хараал хэлэхгүй байх, бусдыг гүтгэх, доромжлохгүй байх зэрэг нь **“соёлтой харилцааг эрхэмлэх”** зарчмыг тодорхойлох гол хүчин зүйл болдог байтал бусдыг үл тоомсорлох, ажлын үеэр согтууруулах ундаа хэрэглэсэн байх, тухайн нөхцөл байдалд тохиромжгүй хувцаслах, бусдыг хэл үгээр доромжлох, хараалын үг хэрэглэх, бусдыг гүтгэх зэрэг нь өмгөөлөгчийн талаар бусдад таагүй сэтгэгдэл төрүүлж, улмаар түүнийг үнэлэх үнэлэмжид муугаар нөлөөлж байдаг.

Мөн “Өмгөөлөгчийн ёс зүйн дүрэм” - ээр **“хэргийг шийдвэрлүүлэх зорилгоор хэлхээ холбоо тогтоохгүй байх”** тухай шаардлага нь өмгөөлөгчийн зүгээс байцаан шийтгэх ажиллагаа явуулж буй этгээдүүдтэй холбоо тогтоохдоо хээл хахууль өгөх, шан харамж амлах, тухайн этгээдийн хүндрэл бэрхшээлтэй асуудлыг нь шийдвэрлэж өгөх, үүнийхээ хариуд хэргийг өөрийнхөө үйлчлүүлэгчид ашигтайгаар шийдвэрлүүлэх болзол тавих зэргээр зөрчигдөж байдаг.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Ёс зүйн зөрчил гэж юу вэ?
- Ёс зүйн зөрчил нь эрх зүйн зөрчлөөс юугаараа ялгаатай вэ? Тэдгээрийн нийтлэг тал юу вэ?
- Мэргэжлийн алдаа ба ёс зүйн зөрчлийн хооронд ямар ялгаа байх вэ?
- Ёс зүйн зөрчлийн гол онцлог юу вэ?
- Ёс зүйн зөрчлийн ямар төрөл, хэлбэрүүд байдаг вэ?

IV БҮЛЭГ.

ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА БА ЁС ЗҮЙН ХЯНАЛТ

Бүлгийн зорилго: *Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, дүрэм, ёс зүйн хяналт, зөрчил, хариуцлага, хариуцлага хүлээлгэх процедурын талаар цэгцтэй мэдээлэлтэй болох, мэргэжлийн үйл ажиллагаандаа хуульчийн ёс зүйн үүднээс дүн шинжилгээ хийх чадвар эзтших, мэргэжилдээ хариуцлагатай хандах, үйл ажиллагаандаа ёс зүйн хэм хэмжээг баримтлах хандлага төлөвших, хуульчийн биеэ авч явах дадалтай болоход оршино.*

4.1. ХУУЛЬЧИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Сэдвийн зорилго: *Хуульчдад хүлээлгэх мэргэжлийн ёс зүйн хариуцлага, түүний төрөл, онцлогийн талаар мэдлэг эзтших, ёс зүйн зөрчлөөс өөрийгөө сэргийлэх, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах хандлага төлөвших, хуульчийн ёс зүйн дадалд сургах.*

НЭР ТОМЬЁО:

- Ёс зүйн хариуцлага
- Сануулга, торгууль
- Нийгмийн хариуцлага
- Ажлаас чөлөөлөх

Ёс зүйтэй байх, ёс зүйн шаардлагыг дагаж мөрдөх явдлыг Монгол Улсын Шүүх, Прокурорын байгууллагын тухай болон Өмгөөллийн тухай хууль, Шүүгчдийн Зөвлөлийн 2003 оны 3 - р сарын 07 ны өдрийн 01 - р тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Прокурорын ёс зүйн дүрэм”, Монголын өмгөөлөгчдийн холбооны 2003 оны 9 дүгээр сарын 19 ны өдрийн Их хурлаар баталж, XI их хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Монголын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” - д хэм хэмжээчилсэн ба шүүгч, прокурор, өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн дүрмийн зарчим, шаардлагыг зөрчсөн үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал, 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан



“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай” Монгол Улсын хуулийн 37 - р зүйлийн 37.1 - д “шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурьдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна: 37.1.1. сануулах, 37.1.2. 6 сар хүртэл 30 хувиар цалинг нь бууруулах, 37.1.3. огцруулах.” гэж заасан байна.

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ОНЦЛОГ

Хариуцлагагүй хуульч хүмүүст хэтэрхий их хор хохирол учруулах учраас хуульч туйлын хариуцлагатай, ёс зүйтэй байх нь чухал юм. Үүрэг, хариуцлагаа ухамсарлах нь ёс зүйтэй байхын бас нэг хэмжүүр.

“Үүрэг нь хувь хүнээс бусдын болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт юм. Үүргээ ухамсарлах нь хүн өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаандаа ямагт бодолтой, ухаалаг хандахад нөлөөлдөг”.

Хуульчийн мэргэжлийн хариуцлагын гол зангилаа бол эрх мэдэл дор хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх явдал учир хуульчид өөрт олгогдсон эрх мэдлээрээ өөртөө давуу байдал олгох зүй бус шийдвэр гаргах бус шударга ёсыг сахигч байх ёстой. Нийгэм, олон нийтийн зүгээс ч ийм байхыг шаарддаг. Шударга ёс алдагдахад хуульчид, хуулийн байгууллагынханд итгэх итгэл алдагдахад хүрнэ. Иймд төр эрх зүйн тусламжтайгаар шударга ёсны наад захын түвшинг хадгалах, хуульчдыг ёс зүйтэй байлгах, нийгэмд шударга ёсыг тогтоон төлөвшүүлэх нь чухал.

Шударга ёс нь хүн нийгмийн харилцаанд үнэн бодитой, зохистой хандах зүй ёсны шаардлага, шударга ёс нь хүний амин хувийн ашиг, сонирхлыг бусдын буюу нийгмийнхтэй зөв тэнцвэртэйгээр уялдуулах, нийтлэг чиг шугамд үндэслэгдсэн эрх зүйн зарчим тул хуульчийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага бол шударга ёсыг сахих явдал. **Шударга бус** гэдэг нь эрх мэдэлтэй нэгний эрхшээл дор иргэн эрхээ эдэлж, үүргээ гүйцэтгэж чадахгүй байх явдал юм.

Манай Улсад шүүгч, прокурор, өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд тавигдах шаардлагыг мэргэжлийн ёс зүйн дүрмээр тусгайлан хэм хэмжээчилж, уг хэм хэмжээнүүдийг зөрчсөн хуульчид сануулах, албан тушаалын зэрэг дэвийг бууруулах, ажлаас халах, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох гэх мэт сахилгын хариуцлага хүлээлгэж байгаа нь өнөөгийн нөхцөлд хэрэгцээ шаардлагатай байгаа зүйл юм.

Хуульч мэргэжлийн хүрээнд явуулах ажиллагаагаа хувийн сонирхлоос зааглаж, хуулийг хэрэглэх эрх мэдлийнхээ хүрээнд хүний эрхийг хамгаалан хангах үүргийг нийгмийн өмнө хүлээж, тэрхүү мэргэжлийнхээ хувьд өндөр хариуцлагатай байх, хувь хүнийхээ зан байдлыг хатуу хянах үүрэг ноогдох ба тэр нь ёс зүйн хувьд тавигдах шаардлагаар хангагддаг.

Ёс зүй нь нийгмийн үзэгдэл болохынхоо хувьд хүмүүс хоорондын харилцаа түүнээс үүдэн гарах үүрэг төдийгүй нийгэм бусдын өмнө хүлээсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг өөрөө хэрхэн ухамсарлаж буйгаар тодорхойлогддог ба хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах ёстой ч бүрэн төгс боловсрогдсон ёс зүйн дүрэм гэж үгүй тул дүрмийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байх нь зүйтэй.

Хуульч ч өөрийн эрх, үүргээ хэрхэн ухамсарлах, үйл ажиллагаандаа ямар сэтгэлээр хандах нь “ёс зүй” - тэй холбоотой тул шударга ёсыг тогтоохын тулд юуны өмнө “ёс зүй” - тэй байх, өөрт хал балгүй гэж дээд удирдлагын үүрэг даалгаврыг л биелүүлэх байдлаар ажлаа гүйцэлдүүлдэг хуучин хэвшмэл арга барилаас ангижирч, үйл ажиллагаандаа хүнлэг, энэрэнгүй ёс, шударга ёсны зарчмыг дээдлэн, хуульчийн хувьд хүлээсэн үүрэг хариуцлагаа ойлгон ухамсарлаж, сэтгэхүй, оюун ухаанаа хөгжүүлж, идэвх санаачлагатай байж, ажлын шинэлэг арга барилд суралцах ёстой.

Хариуцлагын төрөл, хэлбэрүүд: Шүүгч, прокурор, өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, ёс зүйн дүрмийн зарчим, шаардлагыг зөрчсөн үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэнэ. Хариуцлага хүлээлгэх журмыг сахилгын хорооны дүрмээр тодорхойлно.

Хуульч хүн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг ялимгүй зөрчсөн, эсвэл зан үйл нь ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчөөгүй ч ёс суртахууны доголдлын шинжтэй, улмаар олон нийтийн зүгээс зэмлэл хүлээлгэхээр байвал гаргасан зөрчлийн шинж байдал, хор уршиг, гэм буруугаа ойлгон гэмшсэн байдал зэргийг харгалзан түүнд олон нийтийн болон байгууллагын зүгээс засан хүмүүжүүлэх зан суртахууны нөлөөллийн арга хэмжээ авч болдог.



МЭРГЭШЛИЙН ОНЦЛОГООС ҮҮДЭХ ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА

Шүүгч нь хэрэг, маргааныг шүүн хэлэлцэж шийдвэрлэх эрхтэй этгээд ба энэ үүргээ хэргийн бодит үнэнд нийцүүлэн шударгаар шийдвэрлэх, шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бие даасан байх, хуулийг дээдлэх, шударга ёсны зарчмыг үйл ажиллагаандаа удирдлага болгох,

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, ЭБШАжиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг хянах, түүнчлэн ял эдлүүлэх болон гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцож яллах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ үйл ажиллагаандаа нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, гадны нөлөөнд үл автах, хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах, хуулийг хүндэтгэж чанд сахих зарчмыг удирдлага болгон баримтлах,

Өмгөөлөгч нь Үндсэн хуулиар олгогдсон иргэд хууль зүйн туслалцаа авах, өмгөөлүүлэх эрхээр хангагдах, эрх хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах эрхийг нь хэрэгжүүлэх баталгааг хангаж, иргэн, хуулийн этгээдэд эрэлт хэрэгцээтэй эрх зүйн туслалцаа, үйлчилгээг үзүүлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсны баталгааг ханган оролцох ба үйл ажиллагаандаа үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг тууштай хамгаалах, өмгөөллийн нууцыг хадгалах, хуулийг дээдлэх, шударга ёсыг сахих, хүнлэг, энэрэнгүй байх зэрэг зарчмуудыг удирдлага болгох ёстой.

Хуульчдад тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага хууль тогтоомжид тусгагдсан байх хэдий ч дээр дурьдсан хуульчдын мэргэшлийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч хуульчдад тавигдах мэргэшлийн ёс зүйн тусгай шаардлагыг Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм, Прокурорын ёс зүйн дүрэм, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэмд тус тус хэм хэмжээчилсэн байх бөгөөд тус тусын мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл ёс зүйн дүрмийн шаардлагыг зохих ёсоор биелүүлээгүй санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэхүй нь хуульчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог байна.

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн хуульчид гаргасан зөрчлийнх нь шинж байдлыг харгалзан дараах төрлийн сахилгын шийтгэл ноогдуулна. Тухайлбал,

Өмгөөллийн тухай Монгол Улсын хууль /энэ хууль 2012 оны 3 - р сарын 07 ны өдөр баталсан “Өмгөөллийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль” - иар хүчингүй болсон бөгөөд мөн өдөр баталсан “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль” хүчин төгөлдөр болсон өдрөөс буюу 2014 оны 1 дүгээр сарын 01 ны өдрөөс дагаж мөрдөнө / - ийн 18 -р зүйлд “18.1. энэ хуулийн 12.3 -д заасан өмгөөлөгчийн үүрэг, тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Сахилгын хорооны саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно,” 19 -р зүйлийн 19.1 -д “Дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно, 19.1.3. өмгөөлөгчийн үүрэг, ёс зүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн, 19.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Сахилгын хорооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ,” 23 - р зүйлийн 23.1 -д “Хууль тогтоомж, өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн өмгөөлөгчид сахилгын дараах шийтгэл ногдуулна: 23.1.1. сануулах, 23.1.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавих..,”

“Прокурорын байгууллагын тухай” Монгол Улсын хуулийн 44 - р зүйлийн 44.1 - д “Прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараах сахилгын шийтгэлийг оногдуулна. 44.1.1. сануулах; 44.1.2. албан тушаалын цалингийн хэмжээг 20 хувь хүртэл бууруулах; 44.1.3. албан тушаал бууруулах; 44.1.4. ажлаас халах;” ,

“Шүүгчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 37 - р зүйлийн 37.1 - д “шүүгч энэ хууль, шүүгчийн ёс зүйн дүрэм, шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн бол түүнд дор дурьдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг авна: 37.1.1. сануулах, 37.1.2. 6 сар хүртэл 30 хувиар цалинг нь бууруулах, 37.1.3. огцруулах. 37.2. Энэ хуулийн 37.1.3 -т заасан сахилгын арга хэмжээг оногдуулахдаа Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ” гэж тус тус заасан байна.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хуульчийн мэргэжлийн хариуцлага гэж юу вэ?
- Нийгмийн зүгээс хүлээлгэх хариуцлага ба мэргэжлийн хариуцлага хоёрын уялдаа?
- Хуульчийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын гол онцлогуудыг дурьдана уу?
- Хариуцлагын ямар төрөл, хэлбэрүүд байдаг вэ?
- Мэргэшлийн онцлогоос үүдэх ёс зүйн ямар хариуцлагууд байдаг вэ?



4.2. ЁС ЗҮЙН ХЯНАЛТ

Сэдвийн зорилго: *Мэргэжлийн ёс зүйн хяналтын тухай ойлголт, түүнийг хэрэгжүүлэх арга механизм, хяналтын чиг үүргийн талаар тэдлэг эзэмших, хуульчийн ёс зүйн дадалд сурах, мэргэжлийн ёс зүйн хэт хэтжээг баримтлах хандлага төлөвшихөд оршино.*

НЭР ТОМЬЁО:

- Хяналт
- Мэргэшсэн хяналт
- Баталгаа
- Хяналтын хүрээ
- Хяналтын арга

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хяналт гэдгийг тухайн байгууллагаас өөрийн эрх хэмжээний хүрээнд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа зохиох хууль дүрэмд хэрхэн нийцэж байгаад тавьж буй ажиглалт гэж болох бол, **шалгалт** гэж хяналт тавигдах явцад ямар нэг алдаа, зөрчил гарсан байж болзошгүй бол зөрчлийг илрүүлж, тодорхойлохын тулд явуулж буй үйл ажиллагаа юм.

Хяналт шалгалт нь товчдоо тухайн мэргэжлийн чиг үүргийг гүйцэтгэж буй албан тушаалтан /нэгж/ үүргээ хэрхэн биелүүлж байгааг нь шалгаж, зөрчил дутагдал илэрвэл хариуцлага хүлээлгэх, үүргээ биелүүлээгүйгээс учрах эсрдэлээс урьдчилан сэргийлэх ажиллагаа юм.

Хяналт шалгалтын зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг хангах, удирдлагын шийдвэрийн үндэслэл, үр нөлөө, түүний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, хууль тогтоомж, хуулийн хүрээнд гарсан удирдлагын шийдвэрийн шаардлагаас зөрсөн зөрчлийг илрүүлэх явдал байна.

Хяналт шалгалтын гол чиг үүрэг нь хуулиудыг таниулан мэдүүлэх, үйл ажиллагаагаа зөв зохион байгуулахад нь туслах, аливаа хууль, дүрэм зөрчсөн үйлдэл, эс үйлдэл болон хариуцлагаас зайлсхийх явдал гаргуулахгүй байх юм.

Хяналт шалгалтыг явуулахдаа шалгах объектоо зөв сонгох, хяналт шалагалтын ямар горимыг гүйцэтгэх болон ямар хүрээг хамруулах, шалгалтыг хэрхэн үр ашигтай байдлаар гүйцэтгэх зэрэг хүчин зүйлсийг анхаарах ёстой.

Ёс зүйн хяналтын зарчим нь: хууль дээдлэх, шударга байх, тэгш хандах, нууцыг хадгалах, мэргэжлийн ур чадвартай байх, хяналт шалгалтаа үр дүнтэй явуулах, асуудалд мэргэжлийн үзэл бодолтой хандах, уян хатан байх, ил тод, бодитой байх явдал юм.

Хяналт шалгалт хийх нийтлэг үндэслэл: хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага өөрийн санаачлагаар, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар, иргэдээс ирсэн гомдол мэдээллээр, хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр шалгалтыг явуулна.

Хяналт шалгалтын ач холбогдол:

Хууль тогтоомж, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн биелэлтийг хангах
Удирдлагаас гаргаж байгаа шийдвэрийн үндэслэл, үр нөлөө, түүний хэрэгжилтэд дүгнэлт өгөх

Хууль тогтоомж болон ёс зүйн дүрмийн хүрээнд гарсан удирдлагын шийдвэрийн шаардлагыг зөрчсөн зөрчлийг илрүүлэх

Дутагдал зөрчлийн талаар эрх бүхий байгууллага, холбогдох албан тушаалтан, хамт олонд мэдэгдэх нь санамж дохио болох, урьдчилан сэргийлэх

Нийгэмд болон албан үүрэгтэй нь холбоотой хэм хэмжээг нэг мөр гуйвалтгүй даган биелүүлэхэд тэдний ухамсар, идэвх, хариуцлагыг дээшлүүлэхэд, хүнийг бүх талаар нь сайн сайхан болгон хөгжүүлдэг ач холбогдолтой

Сэдэвтэй холбогдуулан **хяналт, захиргааны хяналт, хяналт шалгалтын эрх мэдэл** - гэсэн нэр томъёог эрдэмтэн, судлаачид хэрхэн тайлбарласныг авч үзвэл,

Хяналт (анг. supervision; ор. надзор) - хууль дээдлэх талаарх төрийн янз бүрийн байгууллагын үйл ажиллагааны хэлбэр. Хяналтыг шүүхийн, Үндсэн хуулийн, прокурорын, захиргааны гэж ангилна. Хяналтын онцгой төрөл нь зохиогчийн хяналт юм.

Захиргааны хяналт- (анг. administrative supervision; ор. административный надзор). Хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар тогтоосон бүх нийтээр дагаж мөрдвөл зохих журам буюу захиргааны журмын хэрэгжилтэд улсын хяналтын албадаас тавих хяналтын үйл ажиллагаа.

Хяналт шалгалтын эрх мэдэл (анг. control power; ор. контрольная власть) - хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн зэрэгцээ эрх мэдэл хуваарилах тогтолцоонд бие даасан байр суурийг эзэлдэг гэж үздэг үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны нэг онол. Ихэнх улсад Хяналт шалгалтын эрх мэдэл нь төрийн онцгой төрлийн дээд байгууллага (үндсэн хуулийн шүүх, тооллогын танхим, улсын хянан шалгагч, омбудсман) байдаг. Хяналт шалгалтын байгууллага нь зөвхөнхэргийн байдлыг мөрдөх, шалгах, судлах бөгөөд байгууллага, үйлдвэрийн газрын шуурхай үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох эрхгүй. Зөрчигчдөд зохих арга хэмжээ авах төрийн бусад байгууллагад хяналт, шалгалтын үр дүнг илтгэнэ. Хяналт шалгалтын байгууллага нь өөрөө ямар ч шийтгэл ноогдуулж болохгүй” гэхчлэн тайлбарлажээ.



ХЯНАЛТ ТАВИХ БОЛОМЖ

Шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд нийгмийн зүгээс тавигдах тусгай шаардлагуудыг хэм хэмжээчилж Хуульчдын мэргэжлийн ёс зүйн дүрэм болгон мөрдүүлдэг нь олон нийтэд ил тод, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс эдгээр хуульчдын хуульч ёс зүйн дүрмээ зөрчсөн гэж үзсэн зохисгүй үйлдлийн талаар гомдол, мэдээлэл, хүсэлтээ гаргах эрх нь нээлттэй, гомдол, мэдээлэл, хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах журам, уг ажиллагааг явуулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож өгсөн байгаагаар илэрнэ.

Мөн Шүүхийн сахилгын хорооны гишүүд нь орон тооны бус байдаг ба бүрэлдэхүүнд нь бүх шатны шүүхээс тус бүр 2 шүүгч, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас 2 прокурор, Монголын Өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлөөс 2 өмгөөлөгч, Нийслэлийн ИТХурлын тэргүүлэгчдээс 5 төлөөлөгч байгаа нь шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн шүүгчийн ёс зүйд шүүхээс **бусад байгууллага, иргэдийн зүгээс хяналт тавих бололцоог хангасан явдал.**

Прокурорын байгууллагын тухайд Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журамд зааснаар Зөвлөл нь зөвхөн прокуроруудаас бүрдэхээр журамлагдсан байгаа хэдий ч иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гомдол, мэдээлэл, хүсэлтээ гаргах эрх нээлттэй байгаа нь мөн л прокуроруудын ёс зүйн хяналт тавихад иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог хангасан явдал юм. Ёс зүйн дүрэм зөрчсөн прокурорт Прокурорын байгууллагын тухай Монгол Улсын хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах ба гомдол, мэдээллийн хариуг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд өгөхөөр хуульчилсан нь иргэд, олон нийтийн зүгээс прокурорын ёс зүйн хэрэгжилтэд хяналт тавих боломжийн илрэл юм.

Хяналтыг хэрэгжүүлэх арга механизмууд

Шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн ёс зүйн албан ёсны хяналтыг бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчид, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорууд, мөн аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн Зөвлөлийн дарга нар шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах явцдаа зөрчил илрүүлбэл өөрсдийн санаачлагаар болон иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, хүсэлтийн мөрөөр өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд шалгалт хийх, уг шалгалтын дүнг үндэслэн Сахилгын хороонд уламжлах хэлбэрээр тавьдаг бол шүүх, прокурор, өмгөөлөх байгууллагын дэргэд байгуулагдсан Шүүхийн сахилгын хороо, Прокурорын

ёс зүйн зөвлөл, Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дарга, гишүүд иргэд байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, хүсэлт болон өөрийн санаачлагаар ажлын албаараа дамжуулан шалгалтыг хийж дүгнэлт гаргах, дүгнэлтийг шийдвэрлэх эрх бүхий субъектэд уламжлах хэлбэрээр хяналтын үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 192 - р зарлигаар 2007 оны 8 дугаар сарын 03 ны өдөр батлагдсан Монгол Улсын “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” - д Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн байдалд 15 гишүүний бүрэлдэхүүнтэй Шүүхийн сахилгын хороо хяналт тавьж ажиллах, шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэх, хэлэлцээд гаргасан шийдвэрт гомдол гаргах журам, сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны талаар тусгасан байдаг. Уг дүрэмд бүх шатны шүүхийн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороо Улсын хэмжээнд нэг байх бөгөөд Шүүхийн сахилгын хорооны ажлын алба нь Сахилгын хорооны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, Сахилгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, хянан шалгагч нар зохих шалгах ажиллагаа гүйцэтгэх болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Шүүхийн сахилгын хорооны ажлын алба нь орон тооны байх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдана. Орон тоог нь Шүүхийн ерөнхий зөвлөл тогтоох уг ажлын алба Сахилгын хорооны өдөр тутмын тасралтгүй хэвийн ажиллагааг хангана.

Шүүхийн сахилгын хорооны анхан шатны хуралдаан нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй, давж заалдах шатны хуралдаан нь нийт гишүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй байна” гэж ёс зүйн хяналт тавих механизмыг нарийн тусгасан бол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148-р зарлигийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” - д Прокурорын ёс зүй зөрчсөн эсэх асуудалд Улсын ерөнхий прокурорын орлогчоор ахлуулсан Прокурорын ёс зүйн зөвлөл Улсын хэмжээнд нэгдсэн хяналт тавих, мөн Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, хэлтсийн дарга нар, аймаг нийслэл, тээвэр, дүүргийн прокурорууд мөн мэргэжлийн удирдлагын хувьд хяналт тавих, сахилгын зөрчил гаргасан прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, түүнийг шалгах, шийтгэлийг оногдуулах, хөөн хэлэлцэх хугацаа, шийтгэлийг хэрхэн арилгах зэргийг “хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, шүүгч, хүсэлт гаргасан иргэн, албан тушаалтан, байгууллага гомдол мэдээлэл ирүүлсэн, эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчөөс гарсан гомдол, хүсэлт нь ёс зүйн зөрчлийг шалгах ажиллагааг эхлүүлэх үндэслэл бөгөөд гомдол, хүсэлт мэдээлэлд дурьдсан зүйл нь нотлогдвол энэ нь прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно. Прокурортой холбоотой гомдол



мэдээллийг бичгээр гарган нийслэлд бол УЕПГ-т ажлын өдрүүдэд бичиг хэргээр дамжуулан, хөдөө орон нутагт аймгийн прокурорт болон шуудан холбоогоор дамжуулан УЕПГазарт гаргаж болно” гэхчлэн зохицуулжээ.

Монголын өмгөөлөгчдийн холбооны “Сахилгын хорооны дүрэм” (12 дугаар зүйл) - ээр өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргасан эсэх, зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг хэлэлцээд шийдвэр гаргах, гаргасан шийдвэрт гомдол гаргах журам, сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагаа зэрэг өмгөөлөгчийн ёс зүйд хяналт тавих механизм хэрхэн ажиллахыг нарийн тусгажээ.

АЛБАН БОЛОН АЛБАН БУС ХЯНАЛТ

Хуульчдыг ёс зүйн дадалд сурах, улмаар мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах хандлага төлөвшүүлэхэд нэн чухал ач холбогдолтой шүүгч, прокурор, өмгөөлөгчийн зүгээс мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд мөрдөх ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх явцад тавих **мэргэжлийн ёс зүйн хяналт нь хэрхэн хэрэгжиж байгааг** авч үзвэл: “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм” - ийн хэрэгжилтэд шат шатны шүүхийн ерөнхий шүүгч, Шүүхийн сахилгын хороо, Прокурорын ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорууд болон Прокурорын ёс зүйн зөвлөл, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн Зөвлөлийн дарга, Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хороо тус тус **албан ёсны хяналт** тавьж, шүүгч, прокурор, өмгөөлөгч ёс зүйн дүрмээ зөрчсөн эсэх асуудлыг хянан шалгаж, үр дүнгийн талаар шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд илтгэх явдлаар хэрэгжиж байна.

Олон нийтийн албан бус хяналт, түүний үр нөлөө, ач холбогдол: Шаардлагатай бол цагдан хорих, мөрдөх зэргээр хүний эрх, эрх чөлөөнд хуулийн хүрээнд халдах төрийн албадлага хэрэглэдэг эрхтэйгээрээ бусад мэргэжлээс гойд ялгарах, нийгэм, төрийн өмнө **“төрт ёсыг бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, иргэдийн эрх зүйн мэдлэг, хүмүүжлийг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангах онцгой үүрэг, хариуцлага хүлээдэг”** хуульчид ёс зүйтэй байх нь олон нийт, байгууллага, иргэдийн нэн тэргүүний ашиг сонирхлын асуудал бөгөөд хуульчдын ёс зүйд мэргэжлийн институтын оролцооноос гадна олон нийтийн хяналт зайлшгүй чухал юм. Олон нийт ч ийм байгаасай гэж хүсэж энэ зүгт анхаарлаа хандуулж байдаг.

Энэ утгаараа Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм, Прокурорын ёс зүйн дүрэм, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмээр шүүгч, прокурор, өмгөөлөгчид нийгмийн зүгээс тавигдах тусгай шаардлагыг хэм хэмжээчилсэн нь олон нийтэд ил тод байдаг бөгөөд ёс зүйн дүрмүүдийг зөрчсөн гэж үзсэн иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс эдгээр хуульчдын зохисгүй үйлдлийн талаар гомдол, мэдээлэл, хүсэлтээ гаргах эрх нь нээлттэй, гомдол, мэдээлэл, хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах журам, уг ажиллагааг явуулах байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож өгсөн нь хуульчдын ёс зүйд хяналт тавих боломжийг олгож байгаа.

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд шүүгчдээс гадна иргэд, бусад байгууллагын төлөөлөл багтдаг. Прокурорын ёс зүйн зөвлөлдэн прокуроруудаас бүрдэхээр журамлагдсан байгаа ч прокурорын ёс зүйн зөрчлийн талаар гомдол, мэдээлэл, хүсэлтээ гаргах эрх нээлттэй байгаа нь прокуроруудын ёс зүйн хяналт тавихад иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог хангасан явдал юм.

МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭШЛИЙН ИНСТИТУТЫН ХЯНАЛТ, ҮР НӨЛӨӨ, АЧ ХОЛБОГДОЛ

Ёс зүйтэй холбоотой шүүхийн алдааны эх үүсвэрийг судлан, шүүхийн шийдвэрт шинжилгээ хийхэд шүүгчийн ёс зүйн алдаа ямагт тодорхой хувь эзэлж байгаа, мөн НҮБ - ын Ерөнхий Ассамблейн 1996 оны 51/59 - р тогтоолын хавсралт “Төрийн албан тушаалтны ёс зүйн Олон улсын дүрэм”, 2003 оны 58/4 тоот тогтоолоор баталсан “Авилгын эсрэг НҮБ-ын Конвенц”, 1979 оны 34/169 - р тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль” зэрэг олон хууль, дүрэм байх ба “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль” - ийн “ёс зүйн зөрчилтэй эвлэрэхгүй байх, илрүүлэн арилгах ёстой” - г тогтоож өгсөн. Эдгээр чухал ач холбогдолтой заалтууд одоогийн байдлаар манай Улсын цагдаа, шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйн дүрэмд нарийвчлан тусгагдаагүй...” гэж дүгнэгдэж байсан үеийн **нөхцөл байдал өнөөдөр ч хэвээр байгаа.** Шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн ёс зүйн байдалд олон нийт, иргэдээс гадна **мэргэжлийн байгууллагын ёс зүйн хяналт**, мөн шүүх, прокурор, өмгөөлөх байгууллагын дэргэд байгуулагдсан Шүүхийн сахилгын хороо, Прокурорын ёс зүйн зөвлөл, Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дарга, гишүүдийн тавих **мэргэшлийн ёс зүйн хяналт зайлшгүй чухал** юм. Ёс зүйн хэм хэмжээг нийгмийн харилцаа шинэчлэгдэхийн хэрээр байнга өөрчлөн сайжруулж байх шаардлагатай учраас **мэргэжлийн ёс зүйн хяналт нь хуульчийн ёс зүйн дадалд сурах, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг баримтлах хандлага төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.**



ШҮҮГЧ, ПРОКУРОРЫН БОЛОВСОН ХҮЧНИЙ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Хуульчийн ажлын үр дүнгээс тухайн хүний нэр төр, эрүүл мэнд, амь нас үндсэндээ хамаарч, энэ нь түүний хань ижил, үр хүүхдийн амьдралд тусгалаа олж, хуульч хүн ажилдаа хариуцлагагүй байж гаргасан алдаанаас бүхэл бүтэн гэр бүлийн хүмүүсийн амьдрал, хувь заяаны асуудал хөндөгдөх учраас хуульчийн **ёс суртахууны нийтлэг зарчмууд** “хуульч улс орон, ард түмэндээ хандах, хуульчид өөр хоорондоо харилцах, иргэдтэй харилцах, өөртэйгээ харилцахад илэрдэг”, **хуульчийн ёс суртахууны үүрэг** нь “эрх зүй, хууль ёсонд үйлчилж, хүчин зүтгэх, ажил хэрэгчээр хамтран ажиллах, хүмүүст анхааралтай, соёлтой хандах, цэвэр ариун зан төлөвтэй байх” зэргийг санаж ажил үүргийн дагуу хүлээсэн үүргээ хуулийн дагуу шударга, хүнлэг зарчмыг дээдлэн цаг тухайд нь ухаалаг, хариуцлагатай биелүүлэх ёстой.

Хуульзүйн мэргэжил бол төрийн хэргийг хөтлөн явуулах, хууль хэрэгжүүлэх, төр иргэнийг эрх зүйн харилцаанд холбож өгөх, иргэд эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, нийгмийн дэг журам, зохион байгуулалтыг бэхжүүлэх, аливаа харш үзэгдэлтэй тэмцэх, нийгэм төр, хүнийг шударга ариун байлгахад үйлчилдэг мэргэжил бөгөөд төрийн нэрийн өмнөөс хууль хэрэглэн хүнийг яллах, цагаатгах, шийтгэх, эрх, эрх чөлөөг нь хязгаарлах албадлага хэрэглэх үүрэг гүйцэтгэхдээ гаргах шийдвэр нь хууль ёсны байлаа ч талууд ижил байдлаар хүлээн авдаггүй, өөрөөр хэлбэл, бүгдэд нэг ижил таалагддаггүй билээ.

Тэр тусмаа орон нутагт орон тоо нь цөөн байдгаас олны дунд танил болсон байдаг шүүгч, прокурор, өмгөөлөгч үүрэгт ажлаа гүйцэтгэх явцдаа болон нийгмийн бусад харилцаанд оролцоходоо ёс зүй, ёс суртахууны зөрчил гаргах, аливаа асуудалд шударга бусаар хандах явдал нь нийт хуульчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг, цаашлаад хуулиа дээдлэн мөрдөхгүй, шүүхийн шударга шийдвэрийг үл хүндэтгэх сөрөг хандлагыг бий болгодог учир шүүгч, прокурор нэг нутаг оронд хэтэрхий удаан суурьшин үйл ажиллагаа явуулах нь төдийлөн зохимжтой бус байдаг. Энэ нь хуульчдын үйл ажиллагааны цөм болдог “хүн” - ий эерэг, сөрөг янз бүрийн араншинтай холбоотой учир нэг газар томилогдон ажилласнаас хойш тодорхой хугацааны дараа шүүгч, прокурорыг мэргэжлийнх нь дагуу өөр орон нутаг, байгууллагад шилжүүлэн ажиллуулах зохицуулалт хийгддэг байна.

ХЯНАЛТЫН ХҮРЭЭ, ХЯЗГААР

Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйд тавих хяналтын хүрээг шүүх, прокурор, өмгөөллийн байгууллагын ёс зүйн хяналтыг Улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Сахилгын хороод, Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмуудад хэрхэн тусгасныг авч үзвэл:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 192 - р зарлигаар 2007 оны 8 дугаар сарын 03 ны өдөр батлагдсан Монгол Улсын “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” - д **Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн байдалд 15 гишүүний бүрэлдэхүүнтэй Шүүхийн сахилгын хороо хяналт тавьж ажиллах**, бүх шатны шүүхийн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороо Улсын хэмжээнд нэг байх талаар, мөн шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэх, хэлэлцээд гаргасан шийдвэрт гомдол гаргах журам, сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны талаар тусгасан байдаг.

Шүүгчид “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм” - д нь тусгалаа олсон байдлаар нь “шүүгчийн биеэ авч явах ёс зүйн хэм хэмжээ, шүүн таслах ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, шүүн таслах ажиллагаанаас гадуур мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээ, улс төрийн үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөний үед баримтлах ёс зүйн хэм хэмжээ” гэж ангилж болох ёс зүйн олон шаардлагыг шүүгч зөрчсөн эсэх, өөрөөр хэлбэл Сахилгын хорооны дүрэмд “**шүүгч ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг Сахилгын хорооноос өөр байгууллага, албан тушаалтан шалгаж шийдвэрлэхийг хориглоно**”(1.8.) гэж зааснаар **хяналтын хүрээ ерөнхийдөө тодорхойлогдож байгаа** бол,

Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын нийтлэг үндэслэлд “**Прокурорын ёс зүйн зөвлөл** нь Монгол улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаалыг удирдлага болгон **улсын хэмжээнд үйл ажиллагаагаа нэгдмэл байдлаар явуулна**, Прокурорын ёс зүйн зөвлөл нь прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шалгалт явуулж, дүгнэлт гаргана” гэж заасан ба Прокурорын ёс зүйн дүрмээр прокурорт тавигддаг ёс зүйн шаардлагуудыг “прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн хэм хэмжээ, прокурорын хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн хүрээнд баримтлах ёс зүйн хэм хэмжээ прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдвэрлэх” гэж ангилж байгаагаас үзэхэд “**прокурорын ёс зүйн хяналтын хүрээ** нь прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн



хэм хэмжээ, прокурорын хяналтын чиг үүргээс гадуур нийгмийн хүрээнд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэрхэн мөрдөж байгаа, прокурор хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад гарах ашиг сонирхлын зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэж байдалд тавих байдлаар тодорхойлогдоно” гэж үзэж байна.

Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны ажлын алба, түүний эрх, үүргийг Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрэм 14 дүгээр зүйлд тусгасан байна. Тухайлбал, Сахилгын хорооны ажлын алба нь гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, харьяаллын бус гомдол, хүсэлтийг Сахилгын хорооны дарга, гишүүнд танилцуулснаар буцаах буюу харьяаллын дагуу шилжүүлэх, Сахилгын хорооны дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулж Сахилгын хорооны анхны хуралдаанаас тогтоосон журмын дагуу Сахилгын хорооны аль нэг гишүүнд хуваарилах, Сахилгын хорооны ажилд техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэрэг, өргөдөл, гомдлын хөдөлгөөн, бүрдүүлэлтэд хяналт тавьж хадгалах, Сахилгын хорооны дарга, гишүүний даалгасан болон өөрийн санаачлагаар гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагаа явуулах, Сахилгын хорооны хэвийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангах, үйл ажиллагаа, шийдвэрийг баримтжуулах, Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон сахилгын хэргийг илтгэх гишүүнд шилжүүлж, Сахилгын хорооны хуралдааны товьг талуудад мэдэгдэх талаар, мөн Сахилгын хорооны үйл ажиллагааг ил тод, идэвхтэй шуурхай явуулах, үйл ажиллагаа явуулахдаа гадны ямар нэгэн нөлөөнд үл автан, гагцхүү дагаж мөрдөж байгаа хуульд дүрэмдээ захирагдан, хараат бусаар ажиллах, шаардлагатай зардлаар хангах боломжийг Монголын өмгөөлөгчдийн холбоо бүрдүүлж өгөх зохицуулалтыг Сахилгын хорооны дүрэм тусгасан байдлаас үзэхэд **өмгөөлөгчийн ёс зүйн хяналтад мөн Улсын хэмжээнд нэгдмэл байдлаар тавих зохицуулалт хийсэн нь харагдаж байна.**

Гэхдээ шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйн байдалд тавих хяналтыг зөвхөн “Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”, “Прокурорын ёс зүйн дүрэм”, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” - ийн хүрээнд тавих нь учир дутагдалтай билээ.

Учир нь нийгмийн харилцааг зохицуулагч хүчин зүйл болдгийн хувьд нийгмийн харилцаа өөрчлөгдөхийн хэрээр “зан үйлээр дамжин амьдрал ахуйд нэвтэрч, бүрэлдэн тогтсон хувь хүний зүгээс нийгэм болон олон түмэнтэй харилцах, тэдний өмнө хариуцлага хүлээх, биеэ авч явах зэрэг олон талын харилцааг зохицуулсан хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ” буюу нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын түвшин, амьдралын хэв маяг, нийгмийн үнэт зүйлс зэрэг олон хүчин зүйлээр тодорхойлогддог ёс суртахуун”, тодорхой мэргэжлийн хүрээнд тавигдах ёс зүйн тусгай шаардлага буюу “ёс зүй” нь өөрчлөн хувьсаж байдаг ч **нийгмийн бүх давхаргад нэг ижил агуулгатай ёс суртахуун үйлчлэх нь маш чухал юм.**

Хуульч хүн өөрийн ажлыг хуулийн дагуу ёс зүйн дүрэмдээ захирагдан явуулах ёстой ч бүрэн төгс боловсрогдсон ёс зүйн дүрэм гэж үгүй тул **ёс зүйн дүрмүүдийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж**, нийгмийн олон талт харилцаан дахь хүний эрх, эрх чөлөөний баталгааг улам бүр бэхжүүлж байх нь зүйтэй.

Ардчилсан, эрх зүйт төрт ёстой улсад хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах хэрэгжүүлэхэд мэргэшсэн хуульчид нь хараат бус бие даасан, **шударга байх хариуцлагаа ухамсарласан байх ёстой учир шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйд тавих хяналтын хүрээнд** тэдний зүгээс мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахдаа мэргэшлийн ёс зүйн хэм хэмжээний шаардлагыг хэрхэн дагаж мөрдөж байгаагаас гадна шүүгч, прокурор, өмгөөлөгчийн **мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад төрлийн нийгмийн харилцаанд биеэ хэрхэн авч яваа байдал мөн хамаарах учир** хуульчид мэргэжлийн хүрээнд явуулах үйл ажиллагаагаа, өөрийн хувийн сонирхлоос зааглаж, хуулийг хэрэглэх эрх мэдлийнхээ хүрээнд хүний эрхийг хамгаалан хангах үүргийг нийгмийн өмнө хүлээж, тэрхүү мэргэжлийнхээ хувьд өндөр хариуцлагатай байх, **хувь хүнийхээ зан байдлыг хатуу хянах үүрэг ноогддог нь ёс зүйн хувьд тавигдах шаардлагаар мөн хангагддаг.**

Хариуцлагатай байх нь хуульчийн хараат бус байдлын тулгын чулуу бөгөөд хариуцлагаа ухамсарласан хуульч өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг тул өөртөө хариуцлагын дархлаа бий болгохын тулд “мэргэжилдээ сайн байхын зэрэгцээ ёс суртахууны хувьд төлөвшсөн, ажил, амьдрал, нийгэмд байр сууриа олж тогтворжсон байх явдал зайлшгүй чухал гэдгийг санаж”, “төрт ёсыг бэхжүүлэх, хуулийг хэрэгжүүлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, иргэдийн эрх зүйн мэдлэг, хүмүүжлийг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үйлчилгээ үзүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хангах” үүргээ гүнээ ухамсарлан хичээх ёстой.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Хуульчийн ёс зүйд хяналт тавих хэрэгтэй юу?
- Хяналтыг хэн хэрэгжүүлэх ёстой вэ?
- Олон нийт хуульчийн ёс зүйд хэрхэн хяналт тавих боломжтой вэ?
- Хяналт мэргэшсэн байх шаардлагатай юу?
- Мэргэшлийн хяналтыг ямар институтууд хэрэгжүүлэх нь зохистой вэ? хувилбар дэвшүүлж хэлэлцэнэ үү
- Р. Паунд ёс зүйн хяналтын хүрээнд ямар шинэчлэл хийсэн бэ?
- Хяналтын хүрээ хязгаар хаана төгсдөг вэ?
- Хяналт тавьж болохгүй үйл ажиллагаа бий юу?



4.3. ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ АЖИЛЛАГАА

Сэдвийн зорилго: *Хуульчийн ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээлгэх ажиллагааны тухай ойлголт, хэрэгжүүлэх үе шат, институт, эрх хэмжээ, гомдол гаргах талаар цэгцтэй мэдлэг эзэмших, ёс зүйн зөрчлөөс өөрийгөө сэргийлэх, тэргээжлийн ёс зүйн хэм хэмжээг бафилтлах, тэргээжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвших, хуульчийн ёс зүйн дадалд сурахад оршино.*

НЭРТОМЬЁО:

- Сахилгын хэрэг
- Ажиллагаа
- Сахилгын хороо
- Гишүүн
- Бүрэн эрх
- Шийдвэр
- Гомдол

ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Ёс зүйн хариуцлага хүлээлгэх ажиллагаа нь шүүгч, прокурор, өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг шийдвэрлэх ажиллагаа юм.

Сахилгын хариуцлага хүлээлгэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8 дугаар сарын 03 ны өдрийн 192 тоот Зарлигаар баталсан “Шүүхийн сахилгын хорооны дүрэм”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 263 тоот Зарлигийн 1-р хавсралтаар баталсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” Монголын өмгөөлөгчдийн холбооны ээлжит XII их хурлаар хэлэлцэн баталсан “Монголын өмгөөлөгчийн холбооны сахилгын хорооны дүрэм” - ээр тус тус зохицуулсан байна. Тухайлбал,

Шүүгч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх талаар Монгол Улсын дээд шүүхийн дэргэд шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий Шүүхийн сахилгын хороо байх бөгөөд уг хороо үйл ажиллагаагаа Улсын хэмжээнд нэгдмэл байдлаар явуулна.

Сахилгын хорооны үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8-р сарын 03 ны өдрийн 192 тоот Зарлигаар баталсан “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” - ээр зохицуулна.

Прокурорт сахилгын шийтгэл оногдуулах нэг үндэслэл нь тэрээр прокурорын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн явдал болох бөгөөд прокурор ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг шалган тогтоох ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд 2007 оны 8 дугаар сарын 14 ны өдрийн хуулиар нэмсэн 421 дүгээр зүйлд заасан “Прокурорын ёс зүйн зөвлөл” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 263 тоот Зарлигийн 1-р хавсралтаар

баталсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” - ын дагуу хийж гүйцэтгэнэ.

Өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг шалгах, өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг сахиулах явдлыг Монгол Улсын өмгөөллийн тухай хууль, Монголын өмгөөлөгчдийн холбооны дүрэм болон Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмээр тогтоосон иж бүрэн арга хэмжээгээр баталгаажуулна. Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн дүрмийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд өмгөөлөгчид сахилгын хариуцлага хүлээлгэх ба сахилгын шийтгэлийг Монголын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч, Сахилгын хороо, өмгөөлөгчдийн эрх хасахаас бусад шийтгэлийг аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн Зөвлөлийн дарга оногдуулах ба уг ажиллагааг Монголын өмгөөлөгчдийн холбооны ээлжит XII их хурлаар хэлэлцэн баталсан “Монголын өмгөөлөгчийн холбооны сахилгын хорооны дүрэм” - ээр тус тус зохицуулсан байдаг. Тухайлбал, Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрэмд сахилгын хэрэг үүсгэх үндэслэл, хэргийг хянан шийдвэрлэх харьяалал, гомдол, хүсэлтийг хүлээн авах харьяалал, хэргийн оролцогчдын иргэний эрх зүйн чадвар, иргэний эрх зүйн чадамж, сахилгын хорооны хурлыг хаалттай, нээлттэй явуулах журам, сахилгын хорооны хуралдааныг тасралтгүй явуулах, хууль, дүрэм, ёс зүйн хэм хэмжээг хэрэглэх, сахилгын хорооны шийдвэр заавал биелэгдэх гэх мэт асуудлыг тусгасан байна.

Сахилгын хэрэг, түүнийг үүсгэх үндэслэл

Шүүгч, прокурор, өмгөөлөгч ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчих нь түүнд сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болох бөгөөд сахилгын хэргийг хэн, хэрхэн үүсгэх энэ талаар холбогдох дүрмүүдэд дараах байдлаар тусгагджээ. Үүнд:

Шүүхийн сахилгын хорооны дүрмийн Хоёр дахь хэсэгт: “2.1. шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчээс ирүүлсэн хүсэлтийг Сахилгын хорооны ажлын алба хүлээн авна.” гэсэн бол,

Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын дөрөвдүгээрт: “4.1. Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн прокурорын газруудаас ирүүлсэн хүсэлтийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч, Зөвлөлийн даргад танилцуулна” гэж,

Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрмийн 19 дүгээр зүйлд “Гомдол, хүсэлтийг гаргах, хүлээн авах харьяалал” - ын талаар тус тус тусгасан байна.



ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ИНСТИТУТ: САХИЛГЫН ХОРОО, ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

Ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх эрх зүйн орчин, тогтолцооны тухайд авч үзвэл ёс зүйн зөрчлийг хуулийн байгууллага бүр өөр өөрийн салбар дахь Сахилгын хороо, Ёс зүйн зөвлөл гэх мэт байгууллагуудаар хянан шийдвэрлүүлдэг. Тухайлбал,

Шүүгч, прокурор, өмгөөлөгчийн гаргасан сахилгын зөрчлийг хянан шалгаж, хариуцлага хүлээлгэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 8 дугаар сарын 03 - ны өдрийн 192 тоот Зарлигаар баталсан “Шүүхийн сахилгын хорооны дүрэм”, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 263 тоот Зарлигийн 1 -р хавсралтаар баталсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” Монголын өмгөөлөгчдийн холбооны XII их хурлаар хэлэлцэн баталсан “Монголын өмгөөлөгчийн холбооны сахилгын хорооны дүрэм” - ээр зохицуулсан.

Монгол улсын **Шүүхийн сахилгын хорооны дүрэмд** “Шүүхийн сахилгын хороо нь иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас шүүгчийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авч шалгах, сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус байгууллага, Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, холбогдох бусад хууль, Шүүхийн сахилгын хорооны дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа улсын хэмжээнд нэгдмэл байдлаар явуулна”,

“Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” - д “Прокурорын ёс зүйн зөвлөл нь прокуророос ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, сахилгын хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн”,

Монголын өмгөөлөгчдийн холбооны “Сахилгын хорооны дүрэм” - д “энэ дүрмийн зорилт нь иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагаас өмгөөлөгчдийн мэргэжлийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх үүрэг бүхий Монголын өмгөөлөгчдийн холбооны дэргэдэх Сахилгын хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, Сахилгын хорооны гишүүний хараат бус, Сахилгын хорооны бие даасан байдлыг хангах болон Сахилгын хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”, “Монголын өмгөөлөгчдийн холбооны сахилгын хороо” нь өмгөөлөгчийн сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, хууль, өмгөөлөгчдийн ёс зүйн хэм хэмжээ болон бусад дүрэм, журмыг зөрчсөн өмгөөлөгчид сахилгын шийтгэл оногуулах асуудлыг шийдвэрлэх Их хурлын байгууллага мөн” гэж тус тус эрх зүйн байдлыг нь тодорхойлсон байна.

ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ИНСТИТУТЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 192 - р зарлигаар 2007 оны 8 - р сарын 03 ны өдөр батлагдсан Монгол Улсын “Шүүхийн сахилгын хорооны дүрэм” - д шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэх, хэлэлцээд гаргасан шийдвэрт гомдол гаргах журам, сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны талаар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 148 - р зарлигийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” - д сахилгын зөрчил гаргасан прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл, түүнийг шалгах, шийтгэлийг оногдуулах, хөөн хэлэлцэх хугацаа, шийтгэлийг арилгах тухай, Монголын өмгөөлөгчдийн холбооны “Сахилгын хорооны дүрэм” - ээр өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргасан эсэх, шүүгч ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд сахилгын хэрэг үүсгэх, хэргийг хэлэлцээд шийдвэр гаргах, гаргасан шийдвэрт гомдол гаргах журам, Сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагааны талаар заасан.

Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн сахилгын хороо Улсын ерөнхий прокурорын газрын удирдах зөвлөлөөс 2, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлөөс тус бүр 2, НИТөлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хуралдаанаас 5 хүн, бүх шатны шүүхээс тус бүр 2, нийт 6 шүүгч хүн нэр дэвшүүлэн батлуулсан 15 хүний бүрэлдэхүүнтэй Шүүхийн Сахилгын хорооны хуралдааны хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилсноос хойш 14 хоногийн дотор Сахилгын хорооны даргад хорооны гишүүд дотроосоо нэр дэвшүүлж, хуралдаанаараа хэлэлцэн нууцаар санал хурааж, олохийн санал авсан хүнийг томилуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Хуралдааныг Сахилгын хорооны хамгийн ахмад гишүүн удирдан явуулна. Хэрэв Монгол Улсын Ерөнхийлөгч Сахилгын хорооны даргад нэр дэвшүүлсэн хүнийг томилоогүй бол Сахилгын хороо өөр хүнийг нэрийг дэвшүүлнэ.

Шүүхийн сахилгын хорооны хуралдаан:

- Сахилгын хорооны анхан шатны хуралдаан нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй;
- Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдаан нь нийт гишүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй байна.

Шүүхийн сахилгын хороо Улсын хэмжээнд нэг байх бөгөөд ажлын алба нь өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх, Сахилгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангах, хянан шалгагч нар зохих шалгах ажиллагаа гүйцэтгэх болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Шүүхийн сахилгын хорооны ажлын алба нь орон тооны байх бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдана. Орон тоог нь Шүүхийн ерөнхий зөвлөл тогтоох уг ажлын алба Сахилгын хорооны өдөр тутмын тасралтгүй хэвийн ажиллагааг хангана.

Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журмын нийтлэг үндэслэлд “Прокурорын ёс зүйн зөвлөл нь Монгол улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль, Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаалыг удирдлага болгон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа нэгдмэл байдлаар явуулна.

Улсын Ерөнхий прокурор нь Ёс зүйн зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшигчийг Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 - р зүйлийн 42.5 -д заасныг үндэслэн Монгол Улсын ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал Прокурорын байгууллагын тухай хууль, энэ дүрэмд заасан журмын дагуу нэр дэвшүүлж нөхөн томилуулна.

Прокурорын ёс зүйн зөвлөл нь дарга, гишүүд гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн дарга нь Улсын Ерөнхий прокурорын орлогч байх бөгөөд түүний эзгүйд Зөвлөлийн даргаас эрх олгосон гишүүн Зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын ерөнхийлөгч батална. Гишүүн нь мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлагатай ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, 5 - аас доошгүй жил ажилласан прокуроруудаас бүрдэнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь прокурор байна.

Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрэм (12 дугаар зүйл) “Сахилгын хороог Өмгөөллийн тухай Монгол Улсын хуульд заасан үндэслэл журмаар сонгож байгуулна. Сахилгын хорооны гишүүнд мэргэжил, арга зүйн хувьд туршлагатай, нэр хүнд бүхий өмгөөлөгчийг нэр Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрмийн дэвшүүлж, МӨХолбооны Их хурлын төлөөлөгчдөөс хамгийн олон санал авсан төлөөлөгчийг сонгоно. Их хурлаас сонгогдсон Сахилгын хорооны гишүүдийн дундаас нэр дэвшүүлж, тэдний олонхийн санал авсан гишүүнийг Сахилгын хорооны даргаар сонгон, МӨХолбооны Их хурал батламжилна. Сахилгын хорооны гишүүний 2 - оос доошгүй нь болон Сахилгын хорооны дарга орон гарсан тохиолдолд Удирдах зөвлөл Сахилгын хорооны гишүүдийг болон Сахилгын хорооны даргыг нөхөж сонгож болно. Сахилгын хорооны дарга болон гишүүнийг нөхөн сонгох тохиолдолд энэ дүрмийн 12.4 -т заасан журмыг баримтална. Сахилгын хорооны бүрэн эрх нь дараагийн Сахилгын хорооны бүрэн эрх баталгаажсанаар дуусгавар болно.

Сахилгын хорооны ажлын алба, түүний эрх, үүргийг Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрэм 14 дүгээр зүйлд тусгасан байна. Тухайлбал, ажлын алба нь гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх,

харьяаллын бус гомдол, хүсэлтийг Сахилгын хорооны дарга, гишүүнд танилцуулснаар буцаах буюу харьяаллын дагуу шилжүүлэх, Сахилгын хорооны дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулж Сахилгын хорооны анхны хуралдаанаас тогтоосон журмын дагуу Сахилгын хорооны аль нэг гишүүнд хуваарилах, Сахилгын хорооны ажилд техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэрэг, өргөдөл, гомдлын хөдөлгөөн, бүрдүүлэлтэд хяналт тавьж хадгалах, Сахилгын хорооны дарга, гишүүний даалгасан болон өөрийн санаачлагаар гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагаа явуулах, Сахилгын хорооны хэвийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангах, үйл ажиллагаа, шийдвэрийг баримтжуулах, Сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон сахилгын хэргийг илтгэх гишүүнд шилжүүлж, Сахилгын хорооны хуралдааны товыг талуудад мэдэгдэх гэх мэтчилэн заасан ба уг Дүрмийн 15, 16 - р зүйлд Сахилгын хорооны зардал болон нөхөн төлөгдөх зардлын асуудлуудыг тусгасан байна.

Сахилгын хорооны үйл ажиллагааг ил тод, идэвхтэй шуурхай явуулах, үйл ажиллагаа явуулахдаа гадны ямар нэгэн нөлөөнд үл автан, гагцхүү дагаж мөрдөж байгаа хуульд дүрэмдээ захирагдан, хараат бусаар ажиллах, шаардлагатай зардлаар хангах боломжийг Монголын өмгөөлөгчдийн холбоо бүрдүүлж өгөх зохицуулалтыг Сахилгын хорооны дүрэмд тусгасан байна.

ИНСТИТУТЫН ЭРХ ХЭМЖЭЭ, БҮРЭН ЭРХ

Шүүхийн сахилгын хорооний дарга, гишүүн Шүүхийн тухай хуульд заасан бүрэн эрхээс гадна гомдол хүсэлтийг биечлэн шалгах, Сахилгын хорооны даргыг томилсноор сахилгын хэргийг хянан хэлэлцэх хуралдааныг даргалах эрхийг эдэлнэ.

Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг Сахилгын хорооноос өөр байгууллага, албан тушаалтан шалгаж шийдвэрлэхийг хориглоно. (дүрмийн 1.8.)

Прокурорын ёс зүйн зөвлөл нь прокурорын үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шалгалт явуулж, дүгнэлт гаргана.

Зөвлөлийн дарга нь гишүүний эрхээс гадна дараах бүрэн эрхийг эдэлнэ:

- Гомдол, хүсэлт хүлээн авч биечлэн шалгах,
- Гомдол, хүсэлтийг харьяаллын дагуу өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх,
- Прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгах гишүүн, ажлын хэсгийг томилох,
- Шалгалтын материалтай урьдчилан танилцаж, нэмэлт шалгалт хийлгүүлэхээр буцаах,



- Шалгалтын дүнг зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэх,
- Шалгасан материалыг харьяаллын дагуу шилжүүлэх,
- Зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хуралдааныг удирдах,
- Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаас гаргасан дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулах.

Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

- Прокурорын ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгах,
- Зөвлөлийн гишүүний үүрэгт ажилтай нь холбогдож өөрт нь илэрхий болсон, эсвэл итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах,
- Зөвлөлийн хуралдаанд тухайн прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар санал хэлэх,
- Зөвлөлийн даргын томилсноор Зөвлөлийн хуралдааныг даргалах.

Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүрэг хүлээнэ:

- Зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах,
- Тэмдэглэл хөтлөх,
- Шалгалтын материалыг эмхэлж архивын нэгж болгох,
- Бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах үндэслэл байвал гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.

- Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол,
- Тухайн прокурортой, эсвэл гомдол, хүсэлт гаргасан этгээдийн гэр бүлийн гишүүдтэй төрөл садан бол,
- Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байвал.

МӨХолбооны Сахилгын хорооны дарга, гишүүний бүрэн эрх (13 дугаар зүйл): Сахилгын хорооны гишүүн дараах эрхтэй:

- Гомдол хүсэлтийн дагуу өмгөөлөгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах,
- Сахилгын хорооны даргын томилсноор Сахилгын хорооны хуралдааныг даргалах, хуралдаанд таслах эрхтэйгээр оролцох,
- Өөрийн санаачлагаар гомдол, хүсэлтэд нэмэлт ажиллагаа явуулахыг аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн даргад болон ажлын албанд даалгах,
- Сахилгын хэрэг үүсгэгдсэн өмгөөлөгч, холбогдох албан тушаалтан, иргэнээс тайлбар, тодорхойлолт гаргуулан авахыг ажлын албанд даалгах,
- Сахилгын хэргийг шалгахад шаардлагатай бичиг баримт сэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээр албан тушаалтан, иргэнээс гаргуулан авах, танилцах,

Сахилгын хорооны дарга нь Сахилгын хорооны 13 дугаар зүйлд заасан дээрх эрхээс гадна дараах эрхтэй. Үүнд:

- Сахилгын хорооны үйл ажиллагааг зохион байгуулан удирдах,
- Сахилгын хорооны хуралдааныг даргалах,
- Сахилгын хорооны хуралдааныг даргалах гишүүнийг томилох,
- Сахилгын хорооны үйл ажиллагаатай холбоотой бодлогын асуудлаар Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлд санал оруулах,
- Сахилгын хорооны ажлын албыг удирдлагаар хангах,
- ХМХэрэгслээр тараагдсан өмгөөлөгчийн ёс зүй, өмгөөлөгч, өмгөөллийн байгууллагын нэр хүндэд халдсан мэдээ, баримт, сэлтийг өөрийн санаачлагаар шалгаж, үр дүнг МӨХолбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлд танилцуулах. Шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлэх,
- Сахилгын хорооны дотоод үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг удирдах зөвлөлөөр батлуулахаар санал оруулах,

ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Шүүхийн сахилгын хорооны дүрмийн Хоёрдугаар хэсэгт “Сахилгын хэрэг үүсгүүлэх тухай гомдол, хүсэлтийг хүлээн авах, шалгах, шалгах хугацаа, мөн сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах” харилцааг зохицуулсан бол Гуравдугаар хэсэгт “Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх журмыг, Дөрөвдүгээр хэсэгт “Сахилгын хорооны шийдвэрт гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх” асуудлыг, Тавдугаар хэсэгт Сахилгын хорооны ажлын албаны үйл ажиллагаа, эрх, үүргийг тусгажээ. Тухайлбал, Дүрмийн 2.1 -д : “шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн бүх шатны шүүхийн ерөнхий шүүгчээс ирүүлсэн хүсэлтийг Сахилгын хорооны ажлын алба хүлээн авна. 2.2. Ажлын алба нь гомдол, хүсэлтийг бүртгэн Сахилгын хорооны дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулна...” гэх мэтчилэн нарийн журамласан.

Прокурор ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд зөрчилтэй холбоотой асуудлыг “Прокурорын сахилгын дүрэм” - д заасан журмаар хянан шийдвэрлэх ба “гомдол хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа” -г дүрмийн Дөрөв дэх хэсэгт нарийвчлан тусгажээ. Тухайлбал, 4.1 - д “Прокурорын ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн прокурорын газруудаас ирүүлсэн хүсэлтийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авч зөвлөлийн даргад танилцуулна”, 4.2-т “Зөвлөлийн дарга тухайн гомдол хүсэлтийг хүлээн авч гишүүдэд танилцуулна”, 4.3-т “Зөвлөлийн гишүүн гомдол хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шалгана. Хэрэв нэмэлт ажиллагаа хийх шаардлагатай



тохиолдолд зөвлөлийн дарга хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгана” гэх мэтчилэн зохицуулсан байна. Тухайлбал, “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” (4.6) - д зааснаар “Прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгах аар томилогдсон ёс зүйн зөвлөлийн гишүүн шалгалтыг явуулахдаа албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нотлох баримт шаардан гаргуулах, тайлбар авах, хавтаст хэргээс хуулбар хийх, шалгалтын материалыг тухайн прокурорт танилцуулж тэмдэглэл үйлдэх, хариу тайлбар авах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ. Дээрх ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн гишүүн (ажлын хэсэг) шалгалтын дүнгийн талаар Зөвлөлд танилцуулга бичиж, хуралдаанд илтгэнэ. Зөвлөл нь прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлыг анхан шатны журмаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хэлэлцэнэ. Зөвлөлийн дарга 3 гишүүнийг томилох ба хуралдаан даргалагчийг мөн дээрх гишүүдээс томилно.

Монголын өмгөөлөгчдийн холбооны Сахилгын хорооны дүрэмд “Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх журам”, “гомдол, хүсэлт гаргах, түүнийг хүлээн авах”, “гомдол, хүсэлтийн хэлбэр”, “гомдол, хүсэлтийн бүрдүүлбэр” ямар байх, “Сахилгын хороо гомдол, хүсэлтийг хүлээн авах, хүлээн авахаас татгалзах, хэрэг үүсгэх, үүсгэсний дараа хийгдэх ажиллагаа”, “гомдол, хүсэлтийн хэд хэдэн шаардлагыг нэгтгэх, тусгаарлах”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа”, гомдол, хүсэлтийг өмгөөлөгчид гардуулах” харилцааг тусгасан бол Долдугаар бүлэгт “Сахилгын хорооны хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа”, “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх” асуудлыг тусгажээ.

Мөн дүрмийн “Хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, Сахилгын хорооны хуралдааны оролцогч, хуралдааны нийтлэг журам” гэсэн 8-р бүлэгт “сахилгын хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн, сахилгын хорооны хуралдааны оролцогч, сахилгын хорооны хуралдааны нарийн бичгийн дарга, сахилгын хорооны хуралдаандаргалагч, түүний эрх, үүрэг, сахилгын хорооны хуралдааны нийтлэг журам, татгалзан гаргах үндэслэл, татгалзан гаргах хүсэлт гаргах, гишүүнийг татгалзан гаргасны үр дагавар, шийдвэрийг зөвлөлдөх тасалгаанд гаргах, санал хураах, сахилгын хорооны хуралдааны тэмдэглэл хөтлөх” асуудлыг нарийн зохицуулсан ба “Сахилгын хорооны хуралдааны дэг” - ийн тухай дүрмийн 9 - р бүлэгт “сахилгын хорооны хуралдааныг нээх, хуралдааны ирц, түүнд оролцох эрхийг шалгах, оролцогчид Сахилгын хорооны хуралдаанд ирээгүйгээс гарах үр дагавар, хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг зарлах, татгалзан гарах эрхийг тайлбарлах, хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах наймдугаар бүлэгт, хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх, хэрэг хэлэлцэж эхлэх, хэргийн оролцогч мэтгэлцэх, нотлох баримтыг шинжлэх, асуулт тавих дараалал, бичмэл болон эд мөрийн баримтыг шинжлэх, хэргийн оролцогчоос нэмж тодруулах, хэрэг хянан шийдвэрлэж буй бүрэлдэхүүн зөвлөлдөх” асуудлуудыг тусгажээ.

ШИЙДВЭРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Шүүхийн сахилгын хороо сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. (3.9)

- Сахилгын шийтгэл оногдуулах,
- Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох,
- Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан Сахилгын хорооны дарга, гишүүний захирамжийг хүчингүй болгож, дахин шалгуулахаар буцаах,
- Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллага албан тушаалтанд шилжүүлэх

Сахилгын хороо сахилгын зөрчил гаргасан тухай гомдлын дагуу сахилгын хэрэг үүсгэн шалгасан шалгалтын дүнг хянан хэлэлцээд гаргаж буй шийдвэр нь тогтоол хэлбэрээр гарах ба тогтоол нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна. (3.10)

“Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам” (4.6) - д зааснаар “Прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг шалгахаар томилогдсон ёс зүйн зөвлөлийн гишүүн шалгалтыг явуулахдаа албан тушаалтан, аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс нотлох баримт шаардан гаргуулах, тайлбар авах, хавтаст хэргээс хуулбар хийх, шалгалтын материалыг тухайн прокурорт танилцуулж тэмдэглэл үйлдэх, хариу тайлбар авах зэрэг ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ. Дээрх ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн гишүүн (ажлын хэсэг) шалгалтын дүнгийн талаар Зөвлөлд танилцуулга бичиж, хуралдаанд илтгэх ба анхан шатны журмаар 3 гишүүний оролцсон хуралдаанаар асуудлыг хэлэлцээд олонхийн саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Прокурор ёс зүй зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргана,
- Нэмэлт шалгалт хийлгэхээр буцаах,
- Холбогдох материалыг харьяаллаар шилжүүлэх.

Прокурорын ёс зүй зөрчсөн гэж гаргасан зөвлөлийн дүгнэлт нь сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно. Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж Улсын Ерөнхий прокурор сахилгын шийтгэл оногдуулна.

Өмгөөлөгчдийн холбооны Сахилгын дүрэмд (17.1): “Сахилгын хорооны дарга, гишүүн дор дурьдсан үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэж болно.

- Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан тухай иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллагаас гаргасан гомдол, хүсэлт,
- Өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн,
- Өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлүүлэхээр Холбооны ерөнхийлөгч, удирдах зөвлөлийн гишүүн, аймаг, нийслэлийн Зөвлөлийн дарга нараас ирүүлсэн хүсэлт,



- Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл” гэж тус тус тусгасан байна.

Өмгөөлөгч нь хуульч болон өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, шүүх, прокурор болон төрийн бусад байгууллагаас ирүүлсэн албан бичигт дурьдсан зүйл шалгалтаар нотлогдож байвал, мөн өмгөөлөгчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэдээс ирүүлсэн гомдол үндэслэлтэй байвал энэ нь түүнд холбогдуулан сахилгын хэрэг үүсгэх үндэслэл болно.

Өмгөөлөгч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд зөрчил нь ёс зүйн зөрчил мөн эсэхийг Сахилгын хороо тогтоодог. Ёс зүйн дүрмийн заалтыг ялимгүй зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээ авахгүйгээр урьдчилан сануулга өгөх журмыг тогтоожээ.

Аймаг, нийслэлийн өмгөөлөгчийн Зөвлөлийн дарга, сахилгын хороо, МӨХолбооны Ерөнхийлөгч нар нь сахилгын шийтгэлийг ноогдуулах эрхтэй. Үүнээс аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн Зөвлөлийн дарга нь сануулах, эрх хасахыг урьдчилан сануулах зэрэг арга хэмжээ авч болох бол эрх хасах арга хэмжээг Сахилгын зөвлөл болон Холбооны Ерөнхийлөгчийн санал болгосноор Хууль зүйн сайд ноогдуулна.

Сахилгын хороо сахилгын зөрчил гаргасан тухай гомдлын дагуу сахилгын хэрэг үүсгэн шалгасан шалгалтын дүнг хянан хэлэлцээд гаргаж буй шийдвэр нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсгээс бүрдэх тогтоол хэлбэрээр гарах ба танилцуулан сонсгомогц хүчинтэй болно.

Тогтоол гаргах үед дор дурьдсан асуудлыг шийдвэрлэнэ.

- Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх,
- Өмгөөлөгч мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргасан бол ямар хууль дүрэмд заасан ямар хэм хэмжээг зөрчсөн,
- Өмгөөлөгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлтэй эсэх,
- Өмгөөлөгчид ямар шийтгэл оногдуулбал зохих,
- Сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд гарсан зардлыг хэрхэн шийдвэрлэх,
- Гомдол, хүсэлт гаргагчид төлөх хөлсийг буцаан олгох үндэслэл байгаа эсэх.

Ингэхдээ өмгөөлөгч нь сахилгын зөрчил гаргасан нь тогтоогдвол зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах, Өмгөөллийн тухай Монгол Улсын хуулийн 23 -р зүйлийн 23.2.1 -д заасан Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай асуудлыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавина. Сахилгын хорооны хурлаар хэлэлцээд сахилгын хэрэг үүсгэсэн зөрчил нь батлагдаагүй гэж үзвэл сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгоно.

Тогтоол гаргаснаас бусад тохиолдолд “Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахтай холбоотой асуудал” - аар Сахилгын хороо тогтоол,

гишүүн захирамж гаргана. Тогтоолыг 3 - аас дээш бүрэлдэхүүнээр хэргийг хянан шийдвэрлэж байгаа үед, захирамжийг 1 гишүүн Сахилгын хорооны бус үед гаргана. (76 -р зүйл)

Сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх, мэдээлэх үндэслэл нь Сахилгын хорооны хуралдааны тогтоол болон тухайн тогтоол хүчин төгөлдөр болсон тухай Сахилгын хорооны ажлын алба аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлд болон шүүх, прокурор, холбогдох бусад байгууллагад хүргүүлсэн мэдэгдэл байна.

ГОМДОЛ ГАРГАХ ИНСТИТУТ БА ГОМДОЛ ГАРГАХ ХУГАЦАА

Шүүхийн сахилгын хороо сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэн гаргасан тогтоолыг тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээд эс зөвшөөрвөл Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанд давж заалдах гомдол гаргах эрхтэй. (4.1)

Ажлын алба давж заалдах гомдлыг хүлээн авч бүртгэх, Сахилгын хорооны даргад таницуулах, Сахилгын хорооны дарга гомдолтой танилцаад 15 хоногийн дотор нийт гишүүдийн хуралдааны тов зарлах, оролцогч болон гишүүдэд мэдэгдэх, хурлын ирц болон дэг, хурлаас гаргах магадлал, хурлын тэмдэглэл хөтлөх зэрэг асуудлууд Шүүхийн сахилгын хорооны дүрмийн 4.2 - 4.17 д заасан хэсэгт тус тус нарийн тусгагдсан байна.

Прокурор ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар Ёс зүйн зөвлөл анхан шатны журмаар гаргасан дүгнэлтийг прокурор, гомдол, хүсэлт гаргасан этгээд нь эс зөвшөөрвөл, мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор Зөвлөлийн даргад гомдол гаргаж болно. Дээрх хугацаанд гомдол гаргаагүй бол уг хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор хуралдаан даргалагч нь дүгнэлтийг Зөвлөлийн дарга, Улсын Ерөнхий прокурорт танилцуулна.

Гомдлыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Зөвлөлийн бүх гишүүдийн хураалдаанаар гишүүдийн 50 - иас доошгүй гишүүдийн ирцтэйгээр дахин хэлэлцэж дүгнэлт гаргах ба давж заалдах гомдлыг хэлэлцэж гаргасан Зөвлөлийн дүгнэлт нь эцсийнх байна.

Зөвлөлийн бүх гишүүдийн хуралдаанаас гаргасан дүгнэлтийг хураалдаан даргалагч Улсын Ерөнхий прокурорт 3 хоногийн дотор танилцуулна.

Монголын өмгөөлөгчдийн холбооны “Сахилгын хорооны дүрэм” - ийн 11 дүгээр бүлэгт “Сахилгын хорооны тогтоолд гомдол гаргах” асуудлыг тухайлан тусгасан байна. Тухайлбал, 77 -р зүйлд “Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд шууд болон Сахилгын хороогоор дамжуулан гомдол гаргаж болох” талаар, 78 -р зүйлд “гомдол гаргасан тохиолдолд өмгөөллийн үйл ажиллагаа



эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай шийдвэр гарах хүртэлх, тухайн шийдвэрт гомдол гаргасан бол уг гомдлыг шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд өмгөөлөгч үйл ажиллагаагаа явуулж болох тухай заасан байна.

Сахилгын хэргийг хянан шийдвэрлэж Дүрмийн 71 -р зүйлд (сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэж) зааснаар тогтоол гаргаснаас бусад тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар гарсан Сахилгын хорооны тогтоол, гишүүний Захирамжид гомдол гаргахгүй.

ХЯНАЛТЫН АСУУЛТ:

- Яагаад ёс зүйн хариуцлага хүлээлгэх процедур зайлшгүй вэ?
- Сахилгын хэргийг ямар үндэслэлээр үүсгэдэг вэ?
- Хариуцлагыг хэн оногдуулах вэ? Ямар бүтэцтэй байдаг вэ? Мэргэшил бүр дээр тайлбарлана уу.
- Хэргийг хянан шийдвэрлэхэд ямар зарчим, журмыг баримталдаг вэ?
- Хэргийг хянан шийдвэрлэхэд хугацаа ямар ач холбогдолтой вэ?
- Хэргийг буруу шийдвэрлэсэн гэж үзвэл хаана хандах вэ? Мэргэшил бүр дээр тайлбарлана уу.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ :

Үндсэн:

- К.Осакве. Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги. УБ., 2004
- Х.Тэмүүжин. *Ius frast* буюу ёст үг. УБ., 2000
- М.Батсуурь. Эрх зүйт ёс ба хуульчийн ёс зүй. Хууль дээдлэх ёс. УБ., 2006
- Цөөн хүний эрх мэдэл: Хуульчийн ёс зүй ба эрх чөлөөг сахин хамгаалахад түүний гүйцэтгэх үүрэг. ProEthics со. ХЗҮТ-д болсон лекц. УБ., 2004
- Т.Сэнгэдорж. Хуульчийн мэргэжил. УБ., 1997
- Хуульчийн ёс зүй. Хууль зүйн үндэсний төв. УБ., 2004
- Америкийн Барын холбооноос мэргэжлийн зан үйлийн дүрмийн оршил хэсэг болон танилцуулгаас. Орч-ХЗҮТ., УБ.,
- Т.Сэнгэдорж. Хуульчийн ёс зүй. УБ., 1998
- Д. Цогт-Очир. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 1999
- Ж.Маршал. Ёс зүйн соёлыг бий болгох аргачлал. Хуульчийн ёс зүй. ХЗҮТ. УБ., 2004
- Р.П.Вольф. Философийн тухайд. УБ
- А.С.Кобликов. Юридическая этика. М., 1999
- Ethics for Life.
- Х.Тэмүүжин. Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл. Хуульчийн ёс зүй. ХЗҮТ. УБ., 2004
- Ж.Маршал. Үнэт зүйлсийн ёс зүйн үйл ажиллагаа болгох. ХЗҮТ-д уншсан лекц. 2004-6-15
- Моригива Ясүтома. Хуульчийн ёс зүй. УБ., 2007
- Ж.Керригийн тоглосон “Худалч, худалч” хэмээх АНУ-ын кино.
- Д. Зүмбэрэллхам. Шүүгч, прокурорын ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд өмгөөлөгч хяналт тавих нь. ХЗҮТ -д уншсан лекц. 2004
- Д. Оросоо. Хуульчийн ёс зүй. Түүний талаарх олон нийтийн санаа бодол төлөвшихөд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үзүүлэх нөлөө. ХЗҮТ. УБ., 2004
- Б. Бат- эрдэнэ. Хуульчийн ёс зүй. Лекц. УБ., 2003
- Б. Пүрэвням. Өмгөөлөгчийн ёс зүйн үндсэн асуудал, өмгөөлөгчийн гаргаж буй ёс зүйн нийтлэг зөрчил. Хуульчийн ёс зүй. ХЗҮТ. УБ., 2004
- Б. Батцэрэн. Шүүгчийн ёс зүйн үндсэн асуудал. Шүүгчийн гаргаж буй ёс зүйн нийтлэг зөрчил. Хуульчийн ёс зүй. ХЗҮТ. УБ., 2004
- Н. Сосорбарам. Өмгөөлөгчийн гаргаж буй ёс зүйн нийтлэг зөрчил, түүнийг сахилгын хорооноос шийдвэрлэсэн байдал. ХЗҮТ
- Х.Тэмүүжин. Шүүх эрх мэдэлд прокурор хэн байх ёстой вэ ? *Ius frast* буюу Ёст үг. УБ., 2000.
- АНУ-ын Шүүгчдийн ёс зүйн дүрэм, ШЭЗШТөсөл,
- АНУ-ын захиргааны шүүгчдэд зориулсан ёс зүйн хэм хэмжээ. ХЗҮТ,



Ж.Наранцацралт, ОТИСургуулийн багш, “Ёс зүйн зөрчлийг хөндлөнгөөс хянадаг байгууллага хэрэгтэй байна”, “Өмгөөлөгч” сэтгүүл, УБ., 2007, □1,(07), “Хуульчийн ёс зүй ба мэтгэлцээн” лекц, МУ -ын ХЗҮТ, АНУ -ын шүүхүүдийн Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр 2005-11-18, илтгэгч АНУ-ын иргэн доктор Жак Маршалл,

Мэргэшлийн ёс зүйн дүрмүүд болон бусад эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм, Шүүхийн сахигын хорооны дүрэм, Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрэм, Прокурорын ёс зүйн зөвлөл, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмууд, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, МӨХолбооны сахилгын хорооны дүрэм, Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалын хавсралт, /Төрийн аудитын тухай хууль/, “Гаалийн улсын байцаагчийн сахилгын тусгай дүрэм”, /Гаалийн тухай хууль./, Эрүүл мэндийн тухай хууль, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль., “Улсын аюулгүй байдлыг хангах албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”, “Монгол улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”, /Шүүхийн тухай хууль./, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”, /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль/, “Прокурорын ёс зүйн дүрэм”, /Прокурорын тухай хууль/, “Монгол улсын татварын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”, “Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”, “Нийгмийн даатгалын байгууллагуудын ажилтнуудын ёс зүйн дүрэм”, “Монголын өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”, “Нотариатчийн ёс зүйн дүрэм”-үүд,

Нэмэлт:

Ronald D. Rotunda and John S. Dzienkowski. Legal Ethics: The Lawyer's desk-book on professional responsibility, 2005-2006 ed. (ABA)

Wolfram's Hornbook on Modern Legal Ethocs. 1986.

Лоуренс Фридмэн. Введение в Американское право. Универс, Прогресс. М., 1993

А.Э.Жалинский. Профессиональная деятельность юриста. Введение в специальность. Изд-во “Бек”. М., 1997

Ronald D. Rotunda and Mighael I. Krauss. Legal Ethics in a Nutshell. 2003

Deboran L. Rhode and David Luban. Legal Ethics, 4th (University Casebook Series □). 2004

Винсент Р.Жонсон. АНУ-ын Өмгөөлөгчдийн ёс зүйн шинэтгэл. ХЗҮТ, УБ., 2004, 5сар

Шигежи Ишигүро. Японы хуульчдын ёс зүйн тойм. Лекц, УБ., 2004. 5 сар

